



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



**ХУУЛЬ ЗҮЙН САЛБАРЫН
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ
ТӨСӨЛ**

ТАНЫ ХУУЛИЙН ХӨТӨЧ

**(ИРГЭДИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЛЭГТ ЗОРИУЛСАН
ХЯЛБАРШУУЛСАН ГАРЫН АВЛАГА)**

Улаанбаатар хот
2012 он

DDC
345'023
Д-14

Иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулсан хялбаршуулсан гарын авлага

Зохиогчид: Д. Баялагцэнгэл
А. Дугармаа
Ц. Давхарбаяр
Б. Урнаа
Ж. Оюунчимэг

Хянасан: Б. Урнаа
Ж. Оюунчимэг

Зөвлөх: У. Туяа (Ph.D)

ISBN 978-99962-894-6-0



мигмаПринт

Хэвлэсэн тоо: 5400 ширхэг
Цаасны хэмжээ: 70x100 1/16
Хэвлэлийн хуудас: 10.5 х.х

ГАРЧИГ

1. ЗАХИРГАА-ХУУЛЬ	7
2. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР-ХУУЛЬ	39
3. ГЭР БҮЛ-ХУУЛЬ	61
4. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-ХУУЛЬ	83
5. БИЗНЕС-ХУУЛЬ	107
6. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ-ХУУЛЬ	117
7. ИРГЭН-ХУУЛЬ	141
8. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ	163

ӨМНӨХ ҮГ

Бид нийгмийн харилцаанд оролцохдоо нэг талаас эрх эдэлж, нөгөө талаас бусдын өмнө үүрэг, хариуцлага хүлээж байдаг. Хэрвээ бид хууль, журмыг мэдэхгүйн улмаас бусдын эрх, эрх чөлөөг хөндөж, нийгмийн дэг журмыг зөрчвөл хуулийн дагуу хариуцлага хүлээдэг. Иймд өөрийнхөө эрхийг хамгаалах, хүлээсэн үүргээ биелүүлэх, нийгмийнхээ аюулгүй, амар тайван байдлыг хангахад хуулийн зохих мэдлэгтэй байх хэрэгцээ байнга тулгардаг.

“Таны хуулийн хөтөч” нь иргэдийн өдөр тутмын амьдралд түгээмэл тохиолддог асуудлыг хууль, эрх зүйн хүрээнд хэрхэн шийдвэрлэх талаар анхан шатны мэдлэг олгох зорилготой, иргэд нэн тэргүүнд мэдвэл зохих асуудлыг тусгасан, хялбаршуулсан гарын авлага юм. Тухайлбал, төрийн захиргааны байгууллагатай хуулийн хүрээнд харилцаж мэдээлэл олж авах, өргөдөл, гомдол гаргах, шүүхэд эрхээ хамгаалуулахаар хандах, газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэх, гэр бүлийн гишүүдийн эрх, үүрэг, хөдөлмөрийн гэрээ байгуулах, хувийн бизнесээ хөтлөн явуулах, иргэний гэрээ, хэлцэл байгуулах, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалд хамрагдах зэрэг олон асуудлын хууль зүйн зохицуулалтын талаар мэдэж авах болно.

Сэдэв тус бүрийн өмнөх Монгол ардын зүйр цэцэн үгсээс өвөг дээдсийнхээ хорвоо ертөнцийг үзэх үзэл бодол, танин мэдэхүйг, тэр дундаа төр, хууль цаазат ёс, журмаа хэрхэн дээдлэн хүндэтгэж, даган биелүүлдэг байсныг харж болно.

Хууль, дүрмээ сахин биелүүлдэг соёлтой, мэдлэгтэй ард түмэн нь эрх зүйт ёсыг дээдэлсэн хүмүүнлэг, ардчилсан нийгмийг эх орондоо цогцлоон хөгжүүлэхийн уг үндэс билээ.

I. ЗАХИРГАА-ХУУЛЬ

- 1. Иргэн ба захиргаа**
- 2. Миний мэдэх эрх**
- 3. Миний өргөдөл, гомдол гаргах эрх**
- 4. Захиргааны шийдвэрт гомдол гаргах эрх**
- 5. Захиргааны хэргийн шүүхэд хандах эрх**
- 6. Иргэн захиргааны зөрчил гаргавал эдлэх эрх**



Иргэд бид өдөр тутам газрын алба, иргэний бүртгэл, орон нутгийн засаг захиргаа, сургууль, цэцэрлэг зэрэг олон захиргааны байгууллагатай харилцаж байдаг. Ингэхдээ иргэд нь мэдээлэл олж авах, өргөдөл, гомдол гаргах, шүүхэд хандах зэрэг эрхийг нийтлэг эдэлдэг.

I. ЗАХИРГАА - ХУУЛЬ

1. Иргэн ба захиргаа

*Мөр амгалан бол
Мүмөн амгалан*

Төрийн үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хангаж, энэхүү үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй байх ёстой. Энэ зорилгоор шударга ёсонд нийцүүлэн хүний эрх зөрчигдөхөөс хамгаалан, хүний эрхийг баталгаажуулж хэрэгжүүлэх үүднээс Улсын Их Хурлаас бүх нийтээр дагаж мөрдөх хуулийг баталдаг.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Арван есдүгээр зүйл

1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

Хуулийг хэрэгжүүлэхэд тухайн салбараар дагнан мэргэшсэн захиргааны байгууллага шаардлагатай.

Хуулийг хэрэгжүүлэх, түүний биелэлтийг хянан шалгах, үнэлэх явцдаа хууль зөрчсөн иргэд болон байгууллага, аж ахуйн нэгжид хууль ёсны шаардлага гарган захирамжилдаг тул **захиргааны байгууллага** хэмээн нэрлэдэг. Жишээ нь: тодорхой хуульд заасан баримт бичиг, акт, захирамж, шийдвэр гаргах, торгууль, шийтгэвэр ногдуулах гэх мэт.

Захиргааны байгууллага нь босоо шаталсан чиг үүргээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, дээрээс доош шатлан захирагдаж, хууль, дээд шатны захиргааны байгууллагын шийдвэрт үндэслэн шийдвэр гаргаж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

Захиргааны байгууллага, албан тушаалтны **хамгийн нийтлэг үүрэг бол:**

1. хүний эрхийг хангах нөхцөл, баталгааг бүрдүүлэх;
2. хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэж, зөрчигдсөн эрхийг сэргээх;
3. иргэдээс гаргаж буй өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх юм.

Төрийн захиргааны байгууллага нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тухай бүртээ ялгаатай үүрэг хүлээсэн байдаг. Жишээ нь: баг, хорооны Засаг дарга нь хороо, багийнхаа өндөр настанг судлан бүртгэж, хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж олгуулах, хөнгөлөлт, үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авах, зохих тодорхойлолт гаргах, холбогдох баримт бичгийг бүрдүүлж холбогдох байгууллагад өгөх зэрэг үүргийг хүлээдэг.

Иргэн та захиргааны өмнө ямар эрх эдлэх вэ?

Иргэд захиргааны байгууллагатай чөлөөтэй, нээлттэй харилцаж, гаргах шийдвэрт нь саналаа тусгуулж, ямарваа шударга бус, хууль бус үйлдлээс хуулиар баталгаажсан эрхээ хамгаалуулах нь чухал. Нөгөө талаас захиргааны байгууллага ийм нөхцөлийг бүрдүүлэх ёстой.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Арван зургадугаар зүйлд:

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ

- эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;
- өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;
- эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй;
- сурч боловсрох эрхтэй;
- гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

- төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй;
- иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг хангах асуудлыг бусад хуулиар нарийвчлан зохицуулсан байдаг. Жишээлбэл, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн бүхий л төрлийн халамж үйлчилгээ үзүүлэх, иргэдийн өргөдөл, хүсэлтийн дагуу тэдэнд газар өмчлөлийн гэрчилгээг олгох, баталгаажуулах, аж ахуйн нэгж байгууллагыг нь бүртгэлд авч гэрчилгээ олгох гэх мэт төрийн үйлчилгээг Нийгмийн халамжийн тухай, Газрын тухай, Улсын бүртгэлийн тухай зэрэг олон хуулиар зохицуулдаг.

Иргэн эрхээ хамгаалах нь

Иргэд захиргааны байгууллагатай харилцахдаа тодорхой эрхийг эдэлж, түүнтэй холбоотой үүргийг хэрэгжүүлдэг. Захиргааны байгууллага ч иргэний эрхийг хангах холбогдох үүргийг хүлээж байдаг.

Иргэн	Захиргаа
Хүний эрх эрх чөлөө	Захиргааны шийдвэр, үйл ажиллагаа
Өргөдөл гомдол гаргах эрх	Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх үүрэг
Мэдэх эрх	Хүссэн мэдээллийг өгөх үүрэг

Иргэдийн хамгийн нийтлэг эрх:

1. Мэдэх эрх буюу мэдээлэлтэй байх эрх.
2. Өргөдөл, гомдол гаргах эрх буюу өөрийн өмнө тулгарч буй асуудлаа шийдвэрлүүлэхээр хандах эрх.
3. Захиргааны хэргийн шүүхэд хандаж эрхээ хамгаалуулах.

Эдгээр эрх нь Үндсэн хуулиар баталгаажуулсан бусад эрх, эрх чөлөөгөө бүрэн эдлэх боломжийг бүрдүүлдгийг анхаарах хэрэгтэй.



2. Миний мэдэх эрх

*Төр төмбөгөр
Ёс ёмбөгөр*

Мэдэх эрх буюу мэдээлэл олж авах, хүртэх эрх нь Үндсэн Хууль болон Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар баталгааждаг.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Арван зургадугаар зүйл

Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

17/ төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.

Иргэн яагаад мэдээлэл олж авах эрхтэй вэ?

Яагаад гэвэл бид төр нь иргэндээ үйлчилдэг ардчилсан нийгэмд амьдарч байна. Иргэд бид төрөө сонгож, төрөө санхүүжүүлдэг учраас **мэдэх эрхтэй** байдаг. Гэхдээ иргэдэд гагцхүү үнэн, бодитой, тэнцвэртэй мэдээлэл хэрэгтэй.

Мэдэх эрх гэж юу вэ?

Энэ нь иргэний мэдээлэлтэй байх эрх юм. Энэ эрх чөлөөгөө эдэлснээр иргэд бодитойгоор эрх мэдэлтэй болж, төрийг өөртөө үйлчлүүлэх нөхцөл бодитой бүрдэнэ гэсэн үг.

Мэдээллийн эрх чөлөө нь иргэд эрхээ хамгаалах хэрэгсэл болдог. Харин мэдээлэл авах тухай иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч байгаа холбогдох байгууллага, албан тушаалтан иргэнд хуульд зааснаас бусад шаардлага тавихыг хориглодог.

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

12 дугаар зүйл. Мэдээлэл хүсэгчийн эрх, үүрэг

12.1. Мэдээлэл хүсэгч мэдээлэл авах талаар дараах эрх эдэлнэ:

- 12.1.1. эрх тэгш байх;
- 12.1.2. мэдээлэл авах хэлбэрээ сонгох;
- 12.1.3. мэдээлэл авах болсон шаардлага, үндэслэлээ тайлбарлахгүй байх;
- 12.1.4. мэдээлэлтэй холбогдсон асуудлаар нэмэлт лавлагаа авах;
- 12.1.5. мэдээллийн агуулгын талаар амаар тайлбарлуулах;
- 12.1.6. мэдээллийн албан ёсны эх сурвалжийг мэдэх;
- 12.1.7. мэдээлэл авах эрхийг нь зөрчсөн гэж үзвэл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах;
- 12.1.8. хуульд заасан бусад эрх.

Мэдээлэл хүсэгч иргэн нь эрхээ эдлэхээс гадна мэдээлэл авахдаа дараах үүрэг хүлээнэ:

- хуульд заасан мэдээлэл авах журмыг биелүүлэх;

- мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- авах мэдээллээ бодитой тодорхойлсон байх.

Иргэн ямар мэдээлэл олж авах эрхтэй вэ?

Манай улсад дор дурдсан хуулиар зарим мэдээллийг нууцалснаас бусад мэдээлэл нээлттэй ил тод байдаг:

- Төрийн нууцын тухай хуулиар үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, тагнуул, гүйцэтгэх ажлын тухай мэдээллийг нууцлахаар баталсан байдаг бөгөөд нууцлах мэдээллийн жагсаалтыг мөн л хуулиар тогтоож өгдөг.
- Байгууллагын нууцын тухай хуулиар тухайн байгууллага өөрөө нууцаа тогтоодог бөгөөд нууцаа хамгаалах журмыг баталж мөрдөх үүрэгтэй.
- Хувь хүний нууцын тухай хуулиар хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хувь хүний нууц гэж үзэн хамгаалдаг. Тухайлбал, захидал харилцааны, эрүүл мэндийн, хөрөнгийн, гэр бүлийн талаарх мэдээллийг хамруулсан байдаг.

Хэрэв албан тушаалтан, ажилтан мэдээлэл өгөхөөс татгалзвал шалтгаанаа заавал нотлох ёстой. Хуулийн дагуу мэдээлэл өгөхөөс үндэслэлгүй татгалзсан албан тушаалтан, албан хаагчид захиргааны хариуцлага ногдуулдаг.



Төр, түүний байгууллагаас ямар мэдээлэл авах вэ?

Төр, түүний байгууллагуудад иргэдийн өдөр тутмын үйл хэрэг, аж амьдралтай шууд хамаатай маш олон мэдээлэл байдаг. Үүнд:

- Байгууллагын зохион байгуулалт, эрхлэх ажил үүрэг, бодлого,
- Байгууллагын шийдвэр, санхүүгийн үйл ажиллагаа
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа
- Албан тушаалтнуудын эрх мэдэл, ажил үүргийн хуваарь
- Байгууллагын дотоод дүрэм, журам
- Иргэдэд зориулсан үйлчилгээний тухай тушаал, шийдвэр, журам дүрэм
- Иргэдийн эрхийг хангахтай холбоотой бичиг баримт гэх мэт

Эдгээр мэдээллийг иргэд чөлөөтэй авах боломжийг бүрдүүлэн **мэдээллийн ил тод байдлыг** хангаж ажиллах нь төр, түүний байгууллагын үүрэг юм.

Мэдээлэл авсныхаа төлөө иргэн төлбөр төлөх үү?


Иргэн, хуулийн этгээд мэдээлэл авах тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө. Үйлчилгээний хөлс нь уг мэдээллийг өгөхтэй холбогдон гарах хувилах, шуудангаар хүргүүлэх зэрэг шууд зардлаас хэтэрч болохгүй.

Иргэний хүссэн мэдээллийг ямар журмаар өгөх вэ?

Хариуг нь шууд өгөх боломжтой хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж хариуг өгөх ба хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын 7 өдрийн дотор өгөх бөгөөд хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол тэдгээрийн төлөөлөл болох нэг иргэнд мэдээллийг өгнө.

Иргэнд мэдээлэл өгөхөөс татгалзвал яах вэ?


Тухайн иргэн гомдол тавих эрхтэй. Гомдол, асуудлаа дараах шат дарааллаар шийдвэрлүүлэх эрхтэй.



3. Миний өргөдөл, гомдол гаргах эрх

Үнэнийг олог хууль
Үеийг олог хутга

Иргэн хүн захиргааны байгууллагатай харилцах үндсэн хэлбэр нь захиргааны байгууллага, албан тушаалтанд өргөдөл, санал, хүсэлт гаргах, гомдол мэдүүлэх байдлаар илэрдэг. Жишээлбэл, газар өмчилж авах, тусгай зөвшөөрлөө сунгуулах гэх мэт.



Гомдол нь захиргааны байгууллагын буруугаас иргэн, хуулийн этгээдийн эрх нь зөрчигдөж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр гаргасан хүсэлт юм.

Өргөдөл нь тодорхой ажиллагааг эхлүүлэх, эсхүл дуусгавар болгуулах тухай захиргааны байгууллагад гаргасан хүсэлт.

Хүсэлт гэдэг нь өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг шийдвэрлүүлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт юм.

Өргөдөл, гомдол гаргагч ямар эрхтэй вэ?

Иргэн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн ямар ч асуудлаар төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргах эрхтэй. Харин ямар асуудлаар хандах гэж байгаагаас хамаарч хандах захиргааны байгууллага нь өөр өөр.



ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ

6 дугаар зүйл. Өргөдөл, гомдол гаргагчийн эрх

Өргөдөл, гомдол гаргагч дараах эрх эдэлнэ:

1. төрийн аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах;
2. гаргасан өргөдөл, гомдлынхоо хариуг авах;
3. өргөдөл, гомдолтойгоо холбогдуулж тайлбар, нотлох баримт гаргах;
4. өргөдөл, гомдлоосоо татгалзаж буцаан авах;
5. өгсөн хариуг зөвшөөрөөгүй тохиолдолд зохих дээд шатны албан тушаалтанд гомдол гаргах.

Харин төрийн байгууллага иргэдийг хүлээн авч уулзах байр, өргөдөл, гомдол хүлээн авах цагийн хуваарийг тогтоож, нийтэд мэдэгдсэн байх ёстой.

Өргөдөл, гомдлыг ямар хэлбэрээр гаргах вэ?

Өргөдөл, гомдлыг бичгээр болон амаар биечлэн гаргана. Амаар биечлэн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч байгаа этгээд тэмдэглэн авч, өргөдөл, гомдол гаргагчийн гарын үсгийг зуруулна. Гарын үсгээ зурж чадахгүй бол энэ тухай тэмдэглэнэ.

Өргөдөл өөрөө бичье.

Өргөдөл нь албан бичгийн нэг төрөл юм. Иймээс өргөдлийг бичихдээ шууд буюу гол утгыг нь бичих бөгөөд зүйр цэцэн үг, уран дүрслэл, нутгийн аялгын үг, этгээд бүдүүлэг үг зэргийг хэрэглэх нь зохимжгүй. Өргөдлийг дараах дарааллаар бичнэ.

1. Хүлээн авагч байгууллага, албан тушаалтны нэр бүхий толгой.
/голлуулан бичнэ/
2. Өргөдөл бичих болсон учир шалтгаан буюу агуулга. Энэ хэсгийг дараах дарааллаар бичнэ.
 - Эхлээд өөрийн тухай товч тодорхой танилцуулга.
 - Дараа нь өргөдлийг шийдэхэд холбогдох зүйлийг бичнэ.
 - Төгсгөлд нь юуг хэрхэн шийдүүлэхийг хүсч байгаагаа бичдэг.
3. Өргөдөл гаргагчийн оршин суугаа газрын буюу шуудангийн хаяг, холбоо барих утас /шаардлагатай бол албан тушаал/, овог нэр, гарын үсэг.
4. Он, сар, өдөр гэсэн бүтэцтэй байна.

Өргөдлийн утга агуулга нь янз бүр байж болох бөгөөд бичсэн зүйлийн агуулгаас хамааран хэмжээ нь ямар ч байж болно. Мөн ямар байгууллага, албан тушаалтанд хандаж байгаагаас хамаарч өөр зүйлийг шаардаж болно гэдгийг анхаарах хэрэгтэй.

/Өргөдлийн загвар/

Хандаж байгаа байгууллага,
албан тушаалтны албан тушаал, нэр

Өргөдлийн товч утга

Өргөдлийн агуулга:

- Өргөдөл бичигчийн товч танилцуулга
- Шийдүүлэхийг хүсч буй асуудлын агуулга

Өргөдөл гаргагчийн хаяг, овог нэр, гарын үсэг:

Он.сар.өдөр

4. Захиргааны шийдвэрт гомдол гаргах

*Заан хэдий том г замын аяыг дагана
Жанжин хэдий мэдэлтэй г жууль ёсыг дагана*


Захиргааны байгууллага, албан тушаалтан хуулийг хэрэгжүүлэх явцдаа олон шийдвэр гаргадаг.

Захиргааны байгууллага гэдэгт нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулдаг төрийн захиргааны, иргэд, аж ахуйн нэгжид нийтлэг үйлчилгээ үзүүлдэг нийтийн захиргааны байгууллагуудыг хамруулан ойлгодог.



Эдгээр захиргааны байгууллага, албан тушаалтан нь шийдвэр, үйл ажиллагаагаараа эрхийг нь зөрчсөн тохиолдолд тухайн иргэд, аж ахуйн нэгж, байгууллага нэг талаар зөрчигдсөн эрхээ нөхөн сэргээлгэх, нөгөө талаар буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхээр гомдол гаргах нь зүйн хэрэг юм.

Захиргааны шийдвэр буюу акт гэж нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан захирамжилсан шийдвэрийг хэлнэ.



Жишээлбэл, иргэнд газар өмчлүүлэх асуудлыг шийдвэрлэсэн аймгийн Засаг даргын захирамж, замын хөдөлгөөний дүрэм гэх мэт.

Захиргааны актыг илрэх хэлбэрийн хувьд аман, бичгийн, үйл хөдлөл-хөдөлгөөний, мөн техникийн гэж ангилдаг бөгөөд захиргааны актыг танин мэдсэнээр эрхээ хамгаалах боломж бүрддэг.

Амаар гаргаж буй шийдвэр нь гол төлөв ажлын явц байдалтай танилцах, шийдвэрийн биелэлтийг шалгах, тодорхой тохиолдолд дүрэм, журам сахиулахад хэрэглэгддэг байна.

Бичгээр гаргаж буй шийдвэр нь гол төлөв бусдад үүрэг болгосон, захирамжилсан, хариуцлага ногдуулсан, эрх олгосон зэрэг тохиолдолд хэрэглэгддэг.

Үйл хөдлөл-хөдөлгөөний хэлбэрээр илрэх шийдвэр нь гол төлөв захиргааны байгууллагаас иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд илэрдэг. Жишээ нь: замын хөдөлгөөнийг зохицуулж буй цагдаагийн гарын хөдөлгөөн.

Техникийн хэлбэрээр илрэх захиргааны акт нь харьцангуй цөөн бөгөөд гол төлөв захиргааны байгууллагаас иргэдэд техник хэрэгсэл ашиглан шийдвэр гаргах тохиолдолд илэрдэг. Жишээ нь: Замын хөдөлгөөнийг зохицуулах гэрэл дохио, тэмдэг, тэмдэглэгээ,

банкны дансаар гүйлгээ хийхэд холбогдох татвар, үйлчилгээний хураамжийг тусгай программаар хийх гэх мэт

Захиргааны хууль бус үйл ажиллагаа

Захиргааны байгууллага, тэдгээрийн албан тушаалтан нь захиргааны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ алдаа, дутагдал гаргах явдал цөөн боловч гардаг. Энэхүү захиргааны байгууллагын гаргасан алдаа нь иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байдаг тул захиргааны хууль бус үйл ажиллагаа гэж үздэг.

Тохиолдол:

Намайг Аюуш гэдэг. Би гэрийнхээ ойролцоо байх нэгэн дэлгүүрээр байнга үйлчлүүлдэг бөгөөд уг дэлгүүрт хэд хэдэн удаа хугацаа дууссан бүтээгдэхүүн зарж байсан. Сүү, тараг нь сав, баглаа боодлын хувьд чанарын шаардлага хангахгүй, пэмбийж хөөсөн мөн он, сар байхгүй байна. Энэ дагуу дүүргийнхээ мэргэжлийн хяналтын байгууллагад хандаад байхад ямар ч арга хэмжээ авахгүй байх юм. Тэгэхээр энэ байгууллагыг хууль бус үйл ажиллагаа явуулсан гэж үзэх үү?

Захиргааны хууль бус ажиллагаа нь хоёр хэлбэрээр илэрч болно.

- **Үйлдэл:** иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эрхийг зөрчсөн шийдвэр, идэвхтэй үйл ажиллагаагаар.
- **Эс үйлдэхүй:** захиргааны байгууллага хуульд заасан үүргээ биелүүлээгүй, гаргах ёстой шийдвэрийг гаргаагүй орхигдуулсан идэвхгүй байдлаар.

Иймд дээрх тохиолдолд дүүргийн мэргэжлийн хяналтын байгууллага үүргээ биелүүлээгүй тул хууль бус үйл ажиллагаа явуулсан гэж үзнэ.

Захиргааны шийдвэрт гомдол гаргах

Иргэд болон аж ахуйн нэгж, байгууллага захиргааны шийдвэр нь тэдний эрхийг зөрчсөн гэж үзвэл Захиргааны хэргийн шүүхэд хандах боломжтой юм. Гэхдээ дээрх байгууллагын зөвхөн гадагш /бусдаас/

дагаж мөрдөх буюу заавал биелүүлэх захиргааны акт нь захиргааны хэргийн шүүхэд хамаарах учиртай. Жишээ: Улсын байцаагч үндэслэлгүйгээр иргэнийг торгосон, улсын өмчийн дунд сургуулийн захиргаа сурагчдаас мөнгө шаардсан, аж ахуйн нэгж байгууллагын зөвшөөрлийг үндэслэлгүйгээр хүчингүй болгосон гэх мэт.

Хуульд зааснаар шүүхэд хандахаас өмнө урьдчилан шийдвэрлэх ажиллагааг заавал явуулсан байхыг шаарддаг бөгөөд хэрэв энэ ажиллагааг явуулаагүй бол шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалздаг. Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь иргэн, хуулийн этгээдийн гомдлоор дээд шатны байгууллага гомдлыг хянан хэлэлцдэг үе шат юм.

Захиргааны хэргийг урьдчилан хянан шийдвэрлэх нь

Иргэн Та юуны өмнө уг хууль бус захиргааны акт гаргасан гэж үзэж байгаа захиргааны байгууллага, албан тушаалтны шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж эрхээ зөрчигдсөнөөс эсхүл мэдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй.



Дээд шатны байгууллага гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор сунгаж болно. Хугацаа сунгасан тухай гомдол гаргасан иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэх журамтай.

Гэхдээ хэрэв тухайн албан тушаалтан, эсхүл байгууллага нь шаталсан зохион байгуулалттай олон дээд шатны байгууллага, эсхүл албан тушаалтантай бол шат бүрийг дамжин гомдол гаргахгүй, харин эхний шатны байгууллага, албан тушаалтанд хандаад дараа нь захиргааны хэргийн шүүхэд хандана. Жишээ нь: хорооны Засаг даргын гаргасан шийдвэрийг дүүргийн Засаг даргад хандаад, дараа нь захиргааны хэргийн шүүхэд хандана гэсэн үг.

Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан нь таны гомдлыг шийдвэрлэсэн боловч тэрхүү шийдвэр нь таны эрхийг зөрчсөөр байгаа, эсхүл таны гаргасан гомдлыг тогтоосон хугацаанд шийдвэрлээгүй, мөн шууд харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй тохиолдолд иргэд болон аж ахуйн нэгж байгууллага нь захиргааны хэргийн анхан шатны буюу аймагт бол аймгийн захиргааны хэргийн шүүхэд, нийслэлд бол нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж зөрчигдсөн эрхээ хамгаалуулах боломжтой юм. Жишээ нь: хорооны Засаг даргын гаргасан хууль бус захирамж, эсхүл түүний иргэдийн эрхийг зөрчиж гаргасан шийдвэрийг дүүргийн Засаг даргад хандаж урьдчилан захиргааны хэрэг хянан шийдвэрлүүлэх журмын дагуу гаргана. Хэрэв дүүргийн Засаг даргын гаргасан шийдвэр нь өмнөх шийдвэртэйгээ нэгэн адил гэж үзвэл нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд хандан нэхэмжлэл гаргадаг журамтай.

5. Захиргааны хэргийн шүүхэд хандах

*Мөрийн доор захирагдаж
Мэргэрийн доор амьдрах*

Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/ нь эрхийг нь хохироосон, хуульд нийцээгүй гэж үзвэл иргэд, хуулийн этгээд шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Ийм нэхэмжлэлийн үндсэн дээр тэдгээрийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээдэг, хэргийн төрлөөр дагнасан шүүхийг **Захиргааны хэргийн шүүх** гэдэг.

Захиргааны хэргийн анхан шатны шүүх нь аймаг, нийслэлд байдаг. Нэхэмжлэлийг алдаатай болоод буруу захиргааны шийдвэр гаргасан байгууллагын оршин байгаа газрын захиргааны хэргийн шүүхэд гаргана. Сум, дүүрэгт гарсан маргааныг аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх харьяалан шийдвэрлэдэг.

Захиргааны хэргийн шүүхээр ямар хэргийг шийдвэрлэдэг вэ?

Захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/ нь захиргааны хэргийн шүүхэд хянагдана. Гэхдээ эдгээр байгууллагын зөвхөн гадагш /бусдаас/ дагаж мөрдөх буюу заавал биелүүлэх захиргааны акт нь захиргааны хэргийн шүүхэд хамаарна.

Тохиолдол:

Намайг Оюун гэдэг. Би дүүргийн Засаг даргын 2007 оны захирамжаар 400 м² газар эзэмшдэг. Гэтэл дүүргийн Засаг дарга миний газартай давхцуулан Болд гэдэг хүнд 2011 онд газар олгосон байна. Энэ талаар би дүүргийн Засаг дарга, нийслэлийн Засаг даргад удаа дараа хандсан боловч одоо хүртэл шийдвэрлэж өгөхгүй байна. Одоо би хаана хандах вэ?

Иргэн, хуулийн этгээд эрх, ашиг сонирхлыг захиргааны байгууллага, албан тушаалтан зөрчсөн гэж үзвэл эрх нь зөрчигдсөн

гэж үзэж буй этгээд Захиргааны хэргийн шүүхэд хандан нэхэмжлэл гаргах эрхтэй. Дараах тохиолдолд шүүхэд хандаж нэхэмжлэл гаргах боломжтой болно:

- хуульд тусгайлан заасан;
- дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтнаас гомдлын гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн;
- захиргааны байгууллага, албан тушаалтны гомдлын дагуу хянан үзээд гаргасан шийдвэрийг биелүүлээгүй;
- шууд харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан гомдлыг хуульд заасан хугацаанд хянан шийдвэрлээгүй;
- харьяалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан байхгүй.

Дээр дурдсан тохиолдлын хувьд дүүргийн Засаг даргын шууд харьяалах дээд шатны байгууллага болох нийслэлийн Засаг даргад хандаад шийдвэрийг нь хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул нийслэлийн Захиргааны хэргийн шүүхэд хандах эрх нь нээлттэй байна.

Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл бичих

Иргэн, хуулийн этгээд захиргааны үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны шүүхэд хандаж гаргасан өргөдлийг **нэхэмжлэл** гэнэ.

Нэхэмжлэлийг заавал бичгээр гаргана. Нэхэмжлэлд нэхэмжлэгч, эсвэл түүнийг төлөөлж байгаа этгээд гарын үсэг зурсан байна.

Нэхэмжлэлд дараах зүйлийг тусгана:

- нэхэмжлэлийг захиргааны хэргийн ямар шүүхэд гаргаж байгаа;
- нэхэмжлэгч, хариуцагчийн овог, эцгийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;
- нэхэмжлэлийн шаардлагын агуулга;
- хавсаргасан баримт бичгийн жагсаалт.

Нэхэмжлэлийг доорх загвараар бичнэ:

...../аймгийн эсвэл нийслэл/-ийн
Захиргааны хэргийн шүүхэд хандаж байгаа

Он, сар, өдөр

Нэхэмжлэгч: овог, эцгийн нэр, нэр, оршин суугаа хаяг

Хариуцагч: албан тушаал овог, эцгийн нэр, нэр, оршин суугаа хаяг

Нэхэмжлэлийн шаардлагын товч утга:

Нэхэмжлэлийн утга:

Нэхэмжлэлд хавсаргасан баримт бичгийн жагсаалт

Нэхэмжлэгчийн гарын үсэг


Нэхэмжлэлийн шаардлагад эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн захиргааны актыг хүчингүй болгуулах, илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх, учирсан хохирлоо арилгуулж зөрчигдсөн эрхээ сэргээлгэхийг алиныг нь шаардаж байгаагаа бичнэ.

Нэхэмжлэлийг хариуцагчийн тоогоор хувилж өгнө. Нэхэмжлэлийг хариуцагчийн оршин байгаа газрын шүүхэд гаргана.

Нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх ажиллагаа

Шүүхэд ирүүлсэн нэхэмжлэлийг шүүх хүлээн авч бүртгэсний дараа түүнийг хэрхэх асуудлыг шүүгч захирамж гарган шийдвэрлэдэг. Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангаагүй бол хүлээн авсан шүүгч 7-14 хоногийн хугацаа тогтоон нэхэмжлэгчид уг шаардлагыг хангах боломж олгоно.

Шүүх нэхэмжлэлийг хүлээж авснаас хойш 7 хоногийн дотор хянаж шийдвэр гаргадаг.



Захиргааны хэргийн шүүх хэргийг ямар хугацаанд шийдвэрлэх вэ?

Захиргааны хэрэг үүсгэсэн үеэс эхлэн шүүгч, нэхэмжлэгч, хариуцагч, хэргийн бусад оролцогчид шүүхээр хэрэг хянан хэлэлцэх ажиллагаанд бэлтгэж эхэлдэг.

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай нотлох баримт цугларсан гэж үзвэл шүүх хуралдааныг хийж хэргийг шийдвэрлэдэг. Гэхдээ захиргааны хэрэг үүсгэсэн үеэс эхлэн шүүх хуралдааныг хэргийг хянан хэлэлцэх хүртэлх үйл явц нь тодорхой дараалалтай, тодорхой цаг хугацаанд хэрэгжиж байдаг.

Дараах хүснэгтээр захиргааны хэргийг хянан шийдвэрлэх дараалал, журам, хугацааг товч харууллаа.

	Захиргааны хэргийг шийдвэрлэх	Зарцуулах хугацаа	Тайлбар
1.	Нэхэмжлэл хүлээн авах		
2.	Захиргааны хэрэг үүсгэх	7 хоног	Нэхэмжлэл хүлээн авснаас хойш
3.	Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах	Нийслэлд 7, орон нутагт 14 хоногийн дотор	Хэрэг үүсгэсэн өдрөөс хойш
4.	Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх эсэх тухай бичгээр мэдэгдэх	14 хоногийн дотор	Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш
5.	Шүүх хуралдаанаар захиргааны хэргийг хянан шийдвэрлэх	Аймгийн төвд 40, Нийслэлд 30 хоногийн дотор	Нэхэмжлэл хүлээн авсан өдрөөс хойш
6.	Дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэргийг хянан шийдвэрлэх	30 хоногийн дотор	Шүүх хүлээн авснаас хойш
7.	Шаардлагатай тохиолдолд захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хугацааг сунгах	Нэг удаа 30 хүртэл хоногоор, 15 хоногоор 2 дахь удаагаа	Тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөлгөөнөөс

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны хэргийн шүүх, шүүгч гүйцэтгэдэг нь захиргааны хэргийн шүүхийн онцлог юм. Энэ нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь тэднээс илүү эрх мэдэлтэй, зарим тохиолдолд тэднийг захирч байдаг захиргааны байгууллага, албан тушаалтнаас хамгаалах зорилготой зохицуулалт юм.

Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, иргэнээс гаргаж өгөхийг шаардах эрхтэй бөгөөд холбогдох этгээд уг шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Нэхэмжлэгч бол захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан иргэн, хуулийн этгээд юм.



Нэхэмжлэгчийн эрх:

1. Нэхэмжлэлээ өөрчлөх, түүний шаардлагын хэмжээг ихэсгэх буюу багасгах, нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагчтай эвлэрэх;
2. Захиргааны хэргийн шүүхийн болон эсрэг талын шаардлага, тайлбар, нотлох баримт, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл, хуулбар хийх, тэдгээрт тайлбар өгөх, шүүх хуралдаанд оролцох;

3. Нотлох баримт гаргаж өгөх, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, бусад нотлох баримт цуглуулах, шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах;
4. Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч, прокурор, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг хуульд заасан үндэслэлээр татгалзан гаргахыг шаардах;
5. Шүүх хуралдааны бусад оролцогчид асуулт тавих;
6. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах;
7. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төлөөлөгчөө оролцуулах;
8. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд өмгөөлөгчийн туслалцаа авах;
9. Хуульд заасан бусад эрх.

Нэхэмжлэгчийн үүрэг:

1. Захиргааны хэргийн шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;
2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам, шүүх хуралдааны дэгийг сахих;
3. Захиргааны хэргийн шүүхийн тавьсан шаардлагыг биелүүлэх;
4. Захиргааны хэргийн шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар гаргах;
5. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хуульд заасан хугацаанд гардан авах;
6. Захиргааны хэргийн шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрийг биелүүлэх;
7. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед нэхэмжлэгч, түүний төлөөлөгч хаягаа өөрчилбөл энэ тухай шүүхэд мэдэгдэх;


Нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд нэхэмжлэлээсээ татгалзах, хариуцагчтай харилцан тохиролцож эвлэрлийн гэрээ байгуулж маргааныг дуусгавар болгож болно.

Энэ тохиолдолд нэхэмжлэгч дахин нэхэмжлэл гаргах эрхээ алдана. Өөрөөр хэлбэл, дахиад энэ асуудлаар шүүхэд хандвал шүүх

түүнийг нь хүлээж авахгүй гэсэн үг. Иймд нэхэмлэгч нэхэмжлэлээс татгалзах, хариуцагчтай харилцан тохиролцох бол бусдын ялангуяа, хариуцагчийн нөлөөнд авталгүйгээр /айлгах, сүрдүүлэх, заналхийлэх, ятгах, гуйх зэргийг харгалзалгүйгээр/ ултай, суурьтай бодож, үр дагаврыг тооцож өөрөө шийдвэрлэх нь их чухал байдаг.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр

Захиргааны хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд хангалттай нотлох баримт цугларсан гэж үзсэн, эсвэл дээр дурдсан хугацаа дууссан бол шүүгч захирамж гаргаж, шүүх хуралдааныг хэзээ, хаана болохыг товлон зарлаж шүүх хуралдааныг хийж хэргийг шийдвэрлэнэ.



Захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажилллагааны улмаас нэхэмжлэгчид хохирол учирсан нь тогтоогдвол нөхөн төлүүлнэ. Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг уншиж сонсгосноос хойш 7 хоногийн дотор хувийг хэргийн оролцогчдод хүргүүлнэ.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болно. Хэргийн оролцогчид захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн биелүүлэх үүрэгтэй.

Гэхдээ захиргааны хэргийн шүүх шийдвэрээ биелүүлэх арга, журам, хугацааг гаргасан шийдвэртээ тодорхой тусгах ёстой.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт гомдол гаргах

Анхан шатны шүүх хууль бус, үндэслэлгүй шийдвэр гаргах тохиолдол бий. Жишээ нь: хэргийн нөхцөл байдлын талаар буруу үнэлэлт дүгнэлт өгснөөс захиргааны хэргийн шүүхийн шийдвэр үндэслэлгүй болж болно. Анхан шатны шүүхийн энэхүү алдаа дутагдлыг арилгаж, хууль ёсны, үндэслэлтэй шийдвэр гаргах, хүний эрхийг баталгаатайгаар хангах гэх мэт боломжийг давж заалдах шатны журмаар захиргааны хэрэг хэлэлцэж хангаж болно.

Нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, гуравдагч этгээд шүүхийн шийдвэрт гомдол хэрхэн гаргах вэ?

1. Анхан шатны журмаар захиргааны хэрэг хянан шийдвэрлээд гаргасан шүүхийн шийдвэртэй сайн танилцана.
2. Давж заалдах гомдол бичих: хуулийн ямар заалт болон таны ямар эрхийг зөрчсөн талаар тодорхой бичнэ.
3. Анхан шатны шүүхийн шийдвэрт тухайн шийдвэрийг гардан авснаас хойш давж заалдах гомдлыг 14 хоногийн дотор хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхээр дамжуулан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гаргана.
4. Гомдлын дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх захиргааны хэргийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан хянан шийдвэрлэж, магадлал гаргана.

5. Магадлалыг эс зөвшөөрвөл гардан авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор хяналтын журмаар Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гомдол гаргаж болно.
6. Улсын Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоолыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хууль зөрчсөн үндэслэлээр Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид гомдол гаргаж болно.


6. Иргэн захиргааны зөрчил гаргавал яах вэ?

*Тэм хийвэл
Зэм хрлээж*

Захиргааны зөрчил

Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон хууль, захиргааны журмыг санаатай болон болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил гэж үзнэ. Жишээ нь: хөдөлгөөний аюулгүй байдал, гааль, эрүүл ахуй, ариун цэвэр, иргэний бүртгэл, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны, худалдаа үйлчилгээний гэх мэт журмуудыг зөрчсөн тохиолдолд захиргааны хариуцлага хүлээлгэдэг.

Ямар үйлдэл, эс үйлдэхүй захиргааны зөрчил болох, түүнд ямар хариуцлага хүлээлгэх талаар Захиргааны хариуцлагын тухай хууль болон өөр бусад 200 орчим хуульд тодорхойлсон байдаг.



Иргэн: зөрчил үйлдэх үедээ 16 насанд хүрсэн иргэн байна.

Албантушаалтан: хууль, журмаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсвэл үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан тушаалтан.

Хуулийн этгээд: аж ахуй нэгж, байгууллага ажил, үйлчилгээ явуулахдаа захиргааны журам зөрчвөл хуульд зааснаар хариуцлага хүлээдэг. Жишээ нь: ариун цэврийн дэглэм сахихгүй байх.

Тохиолдол:

Иргэн А, Б хоёр ярилцаж байна:

А: Би сая машинтайгаа явж байгаад торгуулаад.

Б: Ямар зөрчил гаргасан юм бэ?

А: Ямар зөрчил гаргасан, ямар учраас торгосныг нь мэдсэнгүй.

Б: Зөрчил гаргасан хүн ч тодорхой эрх эдэлдэг байх. Гомдолтой байгаа бол шийтгэл ногдуулсан шийдвэрт гомдол гаргаж болдог гэсэн. Мэддэг хүнээс нь асууя.



Зөрчил гаргасан этгээд дараах эрх эдэлнэ:

1. **Зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох.**
2. **Нотлох баримттай танилцах.** Зөрчил гаргасан болохыг нотолж байгаа болон үгүйсгэж байгаа бүхий л баримт материалтай танилцаж болно гэсэн үг юм.

3. **Зөрчлийн талаар тайлбар өгөх, нотлох баримт, хүсэлт гаргах.** Яагаад зөрчил гаргах болсон, зөрчлийн талаарх мэдэх зүйлүүдээ тайлбарлаж хэлэх, өөрийн гэм буруугүйг нотлох баримт материалыг гаргаж өгөх, тодорхой зүйлийг шалгуулахаар хүсэлт гаргаж болно.
4. **Шийтгэл ногдуулсан шийдвэрийг давж заалдах.** Захиргааны зөрчилд оногдуулсан шийтгэл үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны албан тушаалтанд нь гомдол гаргах эрхтэй гэсэн үг юм.
5. **Хууль зүйн туслалцаа авах.** Зөрчил, түүнд оногдуулах шийтгэл, шийтгэлийг хөнгөрүүлж үзэх ямар боломжууд байдгийг мэдэхгүй бол хуульч, өмгөөлөгчид хандаж зөвлөгөө авах боломжтой.
6. **Эрхээ зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд гомдол гаргах.** Дээр дурдсан эрхээ эдлэх боломжийг захиргааны хариуцлага хүлээлгэж буй албан тушаалтан танд олгоогүй гэж үзвэл шүүхэд энэ тухайгаа гомдол гаргаж болно гэсэн үг юм.

Зөрчил гаргагч нь дээрх эрхийг хэрэгжүүлснээр өөрийн үйлдэлд тохирсон захиргааны хариуцлага хүлээх боломж бүрддэг. Гэхдээ эрх гэдэг бол заавар хэрэгжүүлэх үйлдэл биш. Харин хариуцлага хүлээлгэж буй албан тушаалтан зөрчил гаргагчид энэ боломжуудыг ашиглах нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй байдаг.

Захиргааны албадлага

Хууль зөрчсөн, төр, нийгэм, иргэдэд хор уршиг учруулсан нөхцөлд уг этгээдийн эрхийг хязгаарлаж албадлага хэрэглэх үүргийг төрийн эрх бүхий албан тушаалтан, албан хаагчид хуулиар хүлээлгэсэн байдаг.

Захиргааны албадлагыг зөрчил гарсан болон гарахаас нь өмнө *урьдчилан сэргийлж* зөрчил үйлдэхээр бэлтгэж байгаа, эсвэл зөрчил үйлдэж байхад нь *таслан зогсоох* зорилгоор хэрэглэдэг. Жишээ нь: зөрчил гаргасан этгээдийн биед болон эд зүйлд нэгжлэг, үзлэг хийх, эд зүйл, баримт бичиг түр хураах, автомашин журамлах, ачих гэх мэт.

Захиргааны журмаар албадан саатуулах

Зөрчлийг таслан зогсоох, зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэх үед шаардлагатай гэж үзвэл зөрчил гаргасан этгээдийг сумын

Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах албадан саатуулж болно.

Энэ нь зөрчил гаргасан этгээдийн чөлөөтэй үйлдэл, хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлаж буй үйлдэл юм.

Зөрчил гаргасан этгээдийг захиргааны журмаар түр саатуулах хугацаа **6 цагаас** илүү байж болохгүй.

Зайлшгүй шаардлагатай тохиолдолд харьяалах шүүхэд албан ёсоор мэдэгдэж түүнийг **72 цаг** хүртэл хугацаагаар захиргааны журмаар албадан саатуулж болно. Жишээ нь: хүүхдийг сэтгэл санааны болон бие махбодийн дарамтад байлгасан, хавчин шахаж хүч хэрэглэсэн иргэнийг цаашид ноцтой хор уршиг учруулахгүйн үүднээс албадан саатуулж болно.

Албадан саатуулагдсан этгээд хаана, ямар газар, албан тушаалтны мэдэлд байгааг зөрчил гаргасан этгээд болон түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгч авсан бол өмгөөлөгчид заавал мэдэгдэх ёстой.

Захиргааны эрх зүйн зөрчил нь ялимгүй, уг зөрчлийг газар дээр нь шийдвэрлэсэн бол захиргааны журмаар албадан саатуулж болохгүй.

Тохиолдол:

А, Б хоёр үргэлжлүүлэн ярьж байна

Б: Би өчигдөр эрүүлжүүлэгдээд

А: Архи хэтрүүлж хэрэглэсэн юм уу?

Б: Уг дөнгөж л амссан байсан юм. Гэр рүүгээ харих замдаа цагдаатай тааралдаад тэгээд үнэртүүлсэн байна гээд эрүүлжүүлсэн.

А: Архи уусан хүн болгоныг эрүүлжүүлдэг гэж үү?

Өөрийн үйлдлийг удирдан хянах чадваргүй болтлоо согтсон хүнийг цагдаагийн албан хаагч эрүүлжүүлэх байранд хүргэж албадан эрүүлжүүлнэ. Согтсон нь дараах байдлаар илэрч болно.

- ≈ гэр бүлийн буюу бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан;
- ≈ хаана байгаагаа болон очих газраа мэдэхгүй болсон;
- ≈ гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй унасан байж болно.

Согтсон хүнийг эрүүлжүүлэх байранд хүргэх нь гэмт хэрэг үйлдэх, захиргааны зөрчил гаргах, мөн осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс тухайн этгээдийг хамгаалах, тусламж үзүүлэх зорилготой.

Албадан эрүүлжүүлэх гэж согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийн өөрийн үйлдлээ удирдан хянах чадварыг нь сэргээх үйл ажиллагаа юм.

Харин согтууруулах ундаа хэрэглэсэн боловч өөрийн үйлдлээ удирдан хянах чадвартай, зөрчил гаргаагүй хүнийг эрүүлжүүлэх байранд албадан хүргэхийг хориглоно.

Гэм хийсэн бол түүнд зэм бий

Захиргааны зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг **захиргааны шийтгэл** гэдэг. Зөрчил гаргасан этгээдэд дараах захиргааны шийтгэл ногдуулж болно:

1. **Торгох:** Торгууль нь хууль тогтоомжид урьдчилан заасан, тодорхой хэмжээ хязгаарын дотор захиргааны зөрчилд оногдуулж буй мөнгөн шийтгэл юм. Зөрчил гаргагч этгээдээс хамаарч торгуулийн хэмжээ нь ялгаатай байдаг:

- иргэний хувьд 100-50000,
- албан тушаалтны хувьд 1000-60000,
- байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд 50000-250000 төгрөг байна.

Хуульд заасан бол торгуулийн хэмжээ үүнээс өндөр байж болно.

2. **Тусгайлан олгосон эрхийг хасах:** Эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой үйл ажиллагаа явуулах, тодорхой үйлдэл хийх эрхийг хасах, хүчингүй болгох шийтгэл юм. Жишээ нь: тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 6 сараас 2 жил хүртэл хугацаатайгаар хасах, бар, ресторан, дэлгүүрийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг цуцлах гэх мэт.


3. **Хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хураах:** Үүнд галт зэвсэг, амьсгал боогдуулагч, нулимс асгаруулах бодис, хутга, мэс, бусад хүйтэн зэвсэг, худалдаа үйлчилгээ, тогтоосон үнэ, тариф, жин хэмжүүр, эрчим хүч, холбооны журам зөрчиж

хууль бусаар олсон орлогыг хураахыг ойлгоно. Жишээ нь: буруу хэмждэг жин, стандартын шаардлага хангаагүй туухай гэх мэт зүйлийг түүнийг ашиглан олсон орлоготой нь хамт хураан авч болно.

4. **Баривчлах:** Хуульд зааснаар 7-30 хоногийн хугацаатайгаар иргэний чөлөөтэйгөөр зорчин явах эрхийг хязгаарлах шийтгэл юм. Баривчлах шийтгэлийг шүүгч, сумын засаг дарга л ногдуулах эрхтэй байдаг.

Торгох, баривчлах, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэлийг дангаар нь оногдуулж болдог бол хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хураах шийтгэлийг торгох, баривчлах, тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэлтэй хамтад нь хэрэглэж болдог. Мөн тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасах шийтгэлийг торгох, баривчлах шийтгэлтэй хамтад нь хэрэглэж болдог. Харин нэг зөрчил гаргасан нэг этгээдэд торгох болон баривчлах шийтгэлийг зэрэг оногдуулж болдоггүй.

Захиргааны шийтгэлүүд дээр дурдсан хүрээ, хэмжээний дотор байх ёстой. Хэрэв энэ хуульд заасан хүрээ, хэмжээнээс илүү бол энэ нь зөрчил гаргагчийн эрхийг зөрчсөн үйлдэл болно. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан зөрчил илрүүлсэн, зөрчлийн тухай баримт сэлт хүлээн авсан өдрөөс хойш дараах хугацаанд зөрчлийг хянан шийдвэрлэнэ:



Жишээлбэл, уулзвараар автомашинтайгаа улаан гэрлээр гарахыг нь харсан замын цагдаа зөрчил гаргасан жолоочид шууд газар дээр нь хариуцлага хүлээлгэж болно.

Харин зөрчлийг хянан шалгах тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчлийн тухай гомдол, мэдээлэл, үйл баримтыг үндэслэн зөрчлийг хянан шалгах ажиллагааг тухайн захиргааны зөрчлийг илрүүлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор явуулна. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн эрх бүхий байгууллагын удирдлагын шийдвэрээр 14 хүртэл хоногоор сунгаж болно.

Тохиолдол:

Дүүргийн цагдаагийн хэлтсээс манай 18 настай хүү Доржийг 1 жилийн өмнө танхайрсан гээд Эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байсан юм. Тэгтэл 3 сарын өмнө прокурор нь гэмт хэрэг биш гээд хүчингүй болгосон. Гэтэл 7 хоногийн өмнө дуудаад гэмт хэрэг биш ч гэсэн захиргааны хариуцлага хүлээлгэх ёстой гээд торгосон байна.

Одоо манай хүүхдэд хариуцлага хүлээлгэж болно гэж үү?

Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн тухай гомдол, мэдээлэл, үйл баримтыг шалгаад хор аюулын шинж байдлыг харгалзан тухайн зөрчилд тохирсон хариуцлагыг хүлээлгэх ёстой.

Харин дараах тохиолдолд зөрчилд захиргааны хариуцлага хүлээлгэж болохгүй:

- о захиргааны хариуцлага тогтоосон хууль тогтоомж хүчингүй болсон;
- о зөрчил гаргасан этгээд зөрчил үйлдэх үедээ 16 насанд хүрээгүй, эсхүл өөрийн үйлдлийг ойлгох, зөв жолоодох эрх зүйн чадамжгүй байсан;
- о зөрчил гаргасан этгээд нас барсан;
- о зөрчил гарсан өдрөөс, зөрчил үргэлжилсэн буюу давтан үйлдсэн тохиолдолд сүүлийн зөрчил гарсан өдрөөс хойш 3 сарын хугацаа өнгөрсөн. Зөрчил гаргагч хариуцлага хүлээхээс оргон зайлсан бол энэ хугацаа тасардаг.
- о Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бөгөөд уг зөрчилд хариуцлага хүлээлгэхээр бол хэрэгсэхгүй болгосон тогтоол гарснаас хойш 1 сарын хугацаа өнгөрсөн.

Дээр дурдсан тохиолдлын хувьд хуульд зааснаар эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бөгөөд уг зөрчилд захиргааны хариуцлага хүлээлгэхээр байвал эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай тогтоол гарсан өдрөөс хойш нэг сарын дотор хариуцлага тооцох ёстой тул одоо хариуцлага хүлээлгэж байгаа нь хууль бус юм.


Мөн аргагүй хамгаалалт, гарцаагүй байдлын нөхцөлд зөрчил гаргасан бол захиргааны хариуцлагаас чөлөөлнө.

Захиргааны шийтгэл оногдуулахдаа таны эрхийг зөрчсөн гэж үзвэл ямар замаар зөрчигдсэн эрхээ сэргээх вэ?

1. Захиргааны шийтгэл ногдуулсан торгуулийн хуудас, шийтгэвэртэй сайн танилцана.
2. Давж заалдах гомдол бичих: /хуулийн ямар заалт, таны ямар эрхийг зөрчсөн талаар тодорхой бичнэ./
3. Торгуулийн хуудас, шийтгэвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор уг шийдвэрийг гаргасан байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандана.
4. Давж заалдсан гомдлыг дээд шатны албан тушаалтан хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.
5. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл **шүүхэд гомдол гаргах эрхтэй** байдаг.

II. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР-ХУУЛЬ

1. Байгаль орчноо хайрлая
2. Монгол Улсад хэн газар өмчлөгч вэ?
3. Газар эзэмших, ашиглах
4. Бэлчээрийн газар, хадлан



Иргэд бид байгаль
дэлхийгээ хайрлан хамгаалах
үүргийг хуулиар хүлээдэг.
Монгол Улсын иргэд газар өмчлөх,
эзэмших, ашиглах эрхээ хуулийн хүрээнд
хэрхэн хэрэгжүүлэх боломжтой вэ?

II. БАЙГАЛЬ ОРЧИН, ГАЗАР - ХУУЛЬ

1. Байгаль орчноо хайрлая

*Угаасан ус рашаан
Унасан шороо алт*

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар иргэд “эрүүл, аюулгүй орчинд амьдарч, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” хэдий ч нөгөө талаар байгаль орчноо хамгаалах журамт үүргийг хүлээдэг билээ. Байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах ажил нь хүн бүрийн оролцоо, хүчин чармайлт, сэтгэлээс хамааралтай юм. Иймд байгаль орчноо хамгаалах хууль журмыг иргэн бүр мэдэж, сахин биелүүлж байх нь чухал юм. Орон нутгийн иргэд нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд тодорхой төрлийн байгалийн баялагийг хамгаалах зорилгоор нэгдэн иргэдийн нөхөрлөл байгуулан ажиллах боломжтой.

Ус. Сүүлийн жилүүдэд цаг уурын дулаарал, ашигт малтмалын олборлолт, ой модыг их хэмжээгээр огтолж байгаа зэргээс болж гол горхи, булаг шанд, нуур цөөрөм олноороо хатаж, ширгэн алга болж байна. Зөвхөн гол горхи гэхэд 900 орчим нь ширгэж алга болжээ.

Усны эх, ундаргад тогтоосон онцгой хамгаалалтын бүсэд:

- ☒ газар хагалах
- ☒ тэсэлгээ хийх
- ☒ барилга барих
- ☒ элс, хайрга, чулуу авах
- ☒ зэгс, шагшуурга, мод огтлох
- ☒ ашигт малтмал хайж, олборлох
- ☒ ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүх
- ☒ мал угаах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулах **хориотой**.

Ой мод. Монгол Улсын нийт нутгийн 72 хувь нь цөлжилтөд өртөөд байна. Иргэд бид ойн баялгийг устгаж, сүйтгэсэн тухай мэдвэл Засаг

дарга болон байгаль хамгаалагчдаа нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. Түүнчлэн ой модоо хамгаалах үндэснийхээ уламжлал, ёс заншлыг дээдлэж, үр хүүхдүүдээ ч энэ талаар хэлж сургах үүргийг хүлээдэг.

Ойд хавтгайруулан огтлох аргаар мод бэлтгэх, зөвшөөрөлгүйгээр өвс хадах, тарьц суулгац ургуулсан талбайд мал бэлчээх зэргийг хуулиар хориглодог.

Ой, хээрийн гал түймрээс нэн ялангуяа, дулааны улиралд урьдчилан сэргийлэх талаар байнга анхаарч байх нь зүйтэй.



Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулиар иргэд дараах үүрэгтэй.

- Гал, цог, нурмаа бүрэн унтрааж байх;
- Гэр, байшин, бэлтгэсэн өвс, худаг, малын хашаа, саравчны эргэн тойронд хамгаалалтын зурвас хийх;
- Үнс, нурмаа тусгай таглаатай нүх, саванд хийх;
- Түймрээс сэргийлэх, хамгаалах арга ажиллагааг эзэмшсэн байх, хүүхэд багачууддаа сэрэмжлүүлэн сургах;
- Түймрийн аюултай үед хүүхдийг ой, хээрт шүдэнз, асаагуур зэрэгтэй явуулахгүй байх;
- Түймэр унтраах багаж хэрэгсэлтэй байх;
- Түймэр гарсан талаар яаралтай мэдээлэх;
- Түймэр унтраах ажиллагаанд оролцох.

Санамж. Гал түймэр гарсан тохиолдолд иргэн хүн өөртөө авах арга хэмжээ:

- түймэр унтраахдаа нийлэг эдлэлээр хийсэн, хялбар шатах хувцас өмсөхгүй байх;
- гэрт байгаа хүмүүс, мал амьтан зэргийг гэр хашаанаас гаргаж, аврах боломжийг яаралтай шийдэх;

- гарцаагүй түймэр орж ирж байгаа тохиолдолд юуны өмнө ойр орчинд байгаа өвс, ургамалгүй халцгай газарт гарах, ойролцоо нуур цөөрөм, худагт орох, хэрвээ боломжгүй бол үстэй дээлийг усанд дүрээд үсийг нь гадагш харуулж нөмрөөд түймрийн чиглэлийн эсрэг харж хэвтэх, зузаан эсгий гутал, ноосон хөнжил, малын арьс зэрэг удаан шатах зүйл нөмрөн нүүр гарын ил хэсгийг сайтар далдлах;
- гэрийн бүрээсийг усаар норгох, байгалийн саад ашиглан амдуулан цурам тавих;
- хөдөө хээр явж байгаад түймэр таарвал өөдөөс нь угтуулан цурам тавьж, шатсан талбайд орж өөрийгөө хамгаалах;
- гэрт байгаа үнэт зүйлс, мөнгө төгрөг, бичиг баримтаа биедээ авч гэрээсээ гарах, гэрийнхээ өрхийг бүтээж, хаяаг буулгаж, хаалгыг сайн хаах. (Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа гарын авлагаас, хуудас 22-23)

Ан амьтан. Ахуйн хэрэгцээндээ зориулан ан амьтан агнах, барих бол төлбөр төлж, сумын Засаг даргаас эрхийн бичиг авах хэрэгтэй. Гэхдээ дараах шаардлагыг хангасан байхыг шаарддаг.

- зөвшөөрлийн хураамж төлсөн байх;
- хуульд заасан агнах, барих хугацааны дотор;
- агнуур хийх бүс нутгаа байгаль хамгаалагчаар заалгасан байх;
- тухайн жилд агнахаар зөвшөөрөгдсөн амьтдын тоо хязгаарт багтаж байх;
- хориглосон арга, зэвсэг хэрэгсэл хэрэглэхгүй байх.

Ан агнуурын тухай хуулиас:

Ан
амьтныг:

- химийн бодис ашиглах, тэсэлж, дэлбэлэх
- жим дээр нь нүх ухах, буу сойх, занга, сааль тавих
- туурайтан амьтныг агнахдаа цасанд умбуулах, мөсөнд халтиргах, хясаа, эрэг, ганга руу нисгэх, хавх тавих
- тарвагыг нүхэнд нь утах, ус цутгах, хавх, урхи тавих, нохойгоор зориуд бариулах
- агаарын болон тээврийн хэрэгслээр хөөх, гэрэлтүүлэх
- загас барихад буу, бамбар, цахилгаан гүйдэл, хаалт, хашилга, гувчуур хэрэглэх
- ахуйн хэрэгцээнд загас барихад тор хэрэглэх
- ан агнах зориулалтын бус буу, сум ашиглах
- гол, мөрөнд бүх төрлийн завиар загасчлах

аргаар
агнах,
барихыг
хориглоно.

2. Монгол Улсад хэн газар өмчлөгч вэ?

*Миний нутгийн шорооноос
Бурхан гуйсан г брр өг*

Хүн төрөлхтөн тэр дундаа Монголчууд бид эртнээс газрыг эх, тэнгэрийг эцэг мэт хэмээн зүйрлэн шүтэж дээдлэж ирсэн билээ. Газар нь бидний оршин тогтнохын эх үндэс юм. Ийнхүү эх болсон газраа зөв зохистой амьдрал ахуйдаа ашиглахын үүднээс төрөөс газрын талаарх хууль, дүрэм журам гарган зохицуулж байдаг.

Монгол Улсын хил хязгаарын доторх газар нутгийг зөвхөн Монгол Улсын иргэнд л өмчлүүлж болохыг Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудад заасан байна. Газрыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, аж ахуйн нэгж, байгууллага өмчлөх эрхгүй.

Тохиолдол:

Монгол Улсын иргэн Дулмаа гадаадын иргэнтэй гэр бүл болсон бөгөөд нөхрийнхөө нутагт амьдарч байгаад буцаж эх орондоо ирснийхээ дараа гэр бүлийнхээ хэрэгцээнд газар өмчлөх эрхтэй эсэх талаараа хуульчаас асуужээ.

Энэ тохиолдолд хэрвээ тухайн иргэн Монгол Улсын харьяат хэвээрээ байгаа бол бусад иргэдийн нэгэн адил гэр бүлийн хэрэгцээндээ газар өмчлөн авах тэгш эрхтэй. Харин гэр бүлийнх нь хүн болох гадаадын иргэний хувьд газар өмчлөх эрхгүй юм.

Газар өмчлөх гэдэг нь тухайн газрыг захиран зарцуулах эрхтэйгээр хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ. Газрыг гэр бүлийн хэрэгцээний ба аж ахуйн хэрэгцээний гэсэн 2 зориулалтаар өмчлүүлдэг.

Бид хэдий хэмжээний газрыг өмчилж болох вэ?

Газрын байршил, зориулалтаас хамааран дараах хэмжээний газрыг гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулан нэг удаа үнэгүй өмчлөн авах боломжтой.

Иргэнд өмчлүүлэх газар			
	Байршил	Хэмжээ /га/	Хэмжээ м ²
1	Нийслэлд	0.07 хүртэл га	20х35м ²
2	Аймгийн төвд	0.35 хүртэл га	35х100м ²
3	Сумын төв, тосгонд	0.5 хүртэл га	50х100м ² хүртэл
4	Нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай авто замын дагуух газарт /сумын төвөөс бусад/	0.07 хүртэл га	20х35м ²

Тохиолдол:

Иргэн Доржийн хүү нь эхнэр, хүүхдийн хамтаар гадаадад олон жил ажиллаж амьдарч байгаа. Өөрсдөө ойрын үед буцаж ирэхгүй бол тэдний нэр дээр байдаг хашаа байшингийн газрыг нь хэрхэн өмчилж авах вэ?

Хэрвээ хүүгийнх нь өрхийн бүртгэл тусдаа бол тэрээр иргэний журмаар итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан газар өмчлөх эрхээ хэрэгжүүлж болно. Иймд иргэн Дорж нь албан ёсны итгэмжлэлийн үндсэн дээр хүүгээ төлөөлөн түүний гэр бүлийнх нь газар өмчлөх эрхийг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авах боломжтой.

Монгол Улсын иргэд тариалангийн талбай болон атаршсан газрыг газар тариалан эрхлэх зорилгоор өмчилж болдог. Тариалангийн газрыг эзэмшиж байгаа иргэнд нь давуу эрхтэйгээр эсвэл дуудлага худалдаагаар худалдах замаар өмчлүүлдэг.

Өмчлөх газраа сонгохдоо дараах зүйлийг анхаарах хэрэгтэй.

- Тухайн өмчлөх газар нь тухайн нутаг дэвсгэрийн засаг захиргааны байгууллагаас баталсан жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан байршилд байх;
- Бусдын хууль ёсоор өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцаагүй байх;
- Тусгай хэрэгцээ, бэлчээр, нийтийн эдэлбэр газарт хамаарагдахгүй байх;
- Өндөр хүчдэл, үер усны аюулд өртөхгүй байх болзлыг хангасан байна.

Газар өмчилж авснаар хуулийн хүрээнд газраа барьцаалж, түрээслүүлэх, худалдаж захиран зарцуулах зэргээр өмчийн харилцаанд оруулж болох давуу талтай юм. Энэ талаар газар өмчлөгч иргэний эрхээс харцгаая.

Газрын тухай хуульд зааснаар газар өмчлөгч нь дараах эрхийг эдэлдэг.

1. Хуулиар олгогдсон хэмжээ, хязгаарын дотор өмчийнхөө газрыг эзэмших, ашиглах, худалдах, арилжих, өвлүүлэх, бэлэглэх зэргээр захиран зарцуулах;
2. Бусдад эзэмшүүлэх, ашиглуулах;
3. Өмчийн газрыг нийтийн эдэлбэр, тусгай хэрэгцээнд түр ашиглуулахад харилцан тохиролцсоны дагуу зохих төлбөр авах;
4. Өмчийн газрынхаа түгээмэл тархацтай ашигт малтмалыг гэр бүлийнхээ хэрэгцээнд ашиглах, уг газарт худаг гаргаж усыг ашиглах;
5. Өмчийнхөө газарт барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ барих, ашиглах;
6. Өмчийнх нь газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн солих буюу эргүүлж авсан тохиолдолд нөхөх олговор авах.



Нийгмийн харилцаанд оролцож буй иргэн нь хуулиар олгогдсон эрх эдэлж байгаа бол мөн үүрэг хүлээх нь зайлшгүй юм. Иймд газар өмчлөгч нь дараах үүргийг хүлээдэг.

1. Газрын талаарх хууль тогтоомж, төрийн шийдвэрийг биелүүлэн сахих;
2. Тариалангийн зориулалтаар газар өмчилж байгаа бол тэр зориулалтаар нь ашиглах;
3. Өмчилж авсан газраа кадастрын болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд, өмчийн газраа бусад иргэдийн өмчлөлд шилжүүлэх, бусдад эзэмшүүлэх, ашиглуулахтай холбогдсон болон барьцааны гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх;
4. Өмчийн газар дээр нь байрлуулсан заагийн болон геодезийн цэг, тэмдэгтийг хамгаалах, бүрэн бүтэн байлгах;
5. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч бусад иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хохироохгүй байх, өмчийн газар дээрээ хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх;
6. Газрын төлөв байдал, чанарыг дордуулан муутгахгүй байх;
7. Өмчийнхөө газрыг ашиглах явцад барилгын, экологийн, ариун цэврийн, эрүүл ахуйн, галын аюулгүй байдлын болон бусад холбогдох стандарт, дүрэм, журам, шаардлагыг сахиж мөрдөх;
8. Өмчийн газрынхаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн зардлаар 5 жил тутамд эрх бүхий байгууллагаар хийлгүүлж байх.

Өмчлөн авсан газраа анх өмчлөн авсан зориулалтаар нь бусад хүмүүст эзэмшүүлж, ашиглуулж болно. Ингэхдээ холбогдох сум, дүүргийн Засаг даргад хандан хүсэлт гаргаж, зөвшөөрлийг нь авна. Уг хүсэлтэд 18 нас хүрсэн гэр бүлийн гишүүн бүр буюу бусад хамтран дундаа эзэмшигчид гарын үсгээ зурсан байх хэрэгтэй. Мөн уг газрыг нь эзэмших, ашиглах этгээдтэй гэрээ байгуулан нотариатчаар гэрчлүүлсэн байх ёстой.

Иргэний газар өмчлөх эрх нь дуусгавар болох тохиолдлуудыг хуульд заасан байдаг. Үүнд:

1. өмчийн газраа бусад иргэний өмчлөлд шилжүүлснээр;
2. газар өмчлөх эрхээсээ татгалзсанаар;

3. газар өмчлөгч иргэн Монгол Улсын харьяатаас гарснаар;
4. хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

Хэрвээ иргэн газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд нь төрийн байгууллага, албан тушаалтан хууль бусаар саад учруулсан гэж үзвэл тэдгээрийн дээд шатных нь байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй. Гомдлыг хянан шийдвэрлэж хариу өгөхгүй 30 хоновол тухайн иргэн шүүхэд хандан гомдол гаргаж болно.

Энэхүү өргөдлийг шинээр газар өмчилж авахыг хүссэн иргэн гаргана.

ГХГЗЗГ-ын даргын 200 ... оныдугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН ГАЗАР ӨМЧИЛЖ АВАХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

.....аймаг /нийслэл/-ийнсумын газрын даамал /дүүргийн
Газрын алба/-д

Өргөдөл гаргагчийн:

1. Овог
2. Эцэг/эх/-ийн нэр
3. Нэр
4. Иргэний үнэмлэхийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--
5. Регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--
6. Төрсөн аймаг, хот сум, дүүрэг
7. Үндэс угсаа
8. Оршин суугаа газрын хаяг
9. Утасны дугаар /ажил/ /гэр/ /хөдөлгөөнт утас/
10. Электрон шуудангийн хаяг
11. Өмчилж авах газрын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн харьяалал, байршил
12. Өмчилж авахыг хүссэн газраа эзэмшиж байсан эсэх:
13. Хүсэлт гаргасан газрын нийт хэмжээ:
Урт м, Өргөн м, Талбайм² /га/
.....
(Талбайн хэмжээ геометрийн зөв биш дүрстэй бол тайлбарыг бичнэ.)

Та “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль”-ийн 20 дугаар зүйлд зааснаар дараах баримт бичгийг өргөдөлдөө заавал хавсаргана:

1	Иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	
2	Оршин суугаа баг, хорооны Засаг дарга /тосгоны захирагч/-ын тодорхойлолт	
3	Газрын тухай хуулийн дагуу газар эзэмшиж байгаа бол газар эзэмших эрхийн гэрчилгээ, газар эзэмших гэрээний эх хувь	
4	Хүсэлт гаргасан газрын байршил, хэмжээг харуулсан тойм зураг	

(Хавсаргасан баримт бичгийн ард “√” гэж тэмдэглэнэ үү.)

Өргөдөлд хуудас баримт бичиг хавсаргасан болно.

Өргөдөл хүлээн авсан:

..... аймаг /нийслэл/-ийн
 сум /дүүрэг/-ын
 газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан
овогтой
 хүлээн авч, өргөдөл
 бүртгэлийн –д бүртгэв.

/гарын үсэг/

Өргөдөл гаргасан:

.....

/гарын үсэг/

20 ____ оны ____ сарын ____ өдөр

3. Газар эзэмших, ашиглах

*Газар рндсээр баян
 Мэнгэр одоор баян
 Далай усаар баян*


Тохиолдол:

Иргэн Бадарч хэсэг нөхөдтэйгөө хамтран хоршоо байгуулсан бөгөөд тэд хоршооныхоо үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг явуулах газар өмчлөхийг хүссэн боловч орон нутгийнх нь засаг захиргаа татгалзсан бөгөөд харин дараах зөвлөгөөг өгсөн байна.

Үндсэн хууль, Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд заасны дагуу газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд хувь хүнийх нь хувьд өмчлүүлдэг. Харин хоршоо, компани зэрэг бизнесийн, мөн төрийн болон төрийн бус байгууллага нь газрыг зөвхөн эзэмших, ашиглах эрхтэй. Иймд хоршооныхоо нэр дээр газар эзэмших ашиглах хүсэлтээ Засаг даргад хандан гаргаарай гэжээ.

Газрын тухай хуульд зааснаар зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага газар эзэмших эрхтэй. Газар эзэмших гэдэг нь газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг хэлнэ.

Газар эзэмшихийг хүссэн иргэд нь:



Иргэд газрыг гэр бүлийнхээ хамтын хэрэгцээний зориулалтаар эзэмших ёстой. Тухайн газрын хэмжээ нь:

- Иргэд 0,07 га хүртэлх хэмжээний газрыг хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмших боломжийг хуулиар олгожээ.
- Хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0,1 га-гаас илүүгүй газрыг мөн үнэ төлбөргүй эзэмшиж болно.
- Газар тариалангийн салбарт олон жил тогтвор суурьшилтай ажилласан иргэд үр тариалангийн зориулалтаар 100 га хүртэл,

төмс хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл хэмжээний газрыг эзэмших боломжтой.

Харин аж ахуйн нэгжид үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх газрын дээд хэмжээг Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор тогтоожээ.

Эзэмшүүлэх газрын ашиглалтын зориулалт	Бүс нутаг	
	Аймагт	Улаанбаатар бүс
Үр тариа, тэжээлийн ургамал тариалах	20000 га хүртэл	200 га хүртэл
Төмс, хүнсний ногоо, бусад ургамал тариалах	200 га хүртэл	5 га хүртэл
Байгалийн хадлан бэлтгэлийг дагнан эрхлэх	1500 га хүртэл	100 га хүртэл
Дотоодын хэрэгцээндээ зориулан хадлан бэлтгэх	400 га хүртэл	50 га хүртэл
Хот, тосгон, бусад суурины газрын хилийн заагийн гаднах уурхайн эдэлбэр ашиглагчдад эзэмшүүлэх газрын хэмжээ	5000 га хүртэл	
Хот, тосгон, бусад суурины газрын хилийн заагийн гаднах уурхайн эдэлбэр ашиглагчдад эзэмшүүлэх газрын хэмжээ	25.0 га хүртэл	

Газар эзэмшигчийн эдлэх эрх:

1. зориулалтынх нь дагуу газраа эзэмшиж, ашиглах;
2. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;
3. газарт учирсан хохирлыг гэм буруутай хүнээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;
4. Засаг даргын зөвшөөрөлтэйгээр газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, ашиглуулах;
5. гэрээгээ сайн биелүүлж ирсэн бол гэрчилгээнийхээ хугацааг сунгуулах;
6. газар эзэмших эрхээ барьцаалах.

Газар эзэмшигчийн хүлээх үүрэг:

1. газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;
2. газрын төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх;
3. хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;
4. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх;
5. бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
6. эрхийн гэрчилгээгээ барьцаалах, шилжүүлэх тохиолдолд улсын бүртгэлд бүртгүүлэх.



Газраа насаараа эзэмшиж болох уу?

Газар эзэмших хугацаа нь 15-60 жил хүртэл байна. Эрхийн гэрчилгээг нэг удаад сунгах хугацаа 40 жилээс илүүгүй байна. Газар эзэмшигч нь нас барсан бол өв залгамжлагч нь хүсвэл гэрчилгээг нэр дээрээ шилжүүлэн, газрыг үргэлжлүүлэн эзэмшиж болно.

Гэрчилгээгээ сунгуулахыг хүсвэл хугацаа нь дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргана.

Хүсэлтэндээ хавсаргах бичиг баримт:

- Газар эзэмших эрхийн гэрчилгээ
- Газрын төлбөрийг төлсөн тухай баримт
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр гарсан дүгнэлтийг хэрэгжүүлсэн талаарх тодорхойлолт.

Газар эзэмших эрхийн гэрчилгээг Засаг дарга дараах тохиолдолд хүчингүй болгоно.

- Эзэмшигч нь газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;
- Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;
- Шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй;
- Газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;
- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй.

ГХГЗЗГ-ын даргын 200... оны
дугаар тушаалын 5 дугаар хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХЫГ ХҮССЭН ИРГЭНИЙ ӨРГӨДӨЛ

_____ аймаг /нийслэл/-ийн _____ сумын газрын даамал /дүүргийн Газрын алба/-д

ӨРГӨДЛИЙН УТГА /холбогдох утгын өмнөх дугаарыг дугуйлна уу/					
1. шинээр газар эзэмших			6. газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгуулах		
2. шинээр газар ашиглах			7. эзэмшил газраа бусдад ашиглуулах		
3. газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх			9. газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах		
4. газар эзэмших эрхийн гэрчилгээгээ барьцаалах					
5. газар ашиглалтын зориулалт өөрчлүүлэх					
ӨРГӨДӨЛ ГАРГАГЧИЙН Талаарх МЭДЭЭЛЭЛ /заавал бөглөх хэсэг/					
1. Харьяалал /аль улсын/			3. Эцэг /эх/-ийн нэр		
2. Овог			4. Нэр		
5. Иргэний үнэмлэхийн дугаар.			6. Регистрийн дугаар		
7. Харилцах утас:			8. Шуудангийн хаяг:		
9. Байнгын оршин суугаа хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/ баг /хороо/ гудамж /хороолол/ байр /хашаа, хаалга/-ны дугаар					
9. Электрон шуудангийн хаяг:					
Хамтран эзэмшигчдийн мэдээлэл /зөвхөн хамтран эзэмшигчтэй тохиолдолд бөглөнө/					
д/д	Эцэг /эх/-ийн нэр	Нэр	Эзэмшигчийн хэн болох	Иргэний үнэмлэхийн дугаар	Регистрийн дугаар
1					
2					
Иргэний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн талаарх мэдээлэл /хамтран эзэмшигчид байгаа тохиолдолд тэдгээрийг хэн нэгэн төлөөлөх бол бөглөнө/					
1. Овог:			4. Регистрийн дугаар:		
2. Эцэг /эх/-ийн нэр:			5. Албан тушаал:		
3. Нэр:			6. Холбоо барих утас:		
Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ нөхөн авах /зөвхөн энэ тохиолдолд өмнөх дугаарыг бөглөнө/				1. Гэмтээсэн 2. Үрэгдүүлсэн	

НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

1. Нэгж талбарын дугаар:
2. Газрын байршлын хаяг: аймаг /нийслэл/, сум /дүүрэг/
 . баг /хороо/ гудамж /хороолол/ байр /хашаа, хаалга/-ны дугаар . .
 байршлын нэр

Шинээр газар эзэмших, ашиглах:

- | | |
|---|---|
| 1. Газрын зориулалт: | 2. Тухайн газрыг эзэмших, ашиглахын аль нь болох. |
| 3. Талбайн хэмжээ (m^2/ga): | 4. Эзэмших, ашиглах хугацаа: |

Өөрчлөлт оруулах:

1. Барьцаалах: Эхлэх огноо: Дуусах огноо:
 Барьцаалах иргэн, хуулийн этгээдийн нэр:
2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх: 2.1. Бүхэлд нь 2.2. Хэсэгчлэн
3. Эзэмшиж, ашиглаж буй газартаа өөрчлөлт оруулах: 3.1. Нэмэх 3.2. Хасах
4. Газар эзэмших, ашиглах гэрээ, гэрчилгээний хугацаа сунгуулах: Хугацаа: . . . жил/сар
5. Газар ашиглалтын зориулалт өөрчлүүлэх:
6. Эзэмшил газраа бусдад ашиглуулах: Эхлэх огноо: Дуусах огноо:
 Ашиглах иргэн, хуулийн этгээдийн нэр:

ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ ШИЛЖҮҮЛЭН АВЧ БАЙГАА ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД

1. Харьяалал /аль улсын/: 2. Овог:
3. Эцэг /эх/-ийн нэр: 4. Нэр/хуулийн этгээдийн оноосон нэр:
5. Иргэний үнэмлэх /улсын бүртгэлийн гэрчилгээ/-ийн дугаар:
6. Регистрийн дугаар:
- | | |
|-------------------|---------------------|
| 7. Харилцах утас: | 8. Шуудангийн хаяг: |
|-------------------|---------------------|
9. Байнгын оршин суугаа хаяг: аймаг /нийслэл/, сум /
 дүүрэг/ баг /хороо/ гудамж /хороолол/ байр /
 хашаа, хаалга/-ны дугаар

ӨРГӨДӨЛ ГАРГАСАН: / / _____ он _____ сар _____ өдөр

Газар ашиглах

Тохиолдол:

Иргэн Бат болон тэдний орон сууцанд амьдардаг хөршүүд нь хамтран байрныхаа хүүхэд багачуудад зориулан тоглоомын талбай, ахмад настнууддаа амрах сүүдрэвч байрныхаа хажууд барих хүсэлтэй бөгөөд газрынх нь асуудлыг хэрхэн зохицуулах талаар зөвлөгөө хүссэн байна.

Газар ашиглах гэдэг нь хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг хэлнэ. Газар өмчлөгч, эзэмшигч нь газраа ашиглах эрхтэй, харин газар ашиглагч нь өмчлөх, эзэмших эрхгүй.

Дээрх тохиолдолд байрных нь сууц өмчлөгчдийн холбоо /СӨХ/ харьяа Засаг даргадаа хандан газар ашиглах хүсэлтээ гаргах боломжтой.

Хүсэлтдээ дараах зүйлсийг тусгана.

- Сууц өмчлөгчдийн холбооны оноосон нэр, хаяг, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын тодорхойлолт;
- Тухайн орон сууцны байршил, хаяг;
- Ашиглахыг хүсч байгаа газрын зориулалт, хэмжээ, зааг, байршил, нэгж талбарыг харуулсан тойм зураг.

Газар ашиглахдаа хуулиар заасан шаардлагыг биелүүлж байх хэрэгтэй юм. Үүнд дараах шаардлагууд байдаг.

- Газрыг үр ашигтай, зохистой ашиглан хамгаалах;
- Газрын төлөв байдал, чанарыг хадгалах, муудахаас урьдчилан сэргийлэх, нөхөн сэргийлэх;
- Ашигт малтмал ашиглахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;
- Ойн төгөл, ховор амьтан, ургамал, түүх соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах.

Холбогдох зөвшөөрөлгүйгээр гадаадын иргэн, байгууллагад газраа ашиглуулсан Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших, ашиглах гэрээг цуцалж, хохирлыг нөхөн төлүүлдэг.

4. Бэлчээрийн газар, хадлан

*Зуд нэг жилийнх
Журам мянган жилийнх
Нэг нутагтай
Нийлэж бэлчээртэй*

Тохиолдол:

Нэг гол усанд айл саахалт олон жил явсан нутгийн иргэд болох Дорж, Дондов нарын хооронд маргаан гарчээ. Дорж гуай: энэ жил шинэ өвөлжөө барихаар товлож байсан газарт маань Дондов хонио оруулж идүүллээ, манайх энэ хавиар байнга нутаглаж ирснийг мэдсээр байж гэжээ. Харин Дондов гуай: хэдийгээр Дорж олон жил энэ хавьд өвөлжиж байгаа ч энэ түүний өмчийн газар биш, өвсний гарц муу байгаа жил малаа бэлчээхээс өөр арга алга гэжээ. Тэдний маргааныг хэн шийдвэрлэх вэ?

Монголчууд эртнээс нааш нүүдлийн мал аж ахуй эрхлэн өвсний сортой газрыг шилэн нүүдэллэж малаа маллаж, хадлангаа бэлтгэж ирсэн ард түмэн. Бэлчээр, хадлангийн асуудал нь уламжлалт зан заншлын хэм хэмжээгээр зохицуулагдаж ирсэн хэдий ч өнөө үед энэ асуудал нь төрийн хууль тогтоомжоор зохицуулагдах зайлшгүй шаардлагатай тулгарсан тул энэ талаарх зарим харилцааг хуульчлан зохицуулжээ.

Мал, амьтан бэлчээх зориулалттай байгалийн болон таримал ургамлын нөмрөг бүхий хөдөө аж ахуйн газрыг “бэлчээр”-ийн газар гэж хуульд заасан байна.

Ард иргэд бэлчээрийн газраа зөв зохистой ашиглан, зохицуулах эрхээ иргэдийн Нийтийн хурал, иргэдийн Төлөөлөгчдийн хурлаараа дамжуулан эдлэх боломжтой. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн нутаг орныхоо онцлог, шаардлагыг харгалзан газар зохион байгуулалтын төлөвлөгөөндөө өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаа, отрын нөөц нутаг гэсэн ерөнхий хуваарийг тусгана. Бэлчээрийн газрыг өмчлөх боломжгүй. Зуслан, намаржаа болон отрын бэлчээрийг баг, хот айлаар хуваарилж нийтээр ашиглана.

Мөн өвөлжөө, хаваржааны доорх газрыг хот айлаар дундаа хамтран эзэмшиж болно.

Сум, дүүргийн Засаг дарга тухайн жилийн бэлчээрийн өвс, ургамлын гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг тогтоож мөрдүүлнэ. Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг талхлагдахаас хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор тухайн нутгийн онцлог, бэлчээр ашиглаж ирсэн уламжлал, газрын даац, чадавхийг харгалзан малчдад хэсэг бүлгээр нь ашиглуулах гэрээг сумын Засаг дарга байгуулж болно. Ингэхдээ иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэнэ.

Ган, зуд зэрэг байгалийн гамшгийн улмаас малчид зэргэлдээ болон өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүж, үүнээс үүдэн маргаан гарах тохиодол ч байдаг. Өөр сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлагын талаар тухайн сумдын, өөр аймгийнх бол аймгийн Засаг дарга нар хэлэлцэн шийдвэрлэх ёстой. Хэрэв уг асуудлаар тохиролцож чадахгүй бол аймгийн Засаг дарга эсвэл Засгийн газар шийдвэрлэнэ.

Бэлчээрийн талаар гарсан маргааныг багийн нийт иргэд оролцон шийдвэр гаргах эрхтэй өөрөө удирдах байгууллага болох иргэдийн Нийтийн хурлаараа хэлэлцэн зохицуулна. Эс тохиролцвол сумын Засаг дарга маргааныг шийдвэрлэнэ.



Сум, дүүргийн Засаг дарга тухайн жилийн хадлан авах

бололцоотой талбайг ашиглуулахаар иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн хуваарилж, хэрэгжилтийг зохион байгуулна. Мөн сумын Засаг дарга хадлангийн талбайд газар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийг ханган ажиллах ёстой. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага сум, дүүргийн Засаг даргатай тохиролцон бэлчээрийн ургацтай хэсгийг хадлангийн талбай болгон ашиглаж болно. Энэ нь газрын нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн газарт хамаарахгүй. Мөн ийнхүү нэгдмэл сангийн ангилалд бүртгэгдсэн хадлангийн талбайд 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хадлан авч дуустал мал бэлчээхийг хуулиар хориглодог. Хадлангийн талбайг усалгаатай болгох, хамгаалах, бордох, ойн зурвас тарих зэргээр сайжруулан, ургацыг нь тогтвортой дээшлүүлсэн иргэн, байгууллагад уг талбайг Засаг даргын шийдвэрээр эзэмшүүлж болно.



III. ГЭР БҮЛ-ХУУЛЬ

1. Эцэг, эх, хүүхдийн харилцаа
2. Эцэг, эх байх эрхийг хязгаарлах ба хасах
3. Гэрлэлт цуцлах
4. Хүүхэд үрчлэх



Эцэг, эх, хүүхэд нь бие биенийхээ өмнө эрх эдэлж, үүрэг, хариуцлага хүлээдэг. Гэр бүлийн харилцаан дахь гишүүдийн оролцоо, эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хуулиар хамгаалдаг.

III. ГЭР БҮЛ - ХУУЛЬ

1. Эцэг, эх, хүүхдийн харилцаа хэрхэн үүсэх вэ?

*Отолтол жаргая гэвэл үрээ сурга
Ургэлжид жаргая гэвэл явдлаа жигээ*

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд гэрлэгчид гэр бүлээ төлөвлөхөд тэгш эрхтэй байхаар заажээ.

Гэр бүл төлөвлөлт гэдэг нь хүүхэд төрүүлэх, хүүхэдтэй болох явдлыг гэрлэгчид төлөвлөн зохицуулахыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, төрүүлэх хүүхдийн тоо, насны зөрүүг тодорхойлох эрхийг эхнэр, нөхөр адил хэмжээнд шийдвэрлэхийг ойлгох юм. Мөн түүнчлэн эцэг, эх болох асуудлыг ухамсартайгаар шийдвэрлэх нь гэр бүлийн төлөвлөлтөд хамаарах юм. Гэр бүл төлөвлөлт нь эхийн хэвлийд хүүхэд олохоос эхлэн тээж төрүүлэх, жирэмслэлтээс сэргийлэх зэрэг нөхөн үржихүйн үйл ажиллагаанд хяналт тавьж, гэр бүлд хүүхэд төрүүлэх, эс төрүүлэхэд оршиж байдаг.

Гэр бүлд хүүхэд төрснөөр эцэг, эх хүүхдийн хооронд эрх, үүрэг үүснэ. Мөн түүнчлэн хүүхдийг үрчлэн авснаар, дагавар хүүхэд хойт эцэг, хойт эхийн хооронд эцэг, эх хүүхдийн харилцаа үүснэ.

Тохиолдол:

Иргэн Энхнасан 2010 оны 3 дугаар сарын 13-ны өдөр төрсөн охин Сугарын эцгээр Болорыг тогтоолгож, тэтгэлэг гаргуулахыг хүсчээ. Энхнасан Болортой 2008 онд танилцсан бөгөөд цаашид амьдрах хүсэлтэй байсан. Болор хүүхэд төрөх хүртэл хэвийн харилцаатай байснаа хүүхэд төрсний дараа ер үзэгдэхээ больжээ. Болор нь эхнэр хоёр хүүхэдтэйгээ амьдардаг болохыг Энхнасан олж мэдсэн байна.

Амьдралд эцэг, эх гэрлэлтээ бүртгүүлээгүй атлаа хүүхэд төрүүлэх явдал элбэг тохиолддог. Энэ үед хүүхдийн эцэг, эхийг тогтоох асуудал гарч ирнэ.

Гэр бүлийн тухай хуульд зааснаар хүүхдийн эцэг, эхийг 2 журмаар тогтоож болохоор заажээ.

Хүүхдийн эцэг, эх мөн эсэх талаар маргаантай байгаа, гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн хүүхэд хэний хүүхэд болохыг тогтоолгох талаар хамтарч өргөдөл гаргахаас татгалзсан тохиолдолд хүүхдийн эцэг, эхийг шүүхийн журмаар тогтооно.

Шүүхийн журмаар хүүхдийн эцэг тогтоолгох тухай хүсэлтийг хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, төрөл садангийн хүн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, 14 нас хүрсэн хүүхдийн аль нэг нь гаргах эрхтэй бөгөөд шүүх онцгой ажиллагааны журмаар эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоох хэргийн бүрэлдэхүүнд багтаан шийдвэрлэнэ. Ийм учраас дээрх тохиолдолд охины эцэг Болор өөр гэр бүлтэй эсэхийг үл харгалзан Энхнасан шүүхэд хүсэлт гаргах эрхтэй.

Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ хариуцагч нь хүүхдийн эцэг мөн эсэхийг тогтооход зайлшгүй шаардлагатай нотолгооны хэрэгсэл болох нэхэмжлэгч, хариуцагчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл болон эд мөрийн баримт зэргийг харгалзан үзнэ.

Хүүхдийн эцэг, эх биш, мөн хэмээн маргаж байгаа талууд өөрсдөө нотлох баримтаа гаргаж өгөх үүрэгтэй.

Шүүх хүүхдийг төрөхөөс өмнө буюу төрсний дараа эцэг, эх нь хамт амьдарч, эр эмийн харилцаатай байсан эсэх, хамтран гэр ахуйн ажлыг гүйцэтгэж, хүүхдийг өсгөж хүмүүжүүлэхэд оролцож байсан эсэхийг нотолсон нотлох баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэнэ.

Нэхэмжлэгч, хариуцагчийн аль нэгний хүсэлт гаргаснаар шаардлагатай бол шинжээч томилж дүгнэлт гаргуулан шийдвэрлэж болно.

Шинжээчийн дүгнэлтээр хариуцагч нь хүүхэд төрүүлэх (үр тогтоох чадвар) боломжтой эсэх, хүүхдийн болон хариуцагчийн цусны бүлэг тохирч байгаа эсэх, хариуцагчийн эзгүй (албан томилолтоор өөр газар очиж ажиллаж байсан, өвчний улмаас эмнэлэгт хэвтэж байсан, гадаадад суралцсан) байгаа тодорхой хугацаанд хүүхэд олж төрүүлэх боломжтой байсан эсэхийг тогтоолгож болох юм. Тухайлбал: Болор Энхнасантай үерхэж байхдаа хааяа нэг очдог байсан учир охин Сугарыг өөрийн хүүхэд гэдэгт эргэлзэж байна. Тийм учраас эмнэлгийн журмаар шинжилгээ хийлгэх хүсэлт гаргавал шүүгч шинжээч томилсон захирамж гаргах боломжтой.



Захирамжид зааснаар шинжээчид дараах асуултуудыг тавих боломжтой. Үүнд:

- хүүхдийн нүүр царай, гадаад төрх нь нэхэмжлэгч, хариуцагчийн хэнтэй нь адил төстэй байгаа;
- төрөлтийн түүхэнд хүүхдийн эцгийг хэн гэж бичүүлж байсан;
- төрөлтийн түүх, зохигчдын гаргасан тайлбараар хүүхэд олдсон, төрсөн хугацаа тохирч байгаа эсэх;
- хүүхдийн цусны бүлэг хэддүгээр зэрэгт хамаарагдах, энэ нь эцэг, эхийн хэний цусны бүлэгтэй тохирч байгаа;
- 2010 оны 3 дугаар сарын 13-ны өдөр төрсөн Сугарын эцэг Болор мөн эсэх.

Шүүх эцэг тогтоох хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай нотлох баримт цугларч, хүүхдийн эцэг нь Болор мөн гэсэн нөхцөл байдал тогтоогдсон гэж үзвэл шүүх хуралдаанаас хүүхдийн эцэг, эхийг тогтоосон шийдвэр гаргана.

Хүүхдийн эцгийг шүүхээс тогтоосныг хүүхдийн эцэг, эх, эсхүл 16 насанд хүрсэн хүүхэд өөрөө оршин суугаа газрынхаа харьяа сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт өргөдөл гаргаж, шүүхийн шийдвэрийг хавсаргана.

Харин Болор охин Сугарынхаа эцэг мөн гэж хүлээн зөвшөөрвөл гэрлэлтээ бүртгүүлээгүй ч гэсэн эцэг, эхээс хамтарч гаргасан өргөдлийг үндэслэн захиргааны журмаар хүүхдийн эцгийг тогтооно. Өргөдлийн агуулга нь нэг талаас эцэг нь хүүхдийн эцэг мөн гэдгээ өөрөө сайн дураар илэрхийлж байгаа, нөгөө талаас хүүхдийн эх нь түүнийг зөвшөөрч байгаагаар тодорхойлогдоно. Энэ тохиолдолд хүүхэд нь эцгийн хувьд заавал цусан төрлийн холбоотой байхыг шаардахгүй юм.

Хүүхэд нь гэр бүлд дараах эрхтэй байдаг.

- Эрүүл мэнд өсөж бойжих;
- Аюулгүй орчинд амьдрах;
- Хүчирхийллээс ангид байх, гэмт хэрэг, зөрчил болон насанд хүрэгчдийн аливаа зөрчлөөс хамгаалуулах;
- Эцэг, эхтэйгээ хамт амьдрах, тэдний анхаарал халамжид байх;
- Суурь боловсрол эзэмших, төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших;
- Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч эрхийг нь зөрчсөн тохиолдолд тэдэнтэй хууль ёсны харилцаагаа зогсоох, таслах, сэргээх эрхтэй

Эцэг, эх нь хүүхдийнхээ эрх, ашиг сонирхлыг хамгаалах үүрэгтэй.

Хүүхдийн журамт үүрэг:

1. Эцэг эхээ болон бусад хүмүүсийг хайрлах, хүндэтгэх, тэдэнд туслах;
2. Эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалах;
3. Суурь боловсрол заавал эзэмших;
4. Төрийн хууль ёсыг сахиж, ард олны өв уламжлалыг дээдлэн хүндэтгэх, эзэмших;
5. Эрүүл мэндээ хамгаалах;
6. Авъяас чадвараа хөгжүүлэх.

Эцэг, эх - Хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах үүргийг хүлээдэг.

Хүүхдийн өмнө эцэг, эхийн хүлээх үүрэг:

- Эрүүл чийрэг өсгөн бойжуулах;
- Сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх;
- Асран хамгаалах, тэжээн тэтгэх;
- Үндэсний ёсзаншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх;
- Суурь боловсрол эзэмшүүлэх;
- Хөдөлмөрийн анхы дадлага олгох.

Хүүхэд гэр бүл дотор тэгш эрхтэй.

Хүүхэд тухайн гэр бүлд төрсөн, үрчлүүлсэн, дагавар, баталгаагүй гэр бүлд төрсөн эсэхээс үл хамааран гэр бүлд тэгш эрх эдэлнэ.

Эцэг, эх бүр хүүхдийг гэр бүлийн дотор эрүүл чийрэг өсгөн хүмүүжүүлэх, хөгжүүлэх, түүний эрх, ашиг сонирхлыг нь нэн тэргүүнд хамгаалахыг эрхэм болгох үүрэгтэй.

Хүүхэд эд хөрөнгөтэй байх, тэжээн тэтгүүлэх эрхтэй. Гэр бүлийн нэг гишүүнд ногдох эд хөрөнгийн хэмжээ нь хүүхдэд адил тэнцүү байна. *Мөн эцэг, эхийнхээ хайр ивээлд өсөж бойжих, тэдний анхаарал халамжинд байх, эцэг эхтэйгээ хамт амьдрах, сурч боловсрох эрхтэй.*

Хүүхэд нь тухайн гэр бүлийн гишүүн болохынхоо хувьд зөвхөн эцэг, эхтэйгээ биш харин гэр бүлийн бусад гишүүд болох төрөл, садан хүмүүстэй нэгэн адил харилцана. Харин хүүхдийн эрх ашгийг хамгаалах, хангахын тулд дараах этгээдтэй үүсэх харилцаа хуулийн дагуу бий болдог байна.

Үүнд :

- Хүүхэд – Асран хамгаалагч
- Хүүхэд – Харгалзан дэмжигч
- Хүүхэд – Асран хүмүүжүүлэгч

2. Эцэг, эх байх эрхийг хязгаарлах ба хасах

*Биеэ засаад гэрээ зас
Гэрээ засаад төрөө зас*

Тохиолдол:

Төмөр замын гармын ойролцоо байрладаг, хуучин муу байшинд 16 настай Тогтох байнга амьдрах болсон. Тэрээр “манай гэрийн амьдрал хэцүү, аав, ээж архи уудаггүй ч намайг байнга доромжилж зоддог, ажил хийж, мөнгө олж ирэхийг шаарддаг байсан учраас гэрээсээ гарсан. 5 дугаар ангид байхдаа сургуулиас гарсан. Одоо миний төлөө санаа зовох хүн ерөөс байхгүй, өвөлдөө траншейнд очдог” гэж хэсгийн цагдаагийн ажилтанд мэдүүлжээ. Энэ тохиолдолд 16 настай Тогтохын эцэг, эхэд хуулийн ямар хариуцлага тооцох вэ?

Гэр бүлд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, амьдрах эрүүл саруул орчин бүрдүүлэх, нэн шаардлагатай хоол хүнс, орон байр, хувцас, тоглоом бусад зүйлээр хангах, эрүүл чийрэг өсгөн бойжуулах, асран хамгаалах, тэжээн тэтгэх, хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах, суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох үүрэгтэй.

Эцэг, эх нь эрхээ хүүхдийн ашиг, сонирхолд харшаар ашиглах, хүүхэдтэйгээ хэрцгий догшин харилцах, хүүхдийн эрүүл мэнд, сэтгэхүй, ёс суртахууны хүмүүжилд хохирол учруулвал эцэг, эх байх эрхийг хязгаарлах буюу хасах хэлбэрээр хариуцлага тооцохоор хуульд зааж өгсөн байдаг.

Дээрх тохиолдлоос харахад 16 настай Тогтохын эрхийг эцэг, эх нь ноцтой зөрчсөний улмаас тэрээр орон гэрээсээ дайжиж, гудамжинд гарсан төдийгүй халамжийн төвүүдийн хооронд явж байдаг хараа хяналтгүй хүүхэд болжээ. Тийм учраас Тогтохын эцэг, эхэд хуулийн хариуцлага тооцож болно.

Яагаад хүүхдийн эцэг, эх байх эрхийг хязгаарладаг вэ?

Хүүхдийн эцэг эх байх эрхийг хязгаарлах гэдэг нь хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасахгүйгээр эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон хугацаанд хүүхдийг тэднээс тусгаарлахыг ойлгоно.

Энэ нь эцэг, эхтэй хариуцлага тооцож буй нэг хэлбэр мөн боловч хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалж байгаа арга хэмжээ юм.

Гэр бүлийн тухай хуульд зааснаар дараах тохиолдолд хүүхдийн эцэг, эх байх эрхийг хязгаарлана. Үүнд:

- Хүүхдийг орон сууц, хувцас, хоол ундаар байнга, санаатай гачигдуулсан;
- Хүүхдийн хөдөлмөрийг зүй бусаар ашигласан;
- Хүүхдээ гуйлгачлуулсан, орон гэрээсээ дайжуулсан, гадуурхсан.

Эдгээр тохиолдолд тодорхой хугацаанд эцэг, эх нь өөрсдийн буруу үйлдлийг ойлгох, засч залруулах боломж олгодог.

Эцэг, эх байх эрхийг хязгаарлах тухай хүсэлт гаргах эрхтэй этгээдэд хүүхдийн эцэг буюу эх, төрөл садангийн хүн, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах байгууллага, бусад иргэд хамаарна.

Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хязгаарласнаар эцэг, эх нь хүүхдээ биечлэн өсгөн хүмүүжүүлэх, тэднийг төлөөлөх боломжгүй болохын зэрэгцээ хүүхдэд улсаас олгодог тусламж, тэтгэмж авах эрх алдагдана.

Хүүхдийн хувьд эцэг, эхээрээ тэжээн тэтгүүлэх, өөрт ногдох эд хөрөнгөө өмчлөх, өвлөх, орон сууцанд амьдрах зэрэг эрх нь хэвээр хадгалагдана.

Хэрвээ шүүхээс эцэг, эхийн хоёулангийнх нь эцэг, эх байх эрхийг хязгаарласан бол хүүхдийг



асран хамгаалах байгууллагад шилжүүлнэ. Хүүхдийг асран хамгаалахад шаардагдах хөрөнгийг эцэг, эхээс нь гаргуулах ба тэд хөрөнгийн чадваргүй бол сум, дүүргийн Засаг дарга хариуцна.

Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан нөхцөл байдал арилсан нь тогтоогдсон бол эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүний хүсэлтээр шүүх хүүхдийг эцэг, эхэд нь буцаан өгөхөөр шийдвэр гаргаж болно.

Эцэг, эх байх эрхийг хасах

Эцэг, эх байх эрхийг хасах гэдэг нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эрх бүхий байгууллагаас хуульд заасан нөхцөл, журмын дагуу оногдуулж буй хариуцлагын арга хэмжээг хэлнэ.

Эцэг, эх байх эрхийг хасах тухай ойлголт нь дараах онцлог шинжийг агуулна. Үүнд:

- Сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх онцгой ажиллагааны журмаар хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасах тухай хэргийг хянан хэлэлцэнэ.
- Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хасах үндэслэл, нөхцөл, журмыг хуульд тусгайлан зохицуулж өгсөн байдаг учраас зөвхөн хуулиар журамлагдсан ажиллагаа байна
- Хүүхдийн эцэг, эх байх эрхийг хассанаар эрх зүйн тодорхой үр дагавар үүснэ.

Хүүхдийн эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд хүүхдийн эцэг буюу эх нь, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон бусад иргэн хүүхдийн эрх, ашгийг хамгаалах байгууллага хүүхдийн эцэг, эхийн оршин суугаа газрын харьяа шүүхэд гаргана.

Эцэг, эх нь:

- эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан (хүүхдээ хаях, санаатай төөрүүлэх, тарчлаан зовоох, худалдах, барьцаалах, биеийг нь үнэлэх, эрх зүйн зөрчилд татан оруулах);
- хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харилцах;
- бэлгийн харьцаанд оруулахаар завдсан, оруулсан;
- хүүхдээ сэтгэл санааны дарамтад байлгасан;
- хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх үүргээс санаатай зайлсхийсэн;
- мансууруулах, согтууруулах ундаа байнга хэрэглэдэг бол шүүх эцэг, эх байх эрхийг хасна.

Хэрэв эцэг, эх нь хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэц, мэдрэлийн өвчтэйн улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй байхад нь дээрх нөхцөл байдал бий болж хүүхдийн эрх, ашиг хохирдог бол эцэг, эхийг эрх зүйн чадамжгүй, хязгаарлагдмал чадамжтай гэж шүүхээр тооцуулж болно.

Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүн өөрийн зан байдал, амьдралын хэв маягаа өөрчилж, хүүхдийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа ухамсарлан ойлгож, гаргаж байсан буруугаа бүрэн ойлгосон нь тогтоогдвол шүүх эцэг, эх байх эрхийг сэргээж болно. Энэ талаарх хүсэлтийг эцэг, эх байх эрхээ хасуулсан хүн өөрөө гаргана. Шүүх энэхүү хүсэлтийг хүүхдийн саналыг авсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

3. Гэрлэлт цуцлах

*Тэрийн багана жугаражад
Мөрийн багана доригдог*

Тохиолдол:

Оргилон, Хулганаа хоёр 2001 онд танилцаж, 2003 онд гэрлэлтээ бүртгүүлсэн байна. Гэрлэх үедээ тэд 24 настай байжээ. 2010 он гарсаар тэдний хоорондын үл ойлголцох байдал улам даамжирснаар гэрлэлтээ цуцлуулах болсон. Энэ үед эд хөрөнгөө хэрхэн хуваарилах талаар харилцан маргаангүйгээр тохиролцсон бөгөөд 8 настай охин Номин-Эрдэнийг ээж Хулганаа асрамжиндаа авахаар болжээ. Нэгэнт гэрлэлт цуцлуулах, эд хөрөнгө болон хүүхдийн асрамжийн талаар хэн ч маргахгүй, харилцан зөвшөөрсөн учраас гэрлэлтээ бүртгүүлсэн Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн байгууллагад өргөдлөө гаргаж гэрлэлтээ цуцлуулахаар хандсан байна. Тэд нэгэнт гэрлэхдээ хоёулаа харилцан тохиролцсон учраас цашид амьдрах боломжгүй болсон гэдгээ ч харилцан маргаангүй шийдвэрлэх хэрэгтэй гэж ийнхүү шийджээ.

Энэ тохиолдолд гэрлэлт цуцлах үндэслэл, журам, дээрх тохиолдсон асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар авч үзье.


Гэрлэлт цуцлах нь гэрлэлт дуусгавар болох нэгэн үндэслэл бөгөөд түүнийг гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон гэрлэгчдийн хамтын амьдрал тэдний хүсэл зоригийн үндсэн дээр эрх бүхий байгууллагаас тогтоосон журмын дагуу дуусгавар болохыг ойлгоно.

Гэрлэгчид хоёулаа, эсхүл тэдний аль нэгний хүсэлтээр гэрлэлтийн харилцааг зогсоож байгаа үндэслэлийг Гэр бүлийн хуулиар зохицуулж өгсөн байна. Гэрлэгчид сайн дураараа, харилцан зөвшилцөж, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэрлэх ба хамтын амьдралын явцад, цаашид хамтран амьдрах нөхцөл боломжгүй болсон үед ч гэрлэлт цуцлах асуудлыг мөн л өөрсдийн хүсэлтээр шийдвэрлүүлж болно.

Гэхдээ гэрлэлт цуцлах журмыг хуулиар нарийвчлан тогтоож өгсөн байна. Өөрөөр хэлбэл, гэрлэлт цуцлах асуудлыг хуулиар эрх нь олгогдсон эрх бүхий байгууллага гэрлэгчдийн гаргасан нэхэмжлэл, өргөдлийг үндэслэн шийдвэрлэнэ.

Гэр бүл, эх нялхас хүүхдийн эрх ашгийг төр хамгаалах зарчмын дагуу гэрлэгчийг болон хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй тохиолдолд гэрлэлтийг цуцлахыг хориглоно. Мөн түүнчлэн гэрлэлт цуцлах үед хариуцагч нь хүндээр өвчилж, эрүүл мэндийн байдлаас өөрийнхөө эрхийг хамгаалах боломжгүй нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдвол гэрлэлт цуцлахаас эрх бүхий байгууллага татгалзана.

Үүнээс бусад тохиолдолд гэрлэлтээ цуцлуулах хүсэлтийг хөндлөнгийн хэн нэгний оролцоогүйгээр гэрлэгчид өөрсдөө гаргаж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх боломжтой юм.



Гэрлэлтийг захиргааны буюу шүүхийн журмаар цуцална. Өөрөөр хэлбэл, гэрлэлтийг цуцлах эрхтэй байгууллага нь захиргааны байгууллага, эсвэл шүүх байна.

Гэрлэгчид гэрлэлтээ цуцлуулахаар харилцан зөвшөөрсөн, тэдний асрамжид 18 хүртэлх насны төрсөн болон үрчилсэн хүүхэд байхгүй, эд хөрөнгийн болоод бие биеэ тэжээн тэтгэх, тэтгүүлэх талаар маргаангүй тохиолдолд гэрлэлтээ цуцлуулахаар **оршин суугаа газрынхаа сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт өргөдлөө хамтран** гаргана.

Өргөдлөө хамтран гаргаж байгаа нь гэрлэгчид захиргааны журмаар гэрлэлт цуцлуулахаар харилцан зөвшөөрснийг илтгэж байгаа юм. Тэд өргөдөлдөө гэрлэгчдийн овог, эцгийн нэр, нэр гэрлэлтийн гэрчилгээний дугаар болон гэрлэлт цуцлуулах талаар харилцан зөвшөөрсөн байдал, төрсөн болон үрчлэн авсан 18 хүртэлх насны хүүхэдгүй гэдгээ тодорхойлон зааж, түүний нотолсон баримт бичгийг хавсаргана.

Сум, дүүргийн Засаг дарга өргөдлийг хүлээн авч хянаад 30 хоногийн дотор гэрлэлтийг цуцлах эсэхийг шийдвэрлэнэ. Захиргааны журмаар гэрлэлт цуцлахад гэрлэгчдийг биечлэн байлцуулах ба хүндэтгэн үзэх шалтгаанаар гэрлэгчид байлцах боломжгүй бол түүнийг байхгүйд гэрлэлт цуцлахыг зөвшөөрсөн, нотариатаар гэрчлүүлсэн өргөдлийг үндэслэн гэрлэлтийг цуцалсныг бүртгэж, гэрчилгээ олгоно.

Оргилон, Хулганаа нарын хувьд гэрлэлт цуцлуулах талаар харилцан тохиролцсон эд хөрөнгийн талаар маргаангүй байгаа боловч, тэдний асрамжид 8 настай охин байгаа учраас захиргааны журмаар буюу Иргэний бүртгэлийн байгууллагад өргөдөл гаргаж, гэрлэлтээ цуцлуулах боломжгүй гэдэг нь тодорхой байна.

Мөн Монгол Улсын Иргэний бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5-д зааснаар эхнэр, нөхрийн аль нэг нь 3 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн бол нөгөө тал нь гэрлэлтээ цуцлуулах өргөдлөө гаргаж болох бөгөөд хорих ял эдлэх болсныг нотлох шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга гэрлэлтийг цуцалж болно. Энэ тохиолдолд хорих ялаар шийтгүүлсэн этгээд өөрөө хүсэлт гаргах боломжгүй юм.

Түүнчлэн гэрлэгчдийн хэн нэгийг шүүхээс иргэний эрх зүйн эрхийн чадамжгүй гэж тооцсон бол эхнэр, нөхрийн аль нэгний хүсэлтээр шүүхийн шийдвэрийг үндэслэн захиргааны журмаар гэрлэлтийг цуцалж болох талаар мэдэхэд илүүдэхгүй юм.

Гэрлэгчид гэрлэлт цуцлах талаар харилцан тохиролцоогүй, тэдний асрамжинд 18 хүртэлх насны хүүхэд байгаа, эд хөрөнгийн болон тэжээн тэтгэх талаар маргаантай байгаа тохиолдолд шүүх гэрлэлтийг цуцална.

Гэрлэлт цуцлуулах өргөдлөө аль шүүхэд гаргах вэ?

Гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэлийг хариуцагчийн оршин суугаа газрын харьяа шүүхэд гаргах бөгөөд нэхэмжлэгч нь бага насны хүүхэдтэй буюу хөгжлийн бэрхшээлтэй, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас хариуцагчийн байгаа газарт очиход бэрхшээлтэй байвал нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын шүүхэд гаргаж болно.

Мөн түүнчлэн гэрлэгчид маргааныг хэнийх нь оршин суугаа газрын харьяа шүүхээр хянан шийдвэрлүүлэх вэ? гэдгийг харилцан тохиролцон тогтоож болно.

Гэрлэлт цуцлуулах өргөдлөө хэрхэн бичих вэ?

Гэрлэлт цуцлах тухай нэхэмжлэл нь энэ номны “Шүүхээр эрхээ хамгаалуулах нь” бүлэгт заасан бүрдүүлбэрийг хангасан байхаас гадна гэрлэлтээ хэзээ, хаана бүртгүүлсэн, гэрлэлт цуцлах болсон шалтгаан, төрсөн болон үрчлэн авсан хүүхдийн байдал, насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх, тэжээн тэтгэх болон эд хөрөнгийн талаар ямар хүсэлт гаргаж байгаагаа нэхэмжлэлд тодорхойлон бичиж холбогдох нотлох баримтыг хавсаргасан байна.

Гэрлэлт цуцлах хэргийг хянан шийдвэрлэх журам ямар байх вэ?

Шүүх гэрлэлт цуцлах хэргийг хянан шийдвэрлэхдээ насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх, насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах, гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах, гэрлэгч хэн хэнийг тэжээн тэтгүүлэх, орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх

эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулах эрхийг хориглох, шүүхийн зардлын зохих хувийг урьдчилан гаргуулах, 3 сар хүртэл хугацаанд маргалдагч талуудад эвлэрэх боломж олгон хугацаа тогтоож өгөх зэрэг арга хэмжээг авахаар захирамж гаргаж болдог онцлогтой.

Харин гэрлэгчид бие биенээ байнга хүчирхийлж дарамталдаг нь тэдний болон гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учруулж болзошгүй, эсвэл учруулсан нь тогтоогдвол шүүх эвлэрүүлэх арга хэмжээ авалгүйгээр гэрлэлтийг цуцална.

Гэрлэгчид шүүхээс тогтоож өгсөн хугацаанд эвлэрвэл шүүгч эвлэрлийг баталсан захирамж гарган хэргийг хэрэгсэхгүй болгоно. Харин гэрлэгчид шүүхээс тогтоосон хугацаанд эвлэрээгүй бол хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэн гэрлэлтийг цуцлах шийдвэр гаргана.



Шүүхээс насанд хүрээгүй хүүхдийг хэний асрамжинд үлдээх вэ гэдэг асуудлыг шийдвэрлэхдээ эцэг, эхийн тохиролцоог харгалзан үзэх ба тэд энэ талаар тохиролцож чадаагүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн хайр халамж, амьдрал ахуйн нөхцөл бололцоо, эцэг, эхийн ёс суртахууны байдал, 7 (долоо) ба түүнээс дээш насны хүүхдийн саналыг харгалзан үзнэ.

Эцэг, эх нь хүүхдийн асрамжийн асуудлаар хоорондоо санал зөрж байвал, хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс шинжээч томилж, дүгнэлт гаргуулан, холбогдох нотлох баримтын үндсэн дээр энэ асуудлыг шийдвэрлэнэ.

Хүүхдийн тэтгэлгийн асуудлаар гэрлэгчид харилцан тохиролцож тэжээн тэтгэх гэрээ байгуулах боломжтой бөгөөд энэ талаар тохиролцож чадаагүй бол хүүхдийн насны байдлыг харгалзан сар тутам, хүүхэд тус бүрт тэтгэлэг тогтоолгоно.

Гэрлэгчдийн хэн нэг нь гэрлэлт цуцлах үед эсвэл гэрлэлтээ цуцлуулахаас өмнө гэр бүлийн хүчирхийллийн улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, тэтгэвэрт гарсан, гурван нас хүрээгүй болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаагаас хөдөлмөр эрхлээгүй бол гэрлэлтээ цуцлуулсан эхнэр буюу нөхрийн тэжээн тэтгэх асуудлыг шүүх шийдвэрлэж болно.

Гэр бүлийн гишүүн хуваарьт эд хөрөнгөө өөрийн үзэмжээр захиран зарцуулах эрхтэй ба хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахад тэгш эрх эдэлнэ.

Шүүх дараах нөхцөл байдлыг харгалзан хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шийдвэрлэнэ.

Үүнд:

- гэрлэгчдийн эрүүл мэндийн байдал;
- хүүхдийн насны болон эрүүл мэндийн байдал;
- маргаантай байгаа эд хөрөнгийг бий болгоход гэрлэгчдээс оруулсан хөрөнгийн болон хөдөлмөрийн оролцоо;
- гэрлэлт цуцлахад хэний буруу байсан;
- гэрлэгчид хөрөнгөө зүй бусаар нуусан, ашигласан зэрэг байдлыг харгалзан гишүүн тус бүрт оногдох хэсгийг өөрөөр тогтоож болно.

Шүүх гэрлэлтийг цуцлах тухай шийдвэртээ хамтран өмчлөх дундын хөрөнгөөс гэр бүлийн гишүүний хэн, хэнд ямар хөрөнгө ногдохыг тодорхой зааж өгнө.

Гэрлэгчид гэрлэлт цуцалсан тохиолдолд ногдох хөрөнгийг тодорхойлох асуудлыг гэрээний үндсэн дээр тохиролцсон байвал гэрлэгчдийн аль нэгний хүсэлтийг харгалзан эд хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээг биелүүлэх тухай захирамж гаргана.

Гэрлэлт цуцлах хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэж шийдвэр гаргах бөгөөд шийдвэр хүчин төгөлдөр болмогц 3 өдрийн дотор гэрлэлтийг бүртгэсэн иргэний бүртгэлийн байгууллагад явуулах ба гэрлэлтээ цуцлуулсан иргэн 10 хоногийн дотор дээрх байгууллагад бүртгүүлнэ.

Бүртгүүлэхдээ өргөдөл гаргах бөгөөд шүүхийн шийдвэр, гэрлэлтийн гэрчилгээг хавсаргана.

Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын иргэний бүртгэлийн ажилтан өргөдлийг хүлээн авч, гэрлэлт цуцалсныг бүртгэж гэрчилгээ олгоно.

4. Хүүхэд үрчлэх

*Бие минь төрмөл
Санаа минь таримал*

Хүүхэд үрчлэх гэдгийг хэрхэн ойлгох вэ?

Хүүхэд үрчлэхийг амьдралд “хүүхэд өргөж авах” хэмээн ярилцаж хэлцдэг. Үг зүйн талаас авч үзэж тайлбарлавал хүүхэд үрчлэх нь бусдын хүүхдийг өөрийн болгон тэжээх, үрчлүүлэх нь үрчлэхийн үйлдүүлэх хэв юм.

Хуулийн талаас нь үрчлэлт-бусдын хүүхдийг өөрийн хүүхэд болгон тэжээх явцад үрчлүүлэгч, үрчлэгдэгч, үрчлэгчийн хооронд эд хөрөнгийн ба амин хувийн шинжийг агуулсан эрх зүйн тодорхой төрлийн харилцаа буюу үрчлэлтийн харилцаа үүснэ гэж тодорхойлсон байдаг.

Хүүхэд үрчлэхдээ дараах шинж, байдлуудыг анхааран үзэх нь зүйтэй юм.

- Хүүхэд үрчлэх нь зөвхөн гэр бүлийн хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу явагдах үйл ажиллагаа юм.
- Хүүхэд үрчлэх нь ямар нэг шалтгаанаар эцэг, эхийн асрамж, халамжгүй үлдсэн хүүхдийг гэр бүлд өсгөж хүмүүжүүлэх хэлбэр юм.

Гэр бүл бол хүүхдийн зан байдал төлөвших, хүний хүмүүжлийн суурь орчин байдаг. Тийм ч учраас бүтэн өнчин хүүхэд, эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон, эцэг, эх байх эрхээ хасуулсан хүний хүүхдийг хүүхдийн эрх ашиг, сонирхолд нийцсэн, төрсөн гэр орныг нь орлож чадах гэр бүлд хүмүүжүүлэхийг зорьдог.

- Хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс тэднийг бусдад үрчлүүлнэ. Хүүхдийн эрх ашгийг хамгаалж, амьдрах эрхийг хэрэгжүүлж байгаа нэгэн хэлбэр бөгөөд үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэснээр хүүхдийн эрүүл, чийрэг өсөх, зөв боловсон хүмүүжих боломж бүрдэх ойлголт юм. Түүнээс биш хүүхэд үрчлэх нь ашиг, хонжоо олох, хөдөлмөрийн хүч бий болгох зэрэг хүүхдийн хувьд сөрөг хүчин зүйл бий болгох үйл ажиллагаа биш билээ.
- Эхнэр, нөхөр үр хүүхэдтэй болох нэг арга бол хүүхэд үрчлэх юм. Гэрлэгчид нь ерөөсөө хүүхэд төрүүлээгүй, төрүүлэх боломжгүй, эсхүл төрүүлсэн хүүхэдтэй боловч бусдын хүүхдийг асрамжиндаа авч өөрийн хүүхэд мэт хайрлан хүндэтгэн, өсгөж хүмүүжүүлж болно. Энэ тохиолдолд гэрлэгчид буюу эхнэр, нөхөр нь хүүхэд үрчлэх талаар харилцан зөвшөөрөлцсөн байх ба энэ тухай хүсэлтээ эрх бүхий байгууллагад гаргасан байхыг шаардана.



Тохиолдол:

Иргэн Анар эхнэр Болортой гэрлэлтээ бүртгүүлсний дараа Болорын 8 настай охин Энэрэлийг үрчлэн авахаар шийджээ. Анар дагавар охиноо үрчилж болох уу? Хүүхэд үрчлэхэд ямар баримт бичиг бүрдүүлэх вэ?

Хүүхэд үрчлэх нөхцөл гэдэг нь гэр бүлийн хууль тогтоожид тусгагдсан хүүхэд үрчлэхэд боломжит нөхцөл, байдлуудыг ойлгоно.

Хуульд хүүхэд үрчлэх дараах нөхцөл байдлыг хуульд тусгаж өгчээ.

1. Хүүхдээ үрчлүүлэх тухай эцэг, эхийн, хэрэв хүүхэд бүтэн өнчин, эцэг, эх нь хоёулаа иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй бол тэдний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл зайлшгүй шаардлагатай.

Дээрх асуултын хүрээнд Болорын 8 настай охин Энэрэл Анарын дагавар охин. Дагавар хүүхэд хойт эцгийн хооронд эцэг, хүүхдийн эрх, үүрэг үүсэх үндэслэл нь охиныг үрчлэх асуудалтай шууд хамааралтай. Тийм учраас Болор өөрийн охиныг үрчлүүлэхийг хүлээн зөвшөөрсөн тухайгаа бичгээр илэрхийлсэн байх шаардлагатай. Ийнхүү бичгээр гаргасан зөвшөөрлийг нотариатаар гэрчлүүлсэн байна. Зөвшөөрөлд зурсан гарын үсгийг нотариат гэрчилнэ.

2. Хүүхэд үрчлэн авахыг хүссэн үрчлэгч энэ тухайгаа бичгээр үйлдэж нотариатаар гэрчлүүлсэн байна. Үрчлэн авах хүсэлтээ бичгээр илэрхийлсэн байхыг ойлгоно. Үрчлэгч нь хүүхэд үрчлэн авах тухай өргөдлөө хүүхдийн оршин сууж байгаа буюу урьд оршин сууж байсан газрын сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт гаргана.

Өргөдөлдөө:

- Гэрлэлтийн гэрчилгээ;
- Хүүхдийн төрсний гэрчилгээ;
- Хүүхдийн эцэг, эхийн, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөл;
- Өөрийн эрүүл мэндийн тодорхойлолт;
- Цагдаагийн байгууллагын тодорхойлолт зэргийг хавсаргана.

3. Долоон нас хүрсэн хүүхдээс өөрийн нь зөвшөөрлийг авсны үндсэн дээр үрчлүүлнэ. 7 нас хүрсэн хүүхэд саналаа ямар нэгэн байдлаар илэрхийлж чаддаг учраас үрчлүүлэх үед саналыг нь авна.

4. Хуульд зааснаар үрчлэгчид тусгай шаардлага тавигдана. Үрчлэгч нь насанд хүрсэн, иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжтай, хүүхдийг тэжээн тэтгэж, өсгөн хүмүүжүүлэх зохих боломжтой хүн байна.

Хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор зарим хүмүүст хүүхэд үрчлэхийг хориглоно. Үүнд:

- Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан буюу хязгаарлуулж, хасуулж байсан хүнд хүүхэд үрчлэхийг хориглоно.

Хүүхдийн эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан эцэг, эх нь хүүхэдтэйгээ зүй бусаар харилцсан, гачигдуулсан, орон гэрээсээ

дайжуулсан, гадуурхсан, эрхээ урвуулан ашигласан, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн зэрэг хүүхдийн эрх, ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн гэдэг нь тогтоогдож, хариуцлага хүлээсэн этгээд байдаг. Тийм учраас дээр дурдсан хүн хүүхэд үрчлэхийг хориглоно.

- Шүүхийн шийдвэрээр иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй буюу хязгаарлагдмал чадамжтай гэж тооцогдсон хүнд хүүхэд үрчилж болохгүй.

Хүүхэд үрчлэн авахыг хүссэн этгээд сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, үйл ажиллагаагаа зөв удирдаж чадахгүй болсон нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдож, шүүхээс иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцсон шийдвэр гарч хүчин төгөлдөр болсон тохиолдолд хүүхэд үрчлүүлэхгүй.

Шүүхээс иргэний эрх зүйн чадамжгүй гэж тооцогдсон этгээд бусдын өмнө өөрийн үйлдлээр эрх, үүрэг хүлээх боломжгүй этгээд байна.

Тэдгээр хүмүүс хүүхэд тэжээн тэтгэж, өсгөж хүмүүжүүлэх ямар ч боломжгүй юм. Мөн түүнчлэн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаа байнга хэрэглэж, гэр бүлээ эдийн засгийн талаар хүнд байдалд оруулсан насанд хүрсэн этгээдийн иргэний эрх зүйн чадамжийг сонирхогч этгээдийн хүсэлтээр, шүүх хязгаарлаж болно.

Энэ тохиолдолд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно. Учир нь эрх зүй чадамжаа хязгаарлуулсан этгээд хязгаарлагдаагүй чадамжийн хүрээнд харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр хэлцэл хийх эрхтэй байна.

- Урьд үрчлэн авсан хүүхдээ өөрийн буруугаас буцааж өгсөн.

Үрчлэгч урьд нь бусдаас хүүхэд үрчлэн аваад хүүхдийг хоол, унд, орон байраар гачигдуулах, гадуурхах, тэдэнтэй хэрцгий харилцах зэргээр эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласны улмаас хүүхдийн эрх ноцтой зөрчигдөж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчид эргүүлэн өгснийг ойлгоно.

- Үрчлэгч нь ямар нэгэн ашиг, хонжоо олох зорилгоор хүүхдийг үрчлэн авсан нь тогтоогдвол хүүхэд үрчлэх хүсэлтийг зөвшөөрөхөөс татгалзахаас гадна үрчлэлтийг хүчингүйд тооцно.

- Үрчлэгч эрүүгийн хэрэгт удаа дараа шийтгүүлсэн болон хорих ял эдэлж байгаа бол хүүхэд үрчлүүлэхийг хориглоно.

Эрүүгийн гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлсэн, хорих ял эдэлж байгаа хүний хувьд хүүхдийг зөв өсгөн хүмүүжүүлэх, тэжээн тэтгэхэд ахуй нөхцөл, ёс суртахууны хувьд найдваргүй учраас тэдэнд хүүхэд үрчлүүлэхийг хориглоно.

- Үрчлэгч согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг бол хүүхэд үрчлэхийг хориглоно.

Согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүмүүс гэр бүлийн амгалан тайван байдлыг алдагдуулах, тэднийг эдийн засаг, эд материалын хүнд байдалд оруулахаас гадна өөрсдөдөө хяналт тавих нөхцөл боломжоо алддаг. Энэ байдал нь хүүхдийн хэвийн амьдрал, эрүүл мэнд, хүмүүжилд муугаар нөлөөлөх учраас согтууруулах ундаа, мансууруулах бодис байнга хэрэглэдэг хүмүүст хүүхэд үрчлэхийг хориглоно.

Үрчлэгдсэн хүүхэд нь төрсөн хүүхдийн адил эрх, эдэлж үүрэг хүлээнэ. Үрчлэгч нь хүүхдийн өмнө төрсөн эцэг, эхийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үрчлэгдсэн хүүхэд нь үрчлүүлсэн эцэг, эхээ тэжээн тэтгэх үүргээс чөлөөлөгдөнө. Үрчлэгдсэн хүүхэд тэжээгчээ алдсаны тэтгэвэр авдаг бол тэтгэвэр авах эрх хэвээр үргэлжилнэ.

IV. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ-ХУУЛЬ

1. Хөдөлмөрийн гэрээ болон бусад хөдөлмөрийн харилцаанд хэрэглэгдэх гэрээний асуудал
2. Ажил амралтын цаг, цалин хөлс, олговрын зохицуулалт
3. Сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх



Хөдөлмөр эрхлэж буй иргэд бид хөдөлмөрийн гэрээг байгуулах, түүний төрөл, ажил амралтын цаг болон ажлаас халагдах үед юуг анхаарах талаар хуулийн мэдлэгтэй байх нь өөрийн эрхээ хамгаалахад чухал ач холбогдолтой.

IV. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ - ХУУЛЬ

1. Хөдөлмөрийн гэрээ болон бусад хөдөлмөрийн харилцаанд хэрэглэгдэх гэрээний асуудал

*Ажил хийвэл
Ам тосдоно*

Тохиолдол:

А: Дарга надаас санал асуулгүй бэлэн байсан хөдөлмөрийн гэрээнд гарын үсэг зуруулсан. Гэтэл ажил хийх хугацаанд ажлын байрны тодорхойлолтод зааснаас өөр ажил хийлгэх юм. Тэр ажлыг нь хийхгүй бол хөдөлмөрийн гэрээг цуцлах болов уу, яах бол?

Г: Намайг шинээр ажилд орж байх үед туршилтын хугацаа гээд хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, харин үндсэн ажилтан болсноос хойш жил бүр хөдөлмөрийн гэрээ байгуулах юм. Ингэх ёстой юм бол уу?

О: Би хоёр компанид зэрэг хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг. Гэтэл нэг компани нь нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй гэх юм. Энэ зөв үү?

Ё: Өөр ажилд орох гээд ажлаас гарах гэтэл дарга “чи өөрийн санаачлагаар ажлаас гарвал тодорхой хэмжээний нөхөн төлбөр төл” гээд байна. Би төлөх ёстой юу?


Эдгээр асуултууд хөдөлмөр эрхэлдэг хэн бүхний амьдралд өдөр тутам тохиолдож байдаг. Ялангуяа, анх ажилд ороход хөдөлмөрийн гэрээг байгуулахад ажил олгогч давуу эрхтэй байдаг болохоор үүсч байгаа асуудлыг мэддэггүй, асууж чаддаггүй, асуухаас эмээдэг гэх зэргийн олон бэрхшээл байна.

Хөдөлмөр эрхэлж байгаа хэнд ч, хэдий үеэс хөдөлмөрийн гэрээг байгуулах, байгуулахдаа юуг анхаарах, нэгэн зэрэг хэд, хэдэн ажлыг гүйцэтгэж болох эсэх, хугацаатай болон хугацаагүй хөдөлмөрийн гэрээний онцлог гэх зэргээр мэдвэл зохих асуудлууд олон байдаг.



Хамгийн гол нь ямар ажилд хөдөлмөрийн гэрээг байгуулах ёстой вэ гэсэн асуулт тулгамддаг. Тэгвэл хөдөлмөрийн гэрээг байнгын ажлын байр буюу байнга давтагдан хийж байгаа хөдөлмөр эрхлэлтийг зохицуулах үүднээс байгуулдаг байна.

Хөдөлмөрийн гэрээ олон янз байж болно.



Хугацаагүй гэрээ гэдэг нь гэрээ байгуулахдаа тодорхой хугацаа заалгүй гэрээ байгуулахыг хэлнэ. Хугацаагүй гэрээ байгуулсан бол ажил олгогч хэдийд ч гэрээ цуцлах эрхтэй байна. Гэхдээ хөдөлмөрийн

гэрээ цуцлаж байгаа хууль зүйн үндэслэлээс хамаарч гэрээ цуцлахдаа ямар шаардлага тавих нь өөр өөр байж болно. Байнгын ажлын байранд байгуулж байгаа гэрээ нь хугацаагүй байгуулагдана.

Хугацаатай гэрээ нь ажилтан анх ажилд орох үед байгуулсан гэрээнд, хугацаа заасан байхыг хэлнэ. Тухайн хугацаагаар хөдөлмөрийн харилцаа үргэлжилнэ. Уг хугацаа дуусмагц хөдөлмөрийн гэрээг цуцлаагүй бол анх байгуулсан хугацаагаар үргэлжлэн сунгагдсанд тооцно.

Хугацаатай гэрээ нь тодорхой шалтгаанаар эзгүй байгаа /ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдаж байгаа/ ажилтны оронд түр ажиллах, улирлын болон түр ажилд авах гэх зэрэгт байгуулагддаг.

Туршилтын буюу сургалтын хугацаанд гэрээ байгуулан ажиллаж болох ба энэ нь хөдөлмөрийн гэрээний нэг төрөл байдаг.

Шинээр ажилд орж байгаа ажилтантай туршилтын хугацаа тогтоон, эсвэл дагалдан суралцагч гэх нэрээр сургалтын хугацаа тогтоон ямар нэгэн гэрээ байгуулалгүй ажиллуулах нь амьдралд элбэг. Тэгвэл энэ хугацаа нь хөдөлмөрийн гэрээгээр зохицуулагдах, түүний нэгэн төрөл юм байна. Тухайн хугацаанд зайлшгүй хөдөлмөрийн гэрээ байгуулна.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИАС

3.1.3. “хөдөлмөрийн гэрээ” гэж нэг талаас ажилтан нь ажил олгогчоос хуульд нийцүүлэн тогтоосон хөдөлмөрийн дотоод журмын дагуу тодорхой ажил гүйцэтгэх, нөгөө талаас ажил олгогч нь ажилтанд хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох, хууль тогтоомж болон хамтын гэрээ, хэлэлцээрт заасан хөдөлмөрийн нөхцөлөөр хангах тухай харилцан үүрэг хүлээсэн тохиролцоог хэлнэ


31.1. Ажил олгогч нь энэ хуульд зааснаас бусад тохиолдолд ажилтнаас хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил гүйцэтгэхийг шаардаж болохгүй.

Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тохирно:

- Ажлын байрны буюу албан тушаалын нэр;
- Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг;
- Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ;
- Хөдөлмөрийн нөхцөл.

Хөдөлмөрийн харилцаа нь ажил олгогч ба ажилтны хооронд үүсдэг харилцаа. Ажилтан нь эрх зүйн бүрэн чадамжтай, 18 насанд хүрсэн иргэд байхаас гадна насанд хүрээгүй хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, гадаадын иргэд хөдөлмөр эрхлэх тохиолдол байдаг ба эдгээр нь тусгайлан онцлог бүхий зохицуулалт шаарддаг.

Эдгээр иргэд хөдөлмөр эрхлэх насны хувьд, хүүхдээ асрах, төрүүлэх, биеийн онцлог зэргээр бүрэн чадамжтай иргэдтэй нэгэн адилаар хөдөлмөрлөх, хуулиар нэг ижил шаардлага тавих боломжгүй тул ажлын цаг, цалин хөлс, хөдөлмөрийн гэрээг цуцлах үед ялгамжтай зохицуулалт хэрэглэгдэнэ. Тухайлбал:




Тохиолдол:

14 настай С нэгэн компанид зөөгчөөр ажиллах болсон. Түүнтэй байгууллагын дарга хөдөлмөрийн гэрээ байгуулах болов. С хөдөлмөрийн гэрээ байгуулж, гэрээний нэг тал болж болох уу.

С ажлын 8 цаг ажиллах уу, хөдөлмөрийн гэрээнд ямар заалт тусгах ёстой вэ?

Хөдөлмөрийн харилцаанд хэдийгээр насанд хүрсэн иргэд ажилтнаар оролцох ёстой байдаг ч 14-өөс дээш насны, насанд хүрээгүй хүн хөдөлмөр эрхлэх тохиолдол гарч ирэх бөгөөд хуульд насанд хүрээгүй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг хориглоогүй юм. Иймээс С хөдөлмөрийн гэрээний нэг тал болж болох бөгөөд гагцхүү эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг авсан байна. Байгуулж байгаа гэрээнд Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажлын цагийг богиносгох, илүү цаг, шөнийн цагаар ажиллуулах, хэвийн бус нөхцөлд хөдөлмөр эрхлэхийг хориглодог тул тухайн насанд хүрээгүй ажилтны ажлын байр ямар онцлогтой болохыг эцэг эх, асран хамгаалагч нь болон ажил олгогч судалсан байх шаардлагатай юм.

Түүнчлэн дээрх хөдөлмөрийн гэрээний аль нэгийг байгуулж ажиллахын зэрэгцээ хэд, хэдэн төрлийн ажлыг тухайн ажил олгогч болон бусад ажил олгогчтой гэрээ байгуулан ажиллаж болно. Ийм тохиолдолд орон тооны бус ажилтнаар авч ажиллуулах, эсвэл ажил гүйцэтгэх гэрээ байгуулах зэргээр ажил олгогч нь Хөдөлмөрийн хуулийг зөрчих, мөн Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэглэх нь цөөнгүй байдаг юм. Гэтэл Хөдөлмөрийн тухай хуульд уг зохицуулалт байгаа бөгөөд үүнийг зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээний зохицуулалт гэнэ.



Ажил, албан тушаал хавсрах гэдэг нь өөрийн ажиллаж байгаа байгууллагаас /ажил олгогчоос/ гадна өөр бусад ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллахыг хэлнэ. Энэ тохиолдолд

ажлын цагтаа багтаан ажиллах, хэд хэдэн ажил олгогчоос цалинжих, цалин, хөдөлмөрийн хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл тус бүрд нь төлөх гэсэн асуудлууд гарч ирдэг. Ажилтны хувьд ийм байдлаар ажиллах боломжтой, чадвартай бол өөрт нь давуу тал боломжийг бий болгоно.



Хослох нь өөрийн ажиллаж байгаа ажил олгогчтой үндсэн ажил үүргээс гадна өөр ажлыг хамт давхар гүйцэтгэх, хийхийг хэлнэ. Энэ нь ажил олгогчийн хувьд орон тоо хэмнэх, ажил үүргийг нь хэвээр хадгалах ажилтны ажлын байранд дахин шинээр хүн авч ажиллуулахгүй байх зэрэг давуу талтай бол ажилтны хувьд өөрийн нөөц боломжоо дайчлан олон ажлыг хийж гүйцэтгэснээрээ давхар цалинжих боломжийг бүрдүүлдэг.

Орлох гэдэг нь эзгүй байгаа ажилтныг тодорхой хугацаагаар орлох, ажил үүргийг гүйцэтгэх байдлаар илэрхийлэгдэнэ.

Хөдөлмөрийн харилцаанд, дээрх байдлаар хөдөлмөрийн

гэрээнээс гадна ажилтны гоц авьяас, ур чадварыг харгалзан, эсвэл өмчлөгч өмчлөх эрхийнхээ тодорхой хэсгийг хэрэгжүүлэхдээ бусдын хөдөлмөрлөх үйл ажиллагааг ашиглахын тулд контракт байгуулан ажиллаж болно.

Санамж: Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээг заавал байгуулна. Хөдөлмөрийн гэрээ нь ажилд авах тушаал гаргах үндэслэл болно. Нэг ажилтан хэд хэдэн ажил үүргийг ажлын үндсэн цагтаа багтаан орлон, хослон, хавсарч ажиллах тохиолдолд хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулна.

Хөдөлмөрийн гэрээ байгуулах үед талууд хуульд заасан гэрээний гол нөхцөлийн аль нэгийг тохироогүй бол хөдөлмөрийн гэрээ байгуулсанд тооцохгүй.

Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой /51 буюу түүнээс дээш хувьтай/ хуулийн этгээдэд нэг гэр бүлийн буюу төрөл садангийн хүмүүс хөрөнгө мөнгө захиран зарцуулах ажил, албан тушаалд хамт ажиллахыг хориглоно.

Тодорхой үед үүссэн хөдөлмөрийн харилцаа тодорхой үндэслэлээр дуусгавар болох буюу цуцлагдана. Иймд хөдөлмөрийн харилцаа дуусгавар болох болон хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл, ялгааг мэдэх нь чухал байдаг.

Ажил олгогч болон ажилтны хооронд хөдөлмөрийн гэрээгээр үүссэн хөдөлмөрлөх харилцаа Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлээр дуусгавар болох буюу ажилтан, ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцлаж болно.

Гэхдээ хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, цуцлах гэсэн ойлголтууд нь ялгаатай юм. Дуусгавар болох үндэслэл нь ажилтан болон ажил олгогчоос хамааралгүй үүсч болох, нөгөө талаар хүндэтгэн үзэх шалтгаанууд хамаарагддаг.

Гэтэл хөдөлмөрийн гэрээг цуцлах гэдэг гол нь ажил олгогч төдийгүй ажилтан санаачлагаараа хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгож байгаа ойлголт юм.

Практикт, хөдөлмөрийн гэрээнээс үүдэн гарч байгаа маргааны дийлэнх нь ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг цуцласнаас үүсдэг. Иймд Хөдөлмөрийн тухай хуулийн 40-р зүйлд заасан үндэслэлийн гол онцлогийг авч үзье.

- 1. Аж ахуйн нэгж, байгууллага болон түүний салбар, нэгж татан буугдсан, орон тоо хасагдсан, эсхүл ажилтны тоог цөөрүүлсэн;** Татан буугдах нь бүрмөсөн үйл ажиллагаа дуусгавар болох ойлголт бөгөөд байгууллага өөрчлөн байгуулагдсан бол энэ нь хамаарахгүй юм. Орон тоо хасагдах гэдэгт тухайн хуулийн этгээд, байгууллагын зохион байгуулалтын бүтцээс тодорхой ажил, албан тушаалын ажлын байр үгүй болсныг ойлгодог.

“Орон тоо цөөрүүлэх” нь хуулийн этгээд, байгууллагын зохион байгуулалтын бүтцийн адил ажил, албан тушаалын хэд хэдэн орон тооноос тодорхой тооны орон тоог хассаныг ойлгоно.

- 2. Ажилтан мэргэжил, ур чадвар, эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь тогтоогдсон;** Ажилтны уг байдлын талаар салбарын буюу тухайн байгууллагын мэргэжил, ур чадварын түвшин тогтоох комисс, аттестатчиллын комисс болон эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын албан ёсны дүгнэлт, шийдвэр гарсан байхыг ойлгоно.

Харин хуульд өөрөөр заагаагүй бол боловсролын үнэмлэхгүй буюу дээд боловсролгүй гэх зэрэг шалтгаан нь ажил олгогчоос ажилтныг мэргэжил, ур чадварын хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй гэж үзэх, түүнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

- 3. Ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн;** Энэ нь ажилтан хүйсийн байдлаас хамааралгүй иргэний үнэмлэхэд заасан нас нь 60 хүрсэн байхыг ойлгоно. Нийгмийн даатгалын холбогдох хуульд зааснаар эмэгтэй хүн 55 насанд хүрснээр тэтгэврээ тогтоолгох эрх үүсэх бөгөөд ажил олгогч нь үүнийг үндэслэн ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцлаж болохгүй.
- 4. Ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, эсхүл хөдөлмөрийн харилцааг шууд зогсоохоор хөдөлмөрийн гэрээнд тухайлан заасан ноцтой зөрчил гаргасан;** Ажилтан хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан гэдэгт хөдөлмөрийн сахилгын зөрчлийг 2 буюу түүнээс дээш удаа гаргасан байхыг ойлгоно. Зөрчил бүр тус тусдаа тогтоогдсон байх шаардлагатай боловч тус бүрд нь сахилгын шийтгэл заавал ногдуулсан байхыг шаардахгүй. Давтан гаргасан зөрчлүүдийн хоорондох хугацаа өмнөх зөрчилдөө сахилгын шийтгэл хүлээсэн

бол 1 жилээс, хүлээгээгүй бол 6 сараас хэтрээгүй байна.

“Ноцтой зөрчил” гэдэг нь ажил олгогчид эд хөрөнгийн хохирол учруулах, бизнесийн ба ажил хэргийн нэр хүндийг нь гутаах зэргээр түүний эрх, ашиг сонирхолд нь нөлөөлөхүйц сөрөг үр дагаварыг буй болгосон, уг ажилтны хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэгт нь харш үйлдэл, эс үйлдэл байна.

Гэрээний талууд ажлын байр, албан тушаал, гүйцэтгэх ажил үүргийн онцлогтой холбогдуулан ямар зөрчлийг ноцтой гэж тооцохыг харилцан тохиролцон тогтоож, уг зөрчлийн тохиолдол бүрийг хөдөлмөрийн гэрээнд зааснаар, гарсан үйлдлийг зөрчилд тооцох, улмаар сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

- 5. Мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан нь тогтоогдсон;** Ажил олгогчийн итгэлийг алдсан ажилтны гаргасан буруутай үйлдэл, эс үйлдэхүй нь хууль, санхүүгийн болон хяналтын зэрэг эрх бүхий байгууллагын шалгалт, мөн ажил олгогчийн дотоодын хяналт шалгалтаар тогтоогдсон байна.

Мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтны гаргасан эд хөрөнгийн зөрчил нь эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж тогтоогдсон нь эд хөрөнгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болдоггүй.

Мөнгө болон эд хөрөнгө хариуцсан ажилтан гэдэгт ажил олгогчийн мэдлийн өмч хөрөнгийг бүртгэн авч, бүрэн бүтэн байдлыг хангах, хадгалах, хамгаалах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бусдад шилжүүлэх үүрэг хүлээсэн эд хариуцагч байна. Түүнчлэн тодорхой зориулалт, чиглэлээр эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх мэдлийг өмчлөгчөөс шилжүүлэн авсан удирдах албан тушаалтан, мөн удирдах албан тушаалтантай зохих хэмжээгээр эд хөрөнгийг хамтран захиран зарцуулах эрхийг хэрэгжүүлж, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр хяналт тавих эрх бүхий санхүүгийн албан тушаалтан зэргийг хамруулан ойлгоно.

- 6. Сонгууль, томилолтоор өөр орон тооны ажил, албан тушаалд ажиллах болсон;** Өөр ажил, орон тоонд зохих журмаар томилогдсон, сонгогдсон байхыг хэлнэ.

7. контрактад заасан үндэслэл буй болсон;

Эдгээр үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцлах ба хөдөлмөрийн гэрээ цуцлах болсон шалтгаан, үндэслэлээ тушаалд тодорхой дурьдаж, шаардагдах нотлох баримтыг хавсаргасан байх ёстой.

**Тохиолдол:**

Хувийн нэгэн дунд сургуульд багшлах А ажлаас гарах өргөдлөө өгтөл ажил олгогч түүнийг ажлаас халах буюу хөдөлмөрийн гэрээг цуцлахаас татгалзсан байна. А яах ёстой вэ?

Өмнө, ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэлийн талаар дурдсан, харин ажилтны санаачлагаар гэрээг цуцлах үед ажил олгогч хариу өгөөгүй, өгөхөөс татгалзаж байгаа бол өргөдлөө өгөөд 30 хоног өнгөрмөгц ажлын байраа орхин явах эрхтэй талаар Хөдөлмөрийн тухай хуульд заасан байна.

Хөдөлмөрийн гэрээний агуулга ямар байх ёстой талаар дараах гэрээний загвараас харж болно.

Хөдөлмөрийн гэрээ

Энэхүү хөдөлмөрийн гэрээг нэг талаас /ажил олгогч/, нөгөө талаасовогтой нар харилцан тохиролцож монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 21-р зүйлийг үндэслэн дор дурьдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг. Гэрээний нөхцөл

- 1.1 Ажахуйн нэгж байгууллага, түүний нэгжийн нэр
- 1.2 Ажлын байр, албан тушаалын нэр
- 1.3 Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүрэг.....
- 1.4 Үндсэн цалин.....
- 1.5 Хөдөлмөрийн нөхцөл хөдөлмөрийн нөхцөлөөс хамаарч хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа бол үзүүлэх хөнгөлөлт, тусгай нөхцөл.
- 1.6 Хөдөлмөрийн гэрээний хугацаа..... /хэрэв ажилтныг туршилтын хугацаагаар авч ажиллуулж байгаа бол үүнийг гэрээндээ тусгана/
- 1.7 Долоо хоногийн ажлын цагийн үргэлжлэл.....
- 1.8 Ажил, амралтын цагийн горим.....

Хоёр. Ажил олгогчийн эрх, үүрэг

- 2.1 Ажилтныг ажиллах нөхцөл боломжоорхангана.
- 2.2 Ажилтны ажлын үр дүн, явцад үнэлэлт өгөх, урамшуулах, сахилгын зөрчил гаргавал хөдөлмөрийн дотоод журмын дагуу сахилгын арга хэмжээ авна.
- 2.3 Ажилтны ахуй амьдралд дэмжлэг туслалцаа үзүүлэх, ажилтныг үүргээ биелүүлэхийг шаардах, ажлын байр, ажил гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих үүрэг хүлээнэ.
- 2.4 Хөдөлмөрийн тухай хуульд заасан үндэслэлийн дагуу ажил үүргээ гүйцэтгээгүй үед ажил албан тушаалыг хэвээр хадгална.

Гурав. Ажилтны эрх, үүрэг

- 3.1 Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод журам болон бусад холбогдох хууль, хууль тогтоомжийг сахиж ажиллана.
- 3.2 Хөдөлмөрийн гэрээнд заасан цалин, хөдөлмөрийн хөлсөө цаг тухай бүрд нь авна.

Анхаарах зүйл:

- Ажлын байр хэвийн болон хэвийн бус нөхцөлийн алинд хамаарч байгааг анхаарах
- Хөдөлмөрийн гэрээ байгуулсан өдрөөс ажил олгогч нийгмийн даатгалын дэвтэр нээж өгөх үүрэгтэй.

3.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг чанд сахиж ажиллана.

3.4 Илүү цагаар ажиллах тохиолдолд нэмэгдэл хөлс авна.

3.5 Ажил албан тушаал нь хадгалагдаж байгаа бол хугацаа дуусмагц /хадгалах шалтгаан арилмагц/ саадгүй ирж, ажил үүргээ гүйцэтгэнэ.

3.6 Жил бүр ээлжийн амралт авах эрхтэй.

Дөрөв. Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэлүүд:

Ажилтан дараах хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргавал ноцтой зөрчилд тооцон, хөдөлмөрийн гэрээг шууд цуцлана.

4.1 ажлын байранд, ажлын цагаар согтууруулах ундаа хэрэглэсэн;

4.2 хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-с дээш хоног ажил тасалсан;

4.3 хөдөлмөрийн сахилгын зөрчлийг давтан гаргасан, өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй тохиолдолд;

4.4 өмч хөрөнгө үрэгдүүлж, алдагдалд оруулсан, ашигласан;

4.5 байгууллагын нэр хүндийг унагасан, байгууллагын нууцыг задруулсан.

Тав. Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох нөхцөлүүд:

Хөдөлмөрийн гэрээг дараах үндэслээр дуусгавар болгоно.

5.1 талууд харилцан тохирсон;

5.2 хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусаж цаашид сунгагдахгүй болсон;

5.3 хууль тогтоомжид заасан эрх бүхий байгууллага шаардсан;

5.4 хөдөлмөрийн хуульд заасан бусад үндэслэлүүд.

Зургаа. Бусад нөхцөлүүд:

6.1 Гэрээнд талууд гарын үсэг зурснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2 Гэрээг 2 хувь үйлдэж, талуудад тус бүр нэг хувь нь хадгалагдана.

6.3 Гэрээнд талууд харилцан тохиролцож өөрчлөлт оруулж болно.

Анхаарах зүйл:

- Хөдөлмөрийн сахилгын шийтгэлийн бусад арга хэмжээ байгууллагын дотоод журамд тусгагдсан байдаг.
- Хөдөлмөрийн ноцтой зөрчилд байгууллага нь өөрийн үйл ажиллагааны онцлогоо харгалзан өөр өөр байдлаар тусгаж болно.

Дээрх хөдөлмөрийн гэрээнээс гадна хөдөлмөрийн харилцаанд хамт олны эрх ашгийг хамгаалах, зохицуулах чиг үүрэг бүхий хамтын гэрээ, хэлэлцээр байгуулагдана. Хөдөлмөрийн гэрээ тухайн ажилтны хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг зохицуулдаг бол хамтын гэрээгээр тус байгууллага, хамт олны эрх ашгийг зохицуулна. Хамт олны эрх ашгийг байгууллага дээр байх Үйлдвэрчний эвлэл, Үйлдвэрчний эвлэл байхгүй бол нийт ажилтны хурлаас сонгогдсон ажилтны төлөөлөгч ба ажил олгогч буюу захиргааны төлөөлөлтэй байгуулдаг гэрээ юм.

Хамтын гэрээгээр:

- цалин хөлсний хэлбэр;
- хөдөлмөрийн цалин хөлсөнд оруулан тооцох нэмэгдлүүд;
- сул зогсолтын үеийн олговор;
- нэмэгдэл хөлс;
- илүү цагаар хэрхэн ажиллуулах;
- ажилтны нийгмийн асуудал гэх зэрэг нийт ажиллагсдад хамаарагдах асуудлыг хамарч зохицуулна.

2. Ажил амралтын цаг, цалин хөлс олговорын зохицуулалт

*Ажил хэцүү
Амт нь сайхан*

Хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа хэн боловч өөрийн хөдөлмөр, үйл ажиллагааны урамшууллыг мөнгөн хэлбэрээр ажил олгогчоос авах ба үүнийг цалин, хөдөлмөрийн хөлс гэж нэрлэнэ. Улс орон бүрт хөдөлмөрийн үнэлгээ өөр өөр байх боловч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоосноор, түүнээс доогуур цалин хөлс

тооцогдох үндэслэлгүй болно. Цалин, хөдөлмөрийн хөлсийг ажилтан ажилд орох үедээ тохирох боловч төрийн болон хувийн гэх олон ажлын байрны онцлогтой уялдан, тогтоосон тарифаар цалинжих, ажил олгогчоос тогтоох зэргээр цалин хөлсийг тогтоох аргачлал өөр өөр байдаг. Гэхдээ цалин хөлс нь зохих бүрдэлтэй. Үүнд:

үндсэн цалин	• тухайн ажилтны хөдөлмөрийн гэрээнд тусгагдах нэмэгдэл, шагнал, урамшуулал тооцогдож ороогүй цалинг хэлэх ба хөдөлмөрийн гэрээний дагуу ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүргийг гүйцэтгэснээр авч байгаа цалин
нэмэгдэл	• ажилтны ур чадвар, ажилласан жил, эрдмийн зэрэг цол зэргээс хамааран үндсэн цалингийн тодорхой хувиар тооцож олгох мөнгө
нэмэгдэл хөлс	• илүү цагаар ажилласан, эзгүй байгаа ажилтны ажлыг хавсарсан, орлосон, ажлын байранд заагаагүй ажил үүргийг гүйцэтгэсэн, шөнийн цагаар ажилласан зэрэгт олгож буй мөнгө
шагнал урамшуулал	• ажилтны ажлын үр дүнгээс хамаарч олгож байгаа урамшуулал

Эдгээр бүрдлээс цалин хөлс хамаарах тул дээрх бүрдлийн нийлбэрээр цалинг бодож тооцох, нийгмийн даатгалын шимтгэлийг ч үүнээс тооцдог байна. Цалин хөлснөөс гадна олговрын зохицуулалт гэж байдаг.

Тохиолдол:

А, М нар ярилцана.

А: Хагас жил болон жилд манай байгууллага ажлын үр дүнг харгалзан, мөнгөн шагналаар урамшуулдаг. Энэ тэгэхээр цалин юм уу, цалингаас тусдаа ойлголт юм уу.

М: Цалингийн бүрэлдэхүүнд орно. Тиймээс тухайн сардаа нийгмийн даатгалын шимтгэл ногдуулж, нийгмийн даатгалын дэвтэрт баталгаажуулан бичнэ. Хэрэв цалин биш байсан бол шимтгэл ногдуулахгүй байсан байх.

А. Өө тийм юм байна. Харин салбарын болон төрийн шагнал бол яах вэ, тэр шагналыг нь бас мөнгө дагалддаг шүү дээ.

М: Харин тийм юм байна лээ. Тэгэхдээ шагнал олгох шийдвэртээ тус шагналыг дагалдах мөнгийг байгууллагаас гаргахыг даалгадаг юм байна лээ. Тэгэхээр байгууллага тус мөнгийг ажилтанд олгохоор шийдвэрлэхдээ мөн л нийгмийн даатгалын суутгал хийнэ. Тэгэхээр ялгаагүй байгаа биз дээ.

Олговор гэдэг нь хөдөлмөрийн харилцааны явцад цалингаас гадна, хуульд заасан үндэслэлээр олгож байгаа мөнгөн хангамжийг хэлдэг.

Олговрыг:

- Баталгаат;
- Нэмэгдэл;
- Нөхөх гэж ангилна.

Баталгаат олговор гэдэг нь хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гүйцэтгээгүй байх үед олгодог. Үүнд: ээлжийн амралтын, сул зогсолтын үеийн, ажил хүлээлцэх хугацааны, буруу халсан үеийн, хүүхэд хөхүүлэх, асрах үеийн, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажилдаа ирээгүй үеийн гэх зэрэг олговор багтана. Эдгээр олговрын хэмжээ хуульчлагдсан байдаг учраас ажил олгогч түүний хэмжээг өөрчлөх боломжгүй байдаг.

Нэмэгдэл олговор гэдэг нь ажилтныг богиносгосон цагаар ажиллуулсан хэдий ч бүтэн цагаар тооцож олгох олговор хамаарна. Энэ олговор эмэгтэйчүүд, насанд хүрээгүй хүүхэд, хөдөлмөрийн чадвар алдагдах зэрэг шалтгаан, үндэслэлээр олгогддог. Тухайлбал, Эмнэлэг хөдөлмөрийн Комиссын дүгнэлтийн дагуу ажилтныг өөр ажилд шилжүүлэхдээ цалин буурч байгаа бол өмнө авч байсан цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний олговор олгоно. Насанд хүрээгүй ажилтны цалинг тооцохдоо хорогдуулсан цагаар ажилласан хэдий ч хорогдуулсан цагт ногдох цалинг нэмж олгодог байна. Дээрх олговор хуульчлагдаагүй боловч дундаж цалин хөлсний хэмжээнээс багагүй байдаг.

Нөхөх олговор гэдэг нь ажилтнаас гарч байгаа зардлыг зохицуулах зорилготой ба томилолтоор ажиллах, ажил үүргээ

гүйцэтгэхдээ гаргасан зардал, өөр аймаг хот руу томилогдсон, шилжсэн үед гарсан зардал зэргийг нөхөх зорилгоор олгогддог юм.

Ажилтны цалин, хөлснөөс хууль тогтоомжид заасны дагуу, мөн ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан үндэслэлээр суутгал хийх ба нэг сард олгогдох цалингийн 20 хувиас хэтрүүлэлгүй, хэд хэдэн суутгал хийгдэж байгаа бол 50 хувиас хэтрүүлэлгүйгээр суутгаж болно.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИАС

61.1. Ажилтны үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, олговрыг мөнгөн хэлбэрээр олгоно.

51.1. Ажилтанд ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэшлийн зэргийн, хөдөлмөрийн нөхцөлийн болон бусад нэмэгдлийг хамтын гэрээгээр тогтоон олгоно.

60. Ажилтны цалин хөлсийг сард хоёр ба түүнээс дээш удаа, тогтоосон өдөр олгоно. Ажилтны цалин хөлсийг цаг, өдөр, долоо хоногоор тооцон олгож болно. Ажилтны хүсэлтээр цалин хөлсийг нь урьдчилан олгож болно.

53.1. Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно.

Санамж: Ажилтны дундаж цалин хөлсийг тооцохдоо ажилтанд тодорхой хугацаанд олгосон цалин хөлсний нийлбэр дүнг тухайн хугацаан дахь нийт сарын тоонд хувааж нэг сарын дундаж цалин хөлсийг, гарсан дүнг сарын ажлын өдрийн дундаж тоонд хувааж нэг өдрийн дундаж цалин хөлсийг, нэг сарын дундаж цалин хөлсийг тухайн байгууллагад мөрдөж буй сарын ажлын цагийн дундаж тоонд хувааж нэг цагийн дундаж цалин хөлсийг тус тус тодорхойлдог. Дундаж цалин хөлс нь хуульд заасан олговор олгох болон бусад цалинтай холбоотой тооцоог гаргах үндэслэл болно.

Тохиолдол:

Б компани ажлын зайлшгүй шаардлагаар ажилтан А-ийн ээлжийн амралтыг эдлүүлээгүй бөгөөд түүнд ажилласан

хугацааных нь цалинг ээлжийн амралтынх нь олговортой хамт олгожээ. А ээлжийн амралтаа эдэлж чадаагүй учраас мөнгөн урамшуулал авах хүсэлтээ гаргахад ажил олгогчоос ажилласан хугацааны цалин болон ээлжийн амралтын олговор олгосон учраас урамшуулал өгөх боломжгүй гэсэн хариуг өгчээ.

Ажил олгогчийн хариу хууль зүйн үндэслэлтэй юу?

А урамшуулал авах эрхтэй юу?




Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх, биеэр эдлүүлээгүй бол ээлжийн амралтын олговрыг олгохоос гадна мөнгөн урамшуулал үзүүлж болно. Гэхдээ уг урамшууллын талаар хамтын гэрээнд зааж тусган зохицуулдаг. Гэтэл байгууллага хамтын гэрээг байгуулаагүй бол үүнийг ажил олгогчтой тохиролцсоны үндсэнд шийдвэрлэдэг. Гэтэл А өмнө ингэж тохироогүй байгаа бол шаардах эрхгүй болно.

Хөдөлмөрийн харилцаанд оролцож байгаа ажилтны ажиллах болон амралтын цагийг хуульчилсан нь тэдний хөдөлмөрийн зохион байгуулалт, хөдөлмөрийн бүтээмж өндөр байх, хэвийн эрүүл орчинд амьдарч, ажиллах нөхцөл боломжийг хангаж байгаа үндэс нь юм. Ажилтны ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг байх бол долоо хоногт 40 цаг ажиллана. Ажлын цагийг тогтоохдоо ажилтны нас биеийн онцлогийг ажлын байрны онцлогтой уялдуулан, ажлын

цагийн дэглэмийг тогтоох ба үүнээс үүдэн ажлын цагийг богиносгох, шөнийн цагаар ажиллах, ээлжээр ажиллах зэрэг нарийвчилсан ойлголтууд гарч ирнэ.

Ажлын цагийг дээр заасан байдлаар, долоо хоногоор, өдрийн заасан цагаар зохицуулах боломжгүй бол ажлын цагийг нэгтгэн бодож болно. Түүнчлэн зарим шаардлагатай үед ажил олгогчийн санаачлагаар ажилтныг илүү цагаар ажиллуулах тохиолдол байх бөгөөд ингэхдээ зөвхөн хуульд заасан үндэслэл бүрдсэн үед ажиллуулна.

- улс орныг батлан хамгаалах, хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх;
- байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрлэлийн ослоос сэргийлэх, тэдгээрийн хор уршгийг нэн даруй арилгах;
- нийтийн усан хангамж, цахилгаан, дулааны эрчим хүч, тээвэр, холбооны хэвийн ажиллагааг алдагдуулсан гэмтлийг арилгах;
- урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд яаралтай хийхгүй бол аж ахуйн нэгж, байгууллагын буюу түүний салбар, нэгжийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй саадыг арилгах хойшлуулшгүй ажил гүйцэтгүүлэх.



Тохiolдол :

А нэгэн компанид компьютерийн программистаар ажилладаг ба тэрээр хууль зүйн сургуульд эрх зүйн чиглэлээр суралцахаар болж суралцах хугацаандаа ажлын цагаа богиносгох хүсэлтээ ажил олгогчдоо гаргажээ. Ажил олгогч дээрх хүсэлтийг эс зөвшөөрч, манай байгууллгын ажлын ачаалал их байгаа тул ажлын цагийг богиносгох боломжгүй, хэрэв сургуульд суралцахаар бол өөрийн хүсэлтээр ажлаасаа гарахыг санал болгожээ.

Ажил олгогчийн санал хууль зүйн үндэслэлтэй юу?

Хэрэв А өөрийн компьютерийн программистаар мэргэжлээ дээшлүүлэхээр суралцах бол ажлын цагийг богиносгох боломжтой юу?

Ажилтнуудаас гэрээнд заасан хөдөлмөрлөх үүргээ биелүүлэхийн тулд хуанлийн нэгэн хоногт ажиллавал зохих, хөдөлмөрийн тухай хууль болон хөдөлмөрийн гэрээгээр тогтоогдсон хугацааг ажлын өдөр гэнэ. Ажлын өдрийн үргэлжлэх хэмжээг харгалзан ердийн, богиносгосон, бүтэн бус, уртасгасан ажлын өдөр гэж ангилна.

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажилтнуудын хөдөлмөрлөх үүргээс чөлөөтэй байх буюу өөрсдийнхөө үзэмжээр зохицуулах хугацааг амралтын цаг гэнэ. Амралтын цаг нь үдийн завсарлага, амралтын өдрүүд, баярын өдрүүд, ээлжийн амралт, бусад буюу хувийн чөлөө, жирэмсний болон амаржсаны амралт, ажиллахын хамт суралцагсад олгох чөлөө гэсэн төрөлтэй байна.

3. Сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх

*Ажил хийж хрн болдог
Ар давж хрлэг болдог*

Ажилтан хөдөлмөрлөх үйл ажиллагааны явцад байгууллагын дотоод журам болон хөдөлмөрийн гэрээнд заасан сахилгын зөрчил гаргахаас зайлсхийж ажиллах ёстой. Сахилгын зөрчил гэдэг нь ажил шалтгаангүйгээр таслах, ажлаа зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас

зохих этгээдээс /байгууллага болон хөндлөнгийн бусад этгээд/ гомдол гарах, зөрчил нь шалгалтаар тогтоогдох, ажлын байранд согтуурах гэх зэрэг тохиолдол байна. Тухайн үйлдлийг зөрчил гэж үзэх талаар хөдөлмөрийн дотоод журам, эсвэл хөдөлмөрийн гэрээнд заасан байх шаардлагатай. Ялангуяа, ноцтой зөрчлийн талаар заавал тусгасан байхыг шаарддаг.

Дотоод журам гэдэг нь байгууллагын хөдөлмөрийн харилцааг зохицуулж байгаа дагаж мөрдөх акт байх бөгөөд байгууллагад хөдөлмөрийн үйл ажиллагаа ямар байдлаар явагдах, шагнал урамшуулал, зөрчлийг хэрхэн зохицуулж, шийтгэл хүлээлгэхийг тусгадаг. Гаргасан зөрчлөөс хамааран дараах шийтгэлийг ногдуулна. Үүнд:

- сануулах;
- үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
- ажлаас халах.

Эдгээр шийтгэлийг зөрчил гаргаснаас хойш 6 сарын дотор, зөрчлийг илрүүлснээс хойш 1 сарын дотор ногдуулах ёстой. Уг хугацаа өнгөрсөн бол шийтгэл оногдуулах үндэслэлгүй.

Тохиолдол:

Нэгэн байгууллагад 2005 онд төрийн хянан шалгах газраас хийсэн шалгалтаар ня-бо С-ийн ажилд дутагдал байна гэж дүгнэсний дагуу хуулиар түүнд торгууль ногдуулсан байна. Шалгалтаас хойш уг зөрчлийн талаар байгууллага дээр байнга л яригдах болжээ. Эцэст нь С өөрийгөө буруутай эсэх талаар хуулийн байгууллагаар тогтоолгох шаардлагатай юм байна гэж үзээд мөрдөн байцаах байгууллагад гомдлоо гаргах үед нь байгууллага 2006 онд түүний ажил албан тушаалыг түдгэлзүүлжээ. Мөн улмаар шалгагдаж байх үед нь 2007 онд ажлаас халсан тушаал гаргасан байна. Эдгээр тушаалын үндэслэл нь өмнө шалгалтаар илэрсэн гэх зөрчил л байдаг. С-ийн эрх зөрчигдсөн үү?

Дээр дурдсанаар зөрчилд шийтгэл оногдуулах хугацаа байх ба ажил олгогч зөрчил гараад хоёр жил орчмын хугацаа өнгөрч байхад

сахилгын шийтгэл оногдуулж байгаа нь үндэслэлгүй. Мөн ажилтны ажил албан тушаалыг түдгэлзүүлэхдээ хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн албан ёсны түдгэлзүүлэх хүсэлтийн дагуу л хийгдэхээс байгууллага өөрөө дур мэдэн албан тушаал, ажлыг түдгэлзүүлж болохгүй. Хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд саад болоогүй бол ажлаа хийж болно. Иймээс ажил олгогчоос гаргасан хоёр тушаал аль аль нь хууль зүйн үндэслэлгүй байна.

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛИАС

130.1. Ажил олгогч нь ажилтны төлөөлөгчдийн саналыг харгалзан хөдөлмөрийн дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ. Хөдөлмөрийн дотоод журамд хөдөлмөр зохион байгуулалт, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, хариуцлагыг тусгана. Төрийн зохих байгууллагаас сахилгын тусгай дүрэм батлан мөрдүүлж болно.

Сахилгын шийтгэлийг шат дараалан ногдуулахгүй ба зөрчлийн хэмжээнд тохируулан алиныг нь ногдуулахаа ажил олгогч шийдвэрлэх эрхтэй. Хэрэв зөрчлийг “ноцтой” гэж үзэж байгаа бол шууд ажлаас халах шийдвэр ч гаргаж болно.

Хөдөлмөр эрхлэх явцад зөрчил гаргах, түүнд шийтгэл ногдуулах зэрэгт ажил олгогч болон ажилтны хооронд санал зөрөлдөөн гарах нь бий. Үүнийг хөдөлмөрийн маргаан гэнэ. Хөдөлмөрийн маргаан хөдөлмөрийн гэрээнээс, эсвэл хамтын гэрээнээс үүдэн гарч байгаа эсэхээс хамаарч:

- хөдөлмөрийн ганцаарчилсан;
- хамтын маргаан гэж ангилна.

Ажилтан ба ажил олгогчийн хооронд үүсч байгаа санал зөрөлдөөнийг ганцаарчилсан маргаан гэх бол хөдөлмөрийн хамт олны төлөөлөгч ба ажил олгогч нарын хооронд үүсч байгаа маргааныг хамтын маргаан гэж нэрийднэ. Эдгээр маргаанаас ганцаарчилсан маргаан нь элбэг гардаг.

Хөдөлмөрийн гэрээний талууд хөдөлмөрлөх эрх ашиг зөрчигдөх буюу

- цалин хөлсийг бууруулах;
- өөр ажил, албан тушаалд дэвшүүлэх;
- ээлжийн амралтын олговрыг олгохгүй байх;
- илүү цагийн хөлс тооцохгүй байх;
- сахилгын шийтгэл ногдуулах зэрэг олон асуудлаар санал зөрөлдөн, маргаан үүсч болно.

Эдгээр нь тухайн ажилтны хөдөлмөрлөх явцад, өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн гэрээнээс үүдэж гарч байгаа тул ганцаарчилсан маргаан гэж үзнэ.

Ганцаарчилсан маргааныг:

1. хөдөлмөрийн маргаан таслах комисс;
2. шүүх шийдвэрлэнэ.

Хөдөлмөрийн маргаан таслах комисс нь тухайн байгууллага дээр ажил олгогчийн төлөөлөгч болон ҮЭ эсвэл ажилтны төлөөлөлөөс бүрдэж байгуулагдана. Уг комисс Хөдөлмөрийн тухай хуульд заасан шүүхэд харьяалуулснаас бусад маргааныг ажилтны гаргасан өргөдлөөр хүлээн авч, шийдвэрлэнэ.

Тохиолдол:

А, М нар ярилцана.

А: Хөдөлмөрийн гэрээнээс үүдэх маргааныг маргаан таслах комисс эгч байгууллага шийдвэрлэнэ гэж байна. Гэтэл тэр байгууллагыг байгуулаагүй ажил олгогч нар байх юм. Тэгвэл яах бол, хаана хандах вэ?

М: Нэгэнт л маргаан таслах комисс шийдвэрлэнэ гээд заасан бол тэр нь шийдэж таарна. Байхгүй бол шүүх л шийдэж таарах байх.

А: Шүүхэд өргөдлөө гаргахдаа хэдийд ч өгч болох уу?

М: Харин нэг анхаарах зүйл нь хуульд заасан хугацаа байдаг юм билээ.

Ажил олгогчийн санаачлагаар ажлаас буруу халсан, буруу ажилд шилжүүлсэн талаарх гомдлыг ажил олгогчийн шийдвэр, тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш нэг сарын дотор гаргана.

Үүнээс бусад маргааны хувьд эрхээ зөрчигдсөнийг мэдсэн буюу мэдэх ёстой байсан өдрөөс хойш 3 сарын дотор шүүхэд хандах эрхтэй.



V. БИЗНЕС - ХУУЛЬ

1. Хоршоо
2. Нөхөрлөл
3. Компани
4. Үнэт цаас



V. БИЗНЕС - ХУУЛЬ

1. Хоршоо

*Авдарт байтал алсаас эрэх
Тарт байтал гаднаас эрэх*

Тохиолдол:

Мужаан Дондов нутгийн хэдэн найз нартайгаа хамтран хөрөнгө, хүч хөдөлмөрөө нэгтгэн модон эдлэл хийдэг хоршоо байгуулан бизнес эрхлэх хүсэлтэй бөгөөд ингэхийн тулд хоршооны талаар нэн тэргүүнд мэдвэл зохих зүйлсийн талаар хууль зүйн зөвлөгөө авахыг хүсчээ.

Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ. Хоршоог 9-өөс доошгүй, хадгаламж, зээлийн хоршоог 20-иос доошгүй тооны иргэд хамтарч байгуулна. Бусдын өмнө хүлээх үүргийг өөрийн эд хөрөнгөөрөө хариуцна. Эд хөрөнгө нь хүрэлцэхгүй бол гишүүд нь нөхөж хариуцдаг.

Хоршооны тухай хуульд хоршооны үйл ажиллагааны төрлийг заасан байдаг.

- Түүхий эд боловсруулалтын;
- Үйлдвэрлэлийн;
- Хадгаламж, зээлийн;
- Борлуулалт, хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн;
- Үйлчилгээний;
- Орон сууц барих зориулалтын;
- Эд хэрэглэгчдийн;
- Дүрэмд заасан үйл ажиллагаа.

Дээр дурдсан үйл ажиллагааны төрлөөс хэд хэдэн төрлөөр нь ч ажиллаж болно.



Хоршоо байгуулахын тулд нэн тэргүүнд дүрмээ боловсруулан бүх гишүүдийн хурлаараа баталсан байх хэрэгтэй. Дүрмээ баталснаас хойш 30 хоногийн дотор хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлөө гаргана. Хоршоог бүх гишүүдийн хурлын шийдвэрээр эсвэл шүүхээс татан буулгадаг. Дампуурсан, гишүүдийх нь тоо заасан хэмжээнд хүрэхгүй болсон, хууль ноцтой зөрчсөн, хууль, дүрэмд зааснаас өөр үйл ажиллагаа явуулсан зэрэг нь шүүхээс хоршоог татан буулгах үндэслэл болдог.

Хоршоо нь хуулийн этгээд болохынхоо хувьд өөрийн удирдлага, зохион байгуулалттай юм. Хоршооны удирдлагын бүтцийг пирамид хэлбэрээр харуулбал:



Хоршооны гишүүний эдлэх эрх:

- Хоршооноос зохих үйлчилгээ авах;
- Гишүүнээс гарах, дахин элсэх;
- Удирдлагад сонгогдох, сонгох;
- Жилийн орлогоос хувь хүртэх;
- Бүх гишүүдийн хуралд оролцож, санал, асуулт тавих, шийдвэр гаргахад оролцох, хурлын тэмдэглэлтэй танилцах;
- Гишүүдийн бүртгэлтэй танилцах;
- Өрсөлдөгч бус хоршоонд гишүүн байх, хуулийн этгээдийн хувь нийлүүлэгч байх.

Хоршооны гишүүний хүлээх үүрэг:

- Хоршооны үйл ажиллагаанд оролцох;
- Холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөх, оруулах хувь хөрөнгөө хугацаанд нь бүрэн нийлүүлэх;
- Хоршооны болон бусад гишүүдийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- Өөр хоршоонд гишүүнээр элссэн тухайгаа даруй мэдэгдэж байх.

2. Нөхөрлөл

*Ажлын сайнаар баяжиж
Бэлгээрийн сайнаар таргалах*

Нөхөрлөл гэж гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хариуцдаг хуулийн этгээдийг хэлнэ. Нөхөрлөлийг:

1. бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай
2. зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай гэж 2 янзын хэлбэрээр байгуулах боломжтой.

Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай буюу “ББ” нөхөрлөлийн онцлог нь түүний бүх гишүүд нь нөхөрлөлд оруулсан эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө нөхөрлөлийн эд хөрөнгө хүрэлцэхгүй

тохиолдолд нөхөрлөлийн өмнөөс хариуцлага хүлээдэгт оршино.

Харин зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай буюу “ЗБ” нөхөрлөл гэж тухайн нөхөрлөлийн хүлээсэн үүргийг нэг болон түүнээс олон зарим гишүүд нь нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцдаг, бусад гишүүд нь зөвхөн оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг бизнесийн байгууллага юм.

Аливаа нөхөрлөлийг үүсгэн байгуулахдаа гишүүд үүсгэн байгуулах гэрээг хэлэлцэн тохирч хамтран байгуулах шаардлагатай. Уг гэрээнд дараах зүйлсийг тусгана:

- Оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;
- Эрхлэх үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, үйл ажиллагаа явуулах хугацаа;
- Удирдах, төлөөлөх эрх бүхий этгээдийн овог нэр, хаяг, регистрын дугаар;
- Гишүүн бүрийн оруулсан хөрөнгийн хэмжээ, үнэлгээ, үнэлэх аргачлал, буцаан олгох нөхцөл болон үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар;
- “ЗБ” нөхөрлөлийн хувьд гишүүн бүрийн хариуцлагыг ялгаж заах;
- Хэрвээ ажиллах чадвараа нэгтгэж байгаа бол түүний үнэлгээ, үнэлэх аргачлал, үзүүлэх үйлчилгээ, хугацаа;
- Ашиг, алдагдал хуваах зарчим;
- Гэрээ байгуулсан огноо;
- Гишүүдийн овог, нэр, иргэний харьяалал, хаяг, гарын үсэг.

Ийнхүү гэрээг байгуулснаас хойш 7 хоногийн дотор улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэн хуулийн этгээдийн эрхтэй болно.

3. Компани

*Ажлаар баяждаг
Архиар ргйрдэг*

Компани гэж юу вэ?

Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, ашиг олох үндсэн зорилготой үйл ажиллагаа явуулдаг бизнесийн байгууллага юм.

Хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/

Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хязгаарлагддаг;

Үүсгэн байгуулагчдын тоо 50-аас дээшгүй;

Хувьцаагаа хаалттай хүрээнд гаргаж, гишүүд нь тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй.

Хувьцаат компани /ХК/

Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаагаа нээлттэй болон хаалттай хэлбэрээр чөлөөтэй худалддаг;

Хувьцаа эзэмшигчийн тоо хязгааргүй;

Хувьцаагаа чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй.

Аливаа компани өөр компанийн энгийн хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байвал эзэмшигч тал нь толгой компани, нөгөө компани нь **охин компани** болно. Харин компанийн хувьцааных нь 20-50 хувийг өөр толгой компани эзэмшиж байвал уг компани нь **хараат компани** юм. Хараат болон охин компани нь толгой компанийнхаа өрийг хариуцахгүй.

Компанийн оршин байгаа газраас өөр газар байрлан, компанийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа нэгжийг компанийн салбар гэнэ. Салбар нь хуулийн этгээдийн эрхийг бие даан эдлэхгүй бөгөөд үйл ажиллагаанаас нь үүсэх үр дагавар, хариуцлагыг компани хүлээнэ.

Компани байгуулах

Тохиолдол:

Иргэн Навчаа, Цогт, Оюун, Доржоо нар хамтран бизнес хийхээр шийдэж гадаад худалдааны чиглэлээр компани байгуулахаар тохиролцсон байна. Гэвч хэд хоногийн дараа Оюун «Би компаниа бүртгүүлэхээр холбогдох бүх бичиг баримтаа бүрдүүлчихсэн та нар дамжуулж үзээд гарын үсгээ зураарай» гэжээ. Харин бусад нь бид хамтран хурал хийж хэлэлцэн албан ёсоор шийдвэр гаргах хэрэгтэй гэж үзсэн байна.

Компанийг шинээр үүсгэн байгуулахад нэн тэргүүнд үүсгэн

байгуулагчдын хурлаа хийх хэрэгтэй. Нэг хүн ганцаараа ч компаниа байгуулж болно. Компани байгуулах тухай хурлын шийдвэр эсвэл ганц гишүүнтэй компани бол уг үүсгэн байгуулагчийн шийдвэр, үүсгэн байгуулагчдын боловсруулан баталсан дүрэм, гэрээ нь компанийг үүсгэн байгуулах баримт бичиг болно. Эдгээр баримт бичгээ бүрдүүлсний дараа хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж гэрчилгээ авч, тамга тэмдгээ хийлгэнэ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;
- хуулийн этгээд байгуулах тухай эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн эх хувь, эсхүл хуулбар, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;
- хуулийн этгээдийн дүрэм;
- хуульд заасан бол үүсгэн байгуулах гэрээ;
- гадаадын иргэн, гадаадын хуулийн этгээд үүсгэн байгуулагчаар оролцож байгаа бол гадаад паспортын хуулбар, хуулийн этгээдийн тухайн улс дахь улсын бүртгэлийн бичилтийн хуулбар, гадаадын хөрөнгө оруулахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллагын шийдвэр, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар;
- улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

Компаниа байгуулах талаарх анхны үүсгэн байгуулах хурлаараа доорх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх хэрэгтэй байдаг.

1. Яагаад, ямар учраас компани байгуулах болсон зэрэг компани байгуулах тухай асуудал;
2. Дүрэм;
3. Хувьцаа, түүний үнэ;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн талаар;
5. Үүсгэн байгуулахад гарсан зардлын талаар;
6. Хувь нийлүүлсэн хөрөнгөө оруулж дуусах хугацаа.

Бүх үүсгэн байгуулагчид нь хуралд оролцож, тэнцүү эрхтэйгээр саналаа өгч, дийлэнх олонхийн саналаар гаргасан шийдвэр хүчин төгөлдөр байна.



Компаниа удирдах нь

Аливаа бизнесийн үйл ажиллагаа амжилттай байх эсэх нь удирдлага, менежментээсээ ихээхэн хамаардаг тул компанийг удирдах бүтэц, бүрэлдэхүүнийг зөв бүрдүүлж, тогтвортой сайн ажиллуулахад компанийн удирдлагын талаарх журам, хуулийн зохицуулалтыг ягштал мөрдөж байх нь нэн чухал юм.

Нийт хувьцаа эзэмшигчдийн хурал нь компанийн эрх барих дээд байгууллага юм. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь дүрмээ батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулах зэрэг томоохон шийдвэрүүдийг гаргадаг.

Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрхийг барих удирдлага юм. Энэ нь компанийн бодлого, чиглэлийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах, гүйцэтгэх захирлыг сонгох, хувьцаа гаргах, салбар болон төлөөлөгчийн газар байгуулах зэрэг эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Гүйцэтгэх удирдлага нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг компанийн удирдах дээд байгууллагуудаас олгосон эрх хэмжээний хүрээнд зохион байгуулна. Гүйцэтгэх удирдлага нь компанийг төлөөлөх, гэрээ хэлцэл байгуулах, үйл ажиллагаагаа ТУЗ-д тайлагнах зэрэг ажлыг ТУЗ-тай байгуулсан гэрээнд нь тусгагдсан эрх мэдлийг хэрэгжүүлнэ.

Компанийхаа үйл ажиллагааг зогсоох

Компанийн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэн явуулах шаардлагагүй эсвэл боломжгүй болсон гэж хувьцаа эзэмшигчдийн хурлаас үзвэл татан буулгах шийдвэрийг гаргана. Мөн тухайн компани дампуурсан, нэг ч гишүүн үлдээгүй, хуулийг ноцтой зөрчсөн зэрэг үндэслэлээр шүүхээс татан буулгах шийдвэр гаргаж болно. Улсын бүртгэлийн байгууллага бүртгэлээс хассанаар тухайн компанийг татан буугдсанд тооцно.

4. Үнэт цаас

*Багаас их болж
Нямгэнээс зузаан болдог*

Иргэд бизнесийн харилцаанд оролцон ашиг орлого олох, өмчлөх эрхээ хэрэгжүүлэх нэг арга нь үнэт цаасны зах зээлийн харилцаанд идэвхтэй оролцон хөрөнгө оруулах явдал юм. “Үнэт цаасны зах зээл” гэж үнэт цаас гаргах, бүртгүүлэх, худалдах, арилжих, хадгалах, уг үнэт цаасаар гэрчлэгдэж байгаа өмчлөх эрхийг шилжүүлэхтэй холбогдсон харилцааг хэлнэ.

Үнэт цаас гэж юу вэ?

Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компанийн хувьцаа, компанийн хувьцааг худалдах, худалдан авах эрхийн опцион, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг хэлнэ.

Үнэт цаас нь ногдол ашиг хүртэх, эрсдэл багатай, хөрвөх чадвар сайтай, ханшийн өсөлтөөс ашиг олох, тогтмол орлоготой хөрөнгө оруулалт болох зэрэг давуу талтай.

Хувьцаа. Компанид хөрөнгө оруулж хувь хүртэх, тухайн компанийн үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчийнхээ хувьд оролцон тодорхой эрх эдлэхийг гэрчилсэн үнэт цаас.

Өрийн бичиг /бонд/. Тодорхой хугацааны туршид болон дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүрэгтэй болохыг гэрчилсэн үнэт цаас.

Брокер болон дилер. Үнэт цаасны зах зээл дээр бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авахыг брокерийн үйл ажиллагаа гэдэг бол ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдах, худалдан авах, арилжихийг дилерийн үйл ажиллагаа гэнэ. Эдгээр үйл ажиллагааг тусгай зөвшөөрөл авсан брокер, дилерийн компаниуд эрхэлдэг. Мэргэжлийн брокер, дилерийн тусламжтайгаар үнэт цаасны зах зээлд оролцсоноор мэргэшсэн туслалцаа, зөвлөгөө авч, эрсдэлийг багасгах зэрэг ач холбогдолтой.

Үнэт цаасны хэлбэр:

- **Нэрийн.** Нэрийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг гагцхүү түүнд нэр заасан этгээд эдэлнэ.
- **Мэдүүлгийн.** Мэдүүлгийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг уг үнэт цаасыг хууль журмынх нь дагуу олж авсан ямарваа этгээд эдэлнэ.
- **Зөвшөөрлийн.** Зөвшөөрлийн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг уг үнэт цаасыг өмчлөгч буюу түүнээс уг эрхийг шилжүүлж авахаар өөрийн нэр дээр холбогдох бичилт хийсэн этгээд эдэлнэ.

Эдгээр эрх эдлэгчид нь үнэт цаасны өмчлөгч байна.

Үнэт цаасны зах зээлд оролцохдоо брокер, дилерийн компаниар дамжуулан “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжид үндсэн болон холболтын данс нээлгэх шаардлагатай. Үндсэн данс гэдэг нь уг төвлөрсөн хадгаламжид анх удаа данс нээж гүйлгээ, төлбөр тооцоо хийх данс. Холболтын данс гэдэг нь үндсэн данснаасаа гадна өөр брокер, дилерийн компаниар үйлчлүүлэхэд нээлгэх данс.

Үнэт цаасны арилжаанд оролцохдоо үйлчлүүлэх байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдал, нэр хүнд, туршлага зэргийг сайтар судлан үзэж, мэдээлэлтэй болсныхоо дараа сонголт хийх нь зүйтэй. Холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг байгууллагаас авч болно.





VI. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ-ХУУЛЬ

1. Нийгмийн даатгал
2. Эрүүл мэндийн даатгал
3. Нийгмийн халамж



Нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжүүд олгогдох үндэслэл, бүрдүүлэх бичиг баримт, тэтгэвэр, тэтгэмжийн ялгааны талаарх мэдээлэл иргэд бидэнд байнга хэрэгтэй байдаг.

VI. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ - ХУУЛЬ


1. Нийгмийн даатгал

*Тол морон ширүүн боловч эргээ дагаж урсдаг
Улс амьтан олон боловч хуулиа дагаж амьдардаг*

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хүн амьд явах эрхтэй. Уг эрх нь нэг талаас төрийн хувьд амьд явах эрхийг хангах, хамгаалах үндсийг бүрдүүлдэг бол нөгөө талаас иргэд өөрсдийн болон бусад этгээдийн амьдрах боломж орлогыг бий болгохын тулд хөдөлмөрлөж, орлого бий болгоно. Гэхдээ хүн бүрийн хувьд энэхүү орлого бий болгох нь өөр өөр байдаг. Иргэд хөгшрөх, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх зэргээр хөдөлмөр эрхлэх боломж ямар нэгэн байдлаар хязгаарлагдаж, орлогын хомсдолд орохоос сэргийлэх ямар боломж байх вэ? Төрөөс энэ талаар ямар бодлого, арга хэмжээг авдаг вэ?

Үүний хариулт бол нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалт юм. Нийгмийн хамгааллын эрх зүйн хүрээнд иргэдийг нэгдүгээрт, өөрөө өөрийгөө болзошгүй эрсдлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлж, түүндээ хамрагдах, хамгаалах хоёрдугаарт, өөрийгөө эрсдлээс хамгаалах боломжгүй бол төрөөс хамгаалах гэсэн зохицуулалтыг бүрдүүлсэн байна.

Өөрсдийгөө хамгаалах арга хэрэгсэл бол нийгмийн даатгал юм. Нийгмийн даатгал гэдэг нь хөдөлмөр эрхэлж, орлого бий болгож байгаа иргэд хамрагдан, мөнгөн хуримтлал үүсгэн, шаардлагатай үед түүнийгээ тэтгэвэр, тэтгэмжийн хэлбэрээр авах эдийн засаг болон эрх зүйн арга юм.



Нийгмийн даатгалд иргэд заавал буюу сайн дураар хамрагдана.

Хэн заавал хамрагдах вэ?

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад

Иргэний хуульд заасан хөлсөөр ажиллах, болон ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллагсад

Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

Төрийн албан хаагч;

Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн

Заавал хэлбэрээр нийгмийн даатгалд хамрагдах иргэд хөдөлмөрийн болон бусад гэрээг байгуулан ажиллаж, цалин хөдөлмөрийн хөлс, орлогоосоо нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг хүлээнэ.

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажил олгогч хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулж, нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэгтэй. Үүний тулд хөдөлмөрийн гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажилтанд нийгмийн даатгалын, эрүүл мэндийн даатгалын дэвтэр нээнэ. Түүндээ сар бүрийн шимтгэл төлөлтийн талаар бичилт хийх үүрэгтэй.

Ажил олгогч дээрх үүргээ биелүүлээгүй бол үүнээс үүдэн учирсан гэм хорыг ажил олгогчоос шаардах, ажил олгогч түүнийг арилгах үүрэг хүлээнэ. Иргэд ажилд орж, цалин авахыг чухалчилдгаас бус нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл суутгагдаж байгаа эсэх, өөрт нь дэвтэр нээсэн эсэх, дэвтэрт бичилт хийж байгаа эсэхийг анхаарлын гадуур өнгөрөөх нь цөөнгүй.

Заавал даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө:

Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хэмжээ /хувиар/	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хэмжээ /хувиар/
Тэтгэврийн даатгал	7.0	7.0
Тэтгэмжийн даатгал	0.5	0.5
Эрүүл мэндийн даатгал	2.0	2.0
Ажилгүйдлийн даатгал	0.5	0.5
бүгд	10.0	10.0

Заавал даатгуулагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг ажил олгогч бүрэн төлнө.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагаас хамааралтайгаар ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос 3 хүртэл хувиар ялгавартай тогтоох бөгөөд ялгавартайгаар шимтгэл төлөх ажил олгогчийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан Засгийн газар тогтооно

Сайн дурын даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 10 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1,0 хувиас багагүй байна.

Тохиолдол:

“А” ХХК-д ажилд орсон Итгэл сар бүр 250 000 төгрөгний цалин авах болсондоо машид сэтгэл хангалуун байв. Хоёр жил дөрвөн сар ажиллаад ажлаасаа гарчээ. Гэтэл ажлаа хүлээлгэн өгсний дараа түүнд нийгмийн даатгалын дэвтэр өгсөнгүй. Учрыг нь тайлбарлахдаа “сарын цалин чинь 250 000 төгрөг бөгөөд ямар ч суутгал хийдэггүй байсан учраас та өөрөө яг л 250 000 төгрөг авдаг байсан биз дээ. Тэгэхээр нийгмийн даатгалын дэвтэр бичих үндэсгүй шүү дээ” гэж байгууллагын нягтлан хэлжээ.

Итгэлийн эрх ямар нэгэн байдлаар зөрчигдсөн үү.

Итгэлийн ажил нь байнга давтагдах шинжтэй байнгын ажлын байр учраас хөдөлмөрийн гэрээ байгуулагдана. Хөдөлмөрийн гэрээ байгуулсан бол ажил олгогч болон Итгэл аль аль нь нийгмийн даатгалын шимтгэл төлөх үүрэг хүлээнэ. Энэ үүргээ зөрчсөн бол ажил олгогч нийгмийн даатгалын ногдож байгаа шимтгэлийг нөхөн төлж, дэвтэрт бичилт хийж, Итгэлд өгөх ёстой. Байгууллага ийнхүү шийдвэрлэж өгөөгүй бол нийгмийн даатгалын байгууллагад хандах, улмаар шүүхэд хандах эрхтэй.

Цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос хуульд заасан хэмжээгээр шимтгэл ногдуулж суутгана. Ажил олгогч ажилтны өмнөөс төлөх ба эдгээр нь ажилтны нийгмийн даатгалын дэвтэрт бичигдэнэ. Нийгмийн даатгалын байгууллага түүнийг нь шалгаж баталгаажуулдаг.

Иргэд нийгмийн даатгалд даатгуулснаар шимтгэл төлөх бөгөөд шимтгэлийг:

- цалин хөлс, олговор;
- ажил гүйцэтгэх болон хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон хөлс;
- сайн дурын даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн орлого;
- аж ахуйн нэгж, байгууллагаас ажилтанд олгож байгаа хоол, унааны зардал, орон сууц, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, түүнтэй адилтгах бусад орлого зэрэгт ногдуулна.

Заавал хэлбэрээр төлөөгүй, төлөх боломжгүй байгаа иргэд яах вэ?

Хөдөлмөрийн гэрээ болон бусад гэрээгээр ажил олгогч болон гэрээний нэг тал болж ажиллаагүй иргэд өөрсдөө орлогоо тодорхойлж, сайн дураар нийгмийн даатгалд хамрагдах боломжтой. Сайн дураар хамрагдах иргэн өөрийн оршин байгаа газрын /нутаг дэвсгэрийн/ нийгмийн даатгалын байгууллагад хандан гэрээ байгуулж, дэвтрээ нээлгэнэ.

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж авах иргэдийг тэтгэврийн нэрийн дансны хуульд ялгаатай байдлаар хамруулсан. 1960 оны 1 сарны 1-с хойш төрсөн иргэд тэтгэврийн нэрийн дансны хуулийн зохицуулалтад хамрагдан, одоогоор шимтгэл төлж байгаа иргэд бүр данс нээлгэсэн байна.

Нийгмийн даатгалд зохих хугацаанд шимтгэл төлсөн байх нь ямар төрлийн тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсэхийг шийдвэрлэнэ.

Тохиолдол:

А, С нар ярилцана.

А:Би 15 жил ажиллаж байгаад сүүлийн 6 жилд ажил хийсэнгүй.

С:Тэгэхээр сүүлийн зургаан жилд нь нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй гэсэн үг үү

А:Тийм ээ, тэтгэвэр тогтоох болов уу, яах бол?

С:Одоо хэдэн настай билээ

А: 54 настай

С: Болоогүй ээ, 60 нас хүрэхэд дахиад 6 жил байна. Харин энэ хугацаандаа ажил эрхлэн нийгмийн даатгалын шимтгэлээ заавал хэлбэрээр төлөх боломжгүй бол сайн дураар төлж болно шүү дээ. Тэгвэл өндөр насны бүрэн тэтгэвэр авна.



Нийгмийн даатгалын сангаас

- Өндөр насны /хөдөлмөрийн/;
- Хөгжлийн бэрхшээлтэй;
- Тэжээгчээ алдсаны гэсэн тэтгэвэр олгогддог.

Эдгээр тэтгэврүүд нь ямар хугацаанд шимтгэл төлсөн байгаагаас хамаарч:

- бүрэн тэтгэвэр;
- хувь тэнцүүлсэн тэтгэвэр гэж ангилагдана.

Өндөр насны бүрэн тэтгэвэр нь нийгмийн даатгалын шимтгэлийг 20 ба түүнээс дээш төлсөн тохиолдолд бүрэн, харин 10-аас 20 хүртэл жил төлсөн бол хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоогдоно.

Тохиолдол:

Бат 18 жил 4 сар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, одоо 58 настай бол нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх үү?

Хэдийгээр өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоох боломж байгаа боловч өндөр нас гэдэг ойлголт нь манай улсын хуулиар 60 нас байх тул /эмэгтэй хүн 55 нас, уг насанд хүрээд тухайн эмэгтэй өөрөө хүсээгүй бол мөн л 60 нас хүрээд тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх/ 60 хүрч байж л өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгоход, хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгосон байх шаардлагатай.

Өндөр насны тэтгэвэр тогтоохдоо, тухайн даатгуулагчийн ажиллаж байсан хөдөлмөрийн нөхцөл байдлыг харгалзан:

- ердийн нөхцөлөөр тогтоох;
- хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох тэтгэвэр гэж ангилна.

Хөнгөлөлттэй нөхцөлийн тэтгэврийг тогтоохдоо ажилтан тухайн хуульд заасан хөдөлмөрийн нөхцөлд хуульд заасан хугацаанд л ажилласан байх ёстой. Уг хугацааг хангаагүй бол хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох эрхгүй болно. Үүнд:

- нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь газрын дор ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 50 нас хүрсэн бол;
- нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь

хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 50 нас хүрсэн, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 45 нас хүрсэн бол;

- нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 12 жил 6 сараас доошгүй хугацаагаар хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн, түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил, үүнээс 10-аас доошгүй жил нь мөн нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол;
- Сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглэлийн гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургаж тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжмийн үлээвэр хөгжимчнөөр 20-оос доошгүй жил ажилласан, эсхүл нийтдээ 25-аас доошгүй жил, үүнээс 15-аас доошгүй жил дурдсан мэргэжлээр ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн иргэн, мөн 25-аас доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд ажилласан даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Харин нийгмийн даатгалын шимтгэлийг 20 ба түүнээс дээш жил төлөөд ердийн өвчин, ахуйн ослоор хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хэсэгчилэн алдсан этгээд тахир дутуугийн бүрэн тэтгэвэр, нийтдээ 3 –с доошгүй жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, дээрх байдлаар хөдөлмөрийн чадвараа алдсан бол тухайн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох эрх үүснэ.

Хөдөлмөрийн чадвар алдалт гэдэг нь тодорхой шалтгаанаар бие эрхтний бүрэн бүтэн байдал алдагдаж, хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдахыг ойлгодог. Хөдөлмөрийн чадвар алдалтыг:

- бүрэн /100-70 хувь/
- хэсэгчилсэн /50-69 хувь/ гэж ангилна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа



Харин уг хөдөлмөрийн чадвар алдагдахдаа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас болсон гэдэг нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлал, үйлдвэрлийн ослын актаар тогтоогдсон бол тахир дутуугийн тэтгэвэр нь үйлдвэрийн ослын даатгалын сангаас олгогдоно.

Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгалах өвчин нь ажлын байранд, ажил үүргээ гүйцэтгэхтэй холбогдсон ойлголт юм. Тэгэхээр, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад болон бусад гэрээгээр ажиллаж байгаа иргэдэд хамааралтай ойлголт.

Тахир дутуугийн шалтгааныг үйлдвэрийн осол, ахуйн осол болон мэргэжлээс шалтгаалах өвчин ба ердийн өвчин гэж ангилах нь ач холбогдолтой.

1. Тэтгэвэр олгох сан нь өөр. Ердийн өвчин, ахуйн осол бол нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн сангаас тэтгэвэр бодогдоно. Харин үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин бол үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн тэтгэвэр олгоно.
2. Тэтгэвэр бодох арга нь өөр. Үйлдвэрийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдагдсан бол цалин хөдөлмөрийн хөлснөөс чадвар алдсан хувиар тогтооно. Жишээ нь: 60

хувиар чадвар алдагдсан бол цалингийн 60 хувиар гэх мэт. Харин ердийн өвчин ахуйн ослоор хөдөлмөрийн чадвар алдагдсан бол шиймтгэл төлсөн хугацааг харгалзан бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогоох эсэх асуудал гарна. Нөгөө талаар хөдөлмөрийн чадвар алдагдсан хувь хэмжээг харгалзан тэтгэврийг тогтооно.

Иймээс ердийн өвчин ахуйн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрийн осол гэдэг үндэслэл нь тахир дутуугийн тэтгэврийг ялгах нэг шалтгаан болно. Өөрөөр хэлбэл, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин гэж үзэж байгаагаас бусад шалтгаан үндэслэл нь ердийн өвчин ахуйн осол болно. Гэхдээ иргэд заримдаа мэргэжлээс шалтгаалах өвчин, үйлдвэрлэлийн осолд орж, хөдөлмөрийн чадвараа алдсан хэрнээ, түүнийгээ мэдэлгүй ердийн өвчин, ахуйн ослоор тэтгэврээ тогтоолгосон байх тохиолдол байдаг.

Тохиолдол:

Чулуун барилгын компанид ажилладаг. Нэг удаа ажлаа хийж байх үед нь өндрөөс хүнд зүйл түүний нуруун дээр унасан боловч тухайн үед өвдөж мэдэгдээгүй тул ажлаа хийсээр сар гаруй болжээ. Гэтэл 2 сарын дараагаас нуруу нь хөшиж өвдөөд ажил хийхэд хүнд болжээ. Эмнэлэгт хэвтэн үзүүлэхэд нурууны ясны сэртэн гэмтсэн, хөдөлгөөнгүй хэвтэн эмчлүүлэх шаардлагатайг хэлжээ. Эмнэлэгт дахин 2 сарын эмчилгээ хийлгэж байх үедээ энэ өвчин нуруун дээрээс унасан хүнд зүйлээс болсон болохыг сүүлд мэдсэн байна. Осол болсноос хойш 3 буюу 4 сарын дараа ослын акт гаргуулж болох уу.

Чулуун нийгмийн даатгалын сангийн тахир дутуугийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гэх үндэслэлээр тогтоолгосон байсан бол үйлдвэрийн ослын тэтгэвэр болж өөрчлөгдөх үү?

Үйлдвэрийн ослын акт нь осол гарснаас хойш 6 сарын дотор үйлдэгдэн гарах ба харин түүнээс дээш хугацаа хэтэрсэн бол нөхөн гардаггүй. Иймд Чулууны хувьд хараахан 6 сар болоогүй байгаа учраас үйлдвэрийн ослын акт гаргуулж болно.

Хэн үйлдвэрийн ослын акт гаргах эрхтэй вэ?

Ажил олгогчоос үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг ажил олгогчийн болон ажилтны төлөөлөл бүхий 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйгээр ажил олгогчийн шийдвэрээр байгуулж, комиссын даргыг томилно.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас нэг, ажил олгогч болон ажилтны төлөөллөөс тус бүр хоёр хүний бүрэлдэхүүнтэйгээр Засаг даргын захирамжаар байгуулсан комисс дараах нөхцөл байдалд гарсан ослыг судлан бүртгэж, акт тогтооно:

- жижиг, дунд үйлдвэрт гарсан;
- хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээгээр ажил, үүрэг гүйцэтгэж байхдаа;
- хувиараа хөдөлмөр эрхлэх үед.

Үйлдвэрийн осолд :

- ажилтан ажлын үндсэн болон туслах байранд, эсхүл гэрээ хэлэлцээр, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу албан томилолт, дайчилгаагаар бусад газарт ажил үүргээ гүйцэтгэж байхдаа;
- ажлын байр, нэгж, хэсэг, салбарын хооронд байнга явж ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтан ажлын цагаар бүх төрлийн тээврийн хэрэгсэл, ердийн хөсгөөр буюу явган явж байх үед;
- ажлын байраа орхих боломжгүй ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтан ажлын байрандаа амарч байх, ажил эхлэхийн өмнө болон ажил дууссаны дараа ажлын байр, багаж хэрэгслээ эмхлэн цэгцлэх, хувцсаа солих, усанд орох, ажил хүлээлцэх үед;
- ажилдаа ирэх, буцах замдаа аливаа тээврийн хэрэгслээр буюу явган явж байхдаа (энэхүү ослыг тогтоохдоо тухайн ажилтны гэр, ажлын байр хоорондын чиглэл, цаг хугацааг үндэс болгоно);
- үндсэн ажил үүргээ гүйцэтгэх үедээ байгаль, цаг уур, гал, усны гэнэтийн аюул, цацраг идэвхит болон химийн хорт бодисын нөлөөлөл, биологийн гаралтай өвчин үүсгэгчийн гэнэтийн аюулд өртсөн;
- тухайн байгууллагад ашиглаж байгаа түүхий эд, материал

болон бусад технологийн процессод ашигладаг химийн бодис, биологийн гаралтай бохирдуулагчийн улмаас үүссэн өвчин, хордлогод өртсөн;

- байгалийн гэнэтийн аюул, гамшиг, хөнөөх хэрэгслийн болон гоц халдварт өвчний голомт, сүйрэл, дэлбэрэлтийн үед.

Ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ зам тээврийн осолд орсон тохиолдолд ослыг замын цагдаагийн байгууллагын дүгнэлтийн дагуу хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч судалж баталгаажуулна.

Түүнчлэн хэдийгээр ажлын байранд болсон, ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой боловч үйлдвэрийн осолд тооцохгүй дараах үндэслэл байдаг.

- ажил олгогчийн шийдвэргүйгээр үндсэн үүрэгт ажлаасаа өөр ажил гүйцэтгэж байгаад осолдох;
- ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэснээс осолдох;
- ажлын байраа орхиж явсан, аюулгүй ажиллагааны зааварчилга авсан боловч технологийн горимыг ажилтан өөрөө санаатайгаар өөрчилснөөс осолдох;
- гэмт хэрэг үйлдэх үедээ өөрийн биед гэмтэл учруулах.

Иргэд хоорондын гэрээгээр ажил гүйцэтгэх үед болон иргэний машин механизм, тоног төхөөрөмжийг түрээслэх, бусад хэлбэрээр ашиглах явцад гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг гэрээ байгуулж байгаа талууд тухайн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу судлан бүртгэнэ. Хэрэв гэрээнд энэ талаар тусгагдаагүй бол ажил гүйцэтгүүлэгч - захиалагч тал гарсан осол, хурц хордлогыг судлан бүртгэж, хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу барагдуулна.

Батлан хамгаалах, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, уул уурхайн аврах албанд гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг үйлдвэрийн ослын дүрмийн дагуу судлан бүртгэж, хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу барагдуулна.

Тусгай зөвшөөрлийн дагуу гадаадад ажиллах хүч гаргаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаар зуучлуулсан иргэн гадаадад ажиллаж байхдаа үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн тохиолдолд осолтой холбоотой нөхөн төлбөрийн асуудлыг ажиллуулж байгаа

аж ахуйн нэгж, байгууллага тухайн оронд мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Гадаадад ажиллаж байхдаа үйлдвэрлэлийн осолд өртсөн иргэн нь хоёр улсын хооронд байгуулсан гэрээний дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан бол тусгай зөвшөөрлийн дагуу гадаадад ажиллах хүч гаргаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь ослыг судлан бүртгэнэ.

Тохиолдол:

А, С нар ярилцана.

А: Тахир дутуугийн тэтгэвэр авагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох уу, эсвэл тэр тогтоолгосон тэтгэвэрээ л авсаар байх уу?

С: Өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсвэл, тухайн авч байсан тэтгэвэрээ өндөр насны тэтгэвэр болгон өөрчилж болдог гэсэн. Өөрчлөх эсэх нь өөрийнх нь сонгох эрх юм байна лээ.

А: Авах тэтгэвэр мөнгөн хэмжээний хувьд ялгаагүй бол шаардлагагүй гэсэн үг үү?

С: Тийм ээ, өндөр насны тэтгэвэр тогтоолгохдоо хөдөлмөрийн чадвараа алдсан жил тутамдаа тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингийн 1 хувиар нэмэгдэл авах ёстой.

Нийгмийн даатгалын сангаас олгох нэг төрлийн тэтгэвэр нь тэжээгчээ алдсаны тэтгэвэр байдаг. Уг тэтгэвэр нь нийгмийн даатгалын шиймтгэлийг 20-оос доошгүй жил төлсөн, тэжээгч болох иргэн-даатгуулагч нас барсан үед гэр бүлийнх нь хөдөлмөрийн чадваргүй буюу чадваргүйд тооцогдох иргэдэд олгох ба харин нэг жил тасралтгүй нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, тэжээгч нь нас барсан бол хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтооно.

Тэжээгч болох даатгуулагч ямар шалтгаанаар нас барсан нь ямар төрлийн сангийн тэтгэвэр авах асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослоор нас барсан бол нийгмийн даатгалын сангийн, үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс болж нас барсан бол үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн тэтгэвэр тогтоолгоно.

Даатгуулагч нас барахад, түүний гэр бүлийн хөдөлмөрийн

чадваргүй гишүүд тэтгэвэр тогтоолгоно. Харин тэтгэврийг тэдгээрийг нэгтгэн бодож тогтоодог. Тэтгэвэр авагч хөдөлмөрийн чадвартай болсон, эсвэл насанд хүрсэн, түүнчлэн нас барснаар тухайн төрлийн тэтгэврийн харилцаа дуусгавар болно.

2. Эрүүл мэндийн даатгал

Ес сөрговөл мөхөж Журам дагавал дэгжих

Эрүүл мэндийн даатгал нь нийгмийн даатгалын нэг бие даасан төрөл мөн. Монгол улсын иргэд эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна. Харин гадаадын иргэд сайн дураар даатгуулна.

Эрүүл мэндийн даатгалд даатгуулахдаа өөрсдөө даатгалын хураамжаа хариуцах, төр хураамжийг нь хариуцах гэсэн ялгаатай зохицуулалт байна.

Доор дурдсан иргэд өөрсдөө эрүүл мэндийн даатгалын хураамжаа хариуцах ба төлөх журам нь өөр өөр байж болно.

- аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан;
- аж ахуйн нэгжийн эзэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;
- их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч;

Дараах иргэдийн эрүүл мэндийн даатгалын хураамжийг хүний хөгжил сангийн төсвөөс хариуцана.

- малчин;
- ял эдэлж байгаа хоригдол;
- ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 хүртэлх насны хүүхэд;
- тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн;
- хүүхдээ 2 /ихэр бол 3/ нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх / эцэг;
- хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч гэх мэт.



Эрүүл мэндийн даатгалын сан нь даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл, ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл, төр даатгалыг нь хариуцах иргэдэд Хүний хөгжил сангийн төсвөөс төлсөн шимтгэл, сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хэтрүүлсэнд оногдуулсан алдангиас бүрдэнэ.

Уг сангийн хөрөнгө даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний зардал, заасан эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зардал, эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны зардал, эрүүл мэндийн даатгалын зөвлөлийн гишүүдийн урамшуулал, дараалсан гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ аваагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулж урамшуулах зардал, сангийн 10 хувьтай тэнцэх хөрөнгийг болзошгүй эрсдэлийн нөөцөд хуваарилан үлдээх зэрэгт зарцуулагдана.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ нь шаталсан хэлбэртэй байх бөгөөд анхан шатны /өрхийн эмнэлэг/, аймаг, дүүргийн эмнэлэг, улсын клиникийн эмнэлэг гэх зэргээр ялгаатай байх ба хаана

хандаж эмнэлгийн үйлчилгээ авснаас хамаарч, даатгал болон өөрөө хариуцах зардлын хувь хэмжээ өөр өөр байдаг.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХУУЛИАС ...

12.5. /хүний хөгжлийн сангаас шимтгэлийг хариуцдаг даатгуулагчаас бусад/ заавал даатгуулагч болон сайн дурын даатгуулагч эмчилгээний хувьсах зардлын 10 хувийг аймаг, дүүргийн эмнэлэг, бүсийн оношлогоо, эмчилгээний төвд, 15 хувийг улсын хэмжээний үйлчилгээтэй клиникийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд өөрөө хариуцана.

3. Нийгмийн халамж

*Хуулиа саживал хэрэг бртнэ
Хэтээ бодвол улс хөгжинө*

Хүн амьдрах боломж, нөхцөлөө өөрөө бүрдүүлдэг. Гэвч амьдралын явцад, өөртөө орлого бий болгож чадахгүй нөхцөл байдлууд байдаг. Ийм иргэдийг бусдын туслалцааг шаардаж байгаа иргэд гэх ба нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж олгох, бусад туслалцааг үзүүлнэ.

Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг иргэдийн төлж байгаа шимтгэл, ажил олгогчийн төлөх шимтгэлээс бүрдүүлдэг бол нийгмийн халамжийн санг

- төсвөөс олгох хөрөнгө;
- сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;
- олон улсын байгууллага, гадаад орнуудаас өгсөн хандив, тусламж;
- аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламжаас бүрдүүлдэг.

Иймээс халамжийн сангийн хөрөнгийг бусдын туслалцааг шаардаж байгаа иргэнд олгох ба тухайн иргэнийг тогтоож

тодорхойлохдоо орон нутгийг захиргааны байгууллага, сум, хорооны нийгмийн халамжийн ажилтан, сум хороонд байх орон тооны бус Амьжиргааг дэмжих зөвлөл гэсэн талуудын оролцоотой шийдвэрлэнэ. Учир нь орон нутгийн захиргаа иргэнээ мэдэх, тэдэнд туслалцааг үзүүлэхдээ олон нийтийг оролцуулж байх үүднээс дээрх оролцоог бий болгосон байдаг.

Тохиолдол:

А, С нар ярилцана.

А: Нийгмийн даатгалд шимтгэл төлөөгүй, өндөр насанд хүрсэн иргэдэд төрөөс тусламж үзүүлдэг болов уу?

С: Өндөр настан нь төрөл садангүй, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаггүй бол нийгмийн халамжийн тэтгэвэр авч болно.

А: Өө, тийм тэтгэвэр байдаг юм уу, яаж авах вэ?

С: Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, сум, хорооны Засаг даргын тодорхойлолт, 2 хувь зураг, иргэний үнэмлэх, хуулбарын хамт, тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй болохыг нь тогтоосон Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт гэсэн баримт бичгийг бүрдүүлэн сум, хорооны нийгмийн ажилтанд өгнө.

А: Тэгээд болох юм уу?

С: Нийгмийн ажилтан уг асуудлыг Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлж, сумын нийгмийн ажилтан, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлдэг юм билээ. Тэгээд тэдгээр ажилтнууд материалыг хянан, шаардлага хангасан бол хувийн хэрэг нээн халамжийн тэтгэвэр олгоно.

А: Тэгвэл аргагүй л сайтар нягтлаж үздэг хэрэг байх нь.

Халамжийн сангаас:

- халамжийн тэтгэвэр;
- халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж;
- амьжиргааг дэмжих үүднээс тусламж үзүүлнэ.

Халамжийн тэтгэвэр нь дараах төрөлтэй ба мөн эдгээр тэтгэврийг хуулиар тавигдсан шаардлага хангасан иргэнд олгодог байна.

ахмад настны тэтгэвэр	• тэжээн тэтгэх хүүхэд, төрөл, садангийн хүнгүй, 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй • хууль ёсны тэжээн тэтгэгч нь ахмад настан, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэн бөгөөд тэдгээр нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон бол 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй
хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	• 16 насанд хүрсэн одой иргэн; • хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн
тэжээгчээ алдсан буюу өрх толгойлсон эцэг эхэд олгох тэтгэвэр	• тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд • 16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг

Хууль ёсны тэжээн тэтгэгч нь ахмад настан, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэн бөгөөд тэдгээр нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настан тэтгэвэр авахдаа:

- тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл;
- сум хорооны Засаг даргын тодорхойлолт;
- 2 хувь зураг, иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- хууль ёсны тэжээн тэтгэгч нь ахмад настан, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэн бөгөөд тэдгээр нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй болохыг тогтоосон Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр;
- нийгмийн датгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолтыг бүрдүүлнэ

16 насанд хүрсэн одой иргэн тэтгэвэр авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.

- тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, сум, хорооны Засаг даргын тодорхойлолт, 2 хувь зураг;
- иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт.

Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан, 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэтгэвэр авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

- тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, сум, хорооны Засаг даргын тодорхойлолт, 2 хувь зураг, иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт
- хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг тогтоосон эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр.

16 хүртэлх насны 4 болон түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг тэтгэвэр авахдаа

- тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, сум, хорооны Засаг даргын тодорхойлолт, 2 хувь зураг, иргэний үнэмлэх, хуулбарын хамт;
- 0-16 хүртэлх насны хүүхдүүдийн төрсний гэрчилгээ, хуулбарын хамт;
- өрх толгойлсон эх (эцэг) болохыг тогтоосон Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэр гэсэн бичиг баримтыг бүрдүүлнэ.

Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд тэтгэвэр авахдаа

- тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл, сум, хорооны Засаг даргын тодорхойлолт, 2 хувь зураг;
- нийгмийн даатгалын сангаас тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс (сумын нийгмийн даатгалын байцаагч)-ийн тодорхойлолт;

- тэжээгчийн нас барсны гэрчилгээ, хуулбарын хамт;
- 18 хүртэлх насны хүүхдийн төрсний гэрчилгээ (иргэний үнэмлэх хуулбарын хамт);
- 18 хүртэлх насны хүүхдийн эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч)-ийн иргэний үнэмлэх, хуулбарын хамт бүрдүүлдэг.

Сумын нийгмийн ажилтан, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага нь Амьжиргааг дэмжих зөвлөлийн саналыг харгалзан дараах тохиолдолд иргэний тэтгэврийг зогсоох шийдвэр гаргана:

- хууль ёсны тэжээн тэтгэх хүүхэд, төрөл садангийн хүнтэй болсон;
- нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүссэн;
- хууль ёсны тэжээн тэтгэгч ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжтой болсон нь тогтоогдсон;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөрийн чадвар алдалт нь 50 хувиас буурсан тухай эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр гарсан;
- өрх толгойлсон эцэг /эх/-ийн хүүхэд 16 нас хүрсэн;
- тэжээгчээ алдсаны тэтгэвэр авч байгаа хүүхэд 18 нас хүрсэн;
- тэтгэвэр авагч нь нас барсан.

Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа тэтгэмж нь бусдын туслалцаа шаардаж байгаа иргэнд тусламж үзүүлж байгаа иргэдэд олгогдож байдгаараа онцлог. Уг тэтгэмжийг нөхцөлт мөнгөн тэтгэмж гэж нэрлэнэ.

Тэтгэмжийн төрөл:

- ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох тэтгэмж;
- бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж;
- Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас сэтгэл санааны болон бие мах бодийн хохирол хүлээж

хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж;

- ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж;
- “Эхийн алдар” нэгдүгээр, эсхүл хоёрдугаар зэргийн одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламж;
- эхэд жирэмсний 5 сартайгаас эхлэн 12 сарын хугацаанд сар тутам олгох тэтгэмж.

Тохиолдол:

А нь нийгмийн халамжийн сангаас өрх толгойлсон олон хүүхэдтэй гэсэн үндэслэлээр тэтгэвэр авагч нэгэн. Гэтэл түүний аав М нь 74 настай, харж хандах хүнгүй бөгөөд түүгээр асруулахаас өөр аргагүй. Тэгвэл А ахмад настныг асарч байгаа гэсэн үндэслэлээр халамжийн тэтгэмж авч болох уу

Нийгмийнхаламжийнхуульдтэтгэврийгтэтгэмжтэйдавхардуулан авч болохгүй талаар заагаагүй тул А тэтгэврээс гадна, тэтгэмж авч болно.

Түүнээс гадна халамжийн тусламж шаардлагатай байгаа иргэнд:

- амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж;
- орон сууцны хөлсний болон түлшний үнийн хөнгөлөлт;
- халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт;
- протез, ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслэлийн хангамж;
- сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт;
- эх орны рашаан сувиллын зардлын хөнгөлөлт үзүүлдэг.

Дээр дурдсан амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийг дор дурдсан өрх, иргэнд олгоно:

- гурав хүртэлх насны ихэр хүүхдэд жилд нэг удаа;
- байнгын асаргаа шаардлагатай иргэнд улиралд нэг удаа;
- гурав ба түүнээс дээш тооны бага насны хүүхэдтэй /14 хүртэлх насны/ өрх толгойлсон эх /эцэг/-д жилд нэг удаа;
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд болон гэнэтийн аюул, ослын улмаас гэр оронгүй болсон өрхөд гэр авахад нь дэмжлэг үзүүлж нэг удаа.

VII. ИРГЭН - ХУУЛЬ

1. Хэн иргэний эрх зүйн харилцааны оролцогч вэ?
2. Итгэлцлэлийн үндэс-гэрээ
3. Гэм хор учруулснаас үүсэх үүрэг
4. Өв залгамжлал
5. Шүүхээр эрхээ хамгаалуулах нь



Иргэд бид нийгмийн харилцаанд оролцож, гэрээ, хэлцэл байгуулж, эрсдэлээс сэргийлж, хууль ёсны дагуу эд хөрөнгийн эрхээ хэрэгжүүлэхэд юуг анхаарах хэрэгтэй вэ?

VII. ИРГЭН - ХУУЛЬ

1. Хэн иргэний эрх зүйн харилцааны оролцогч вэ?

*Дуудах нэрийг эцэг эх
Дуурсах алдрыг өөрөө*

1. Иргэн. Хүн бүр худалдаа наймаа хийх, өв залгамжлах, бэлэг өгөх, авах, тээврийн хэрэгслээр зорчих зэргээр бүхий ламьдралынхаа туршид өдөр тутам иргэний эрх зүйн харилцаанд оролцож байдаг. Монгол Улсын Иргэний хуулиар төр, хуулийн этгээд, иргэд хоорондын эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулдаг.

Тохиолдол:

Золбоот 16 настай бөгөөд хичээлийнхээ хажуугаар цагийн ажил хийн хуримтлуулсан мөнгөөрөө найз нарынхаа бизнест хөрөнгө оруулалт хийхийг хүссэн боловч эцэг, эх нь зөвшөөрөөгүй байна.

Манай улсын хууль тогтоомжийн хүрээнд “иргэний эрх зүйн чадвар, чадамж” гэсэн ойлголт байдаг. Чадвар гэдэг нь хүн бүхэнд хамаарах ойлголт бөгөөд тухайн хүүхэд төрмөгцөө “иргэний эрх зүйн чадвар”-тай болж, нас барснаар чадвар нь дуусгавар болдог. Өөрөөр хэлбэл, тухайн хүн амьдралынхаа туршид эрх зүйн чадвартай байдаг. Нас барахаас бусад тохиолдолд “иргэний эрх зүйн чадваргүй болох” гэсэн ойлголт байхгүй бөгөөд түүнийг нь хязгаарлахыг хуулиар хориглосон байна.

Харин “иргэний эрх зүйн чадамж” гэдэг нь иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар юм. Чадамжийг дотор нь насны байдал, үүрэг, хариуцлага хүлээх чадвар зэргээс нь хамааран дараах байдлаар ангилдаг.

Бүрэн чадамж. Иргэн 18 насанд хүрснээр эрх зүйн хувьд бүрэн чадамжтай болж хүлээсэн үүрэгтэйгээ холбогдох хариуцлагыг өөрөө бүрэн хариуцдаг. Зарим тохиолдолд шүүхээс 16 настай иргэнийг

хэдийгээр 18 нас хүрээгүй ч бүрэн чадамжтай гэж тооцохыг Иргэний хуулиар зөвшөөрсөн байна.

Бүрэн бус чадамж. Насанд хүрээгүй буюу 14-18 хүртэлх насны хүн бүрэн бус чадамжтайд тооцогдоно. Тэд аливаа гэрээ хэлцлийг эцэг, эхийнхээ зөвшөөрөлгүйгээр хийх эрхгүй. Гэхдээ энэ насны хүүхэд нь өөрөө ажил хөдөлмөр эрхэлж олсон хөдөлмөрийн хөлс, оюутны тэтгэлэг, өөр бусад иймэрхүү орлогоо өөрөө захиран зарцуулах эрхтэй.

Зарим чадамж. 7-14 хүртэлх насны хүүхдийг “иргэний эрх зүйн зарим чадамжтай” гэж үздэг. Ийм насны хүүхдүүд нь өөртөө хохиролгүй бөгөөд хиймэгц биелэх, ахуйн чанартай жижиг хэлцлээс бусад хэлцлийг хийх эрхгүй бөгөөд тэдний өмнөөс эцэг, эх, асран хамгаалагч нь эрх зүйн харилцаанд оролцох ёстой.

Чадамжгүй иргэн. Бага насны буюу 7 хүртэлх насны хүүхэд иргэний эрх зүйн чадамжгүй байна. Мөн сэтгэцийн өвчтэй хүнийг шүүх чадамжгүйд тооцон асран хамгаалалт тогтоож болно.

Чадамжийг хязгаарлах. Хэдийгээр эрх зүйн бүрэн чадамжтай, насанд хүрсэн боловч архи, мансруулах бодис байнга хэрэглэн гэрийнхээ эд зүйлийг зарж үрэх зэргээр ар гэрийнхнээ эд материалын дутагдал, санхүүгийн хүнд байдалд оруулдаг хүний иргэний эрх зүйн чадамжийг шүүхээс хязгаарлаж болдог.

2. Хуулийн этгээд. Иргэдээс гадна байгууллага албан ёсоор улсын бүртгэлд бүртгүүлэн гэрчилгээгээ авснаар иргэний эрх зүйн харилцааны нэг оролцогч болдог. Эдгээр байгууллагыг төрийн болон төрийн бус, ашгийн төлөө болон ашгийн төлөө бус гэж ангилдаг. Компани, нөхөрлөлийн үндсэн үйл ажиллагаа нь ашиг олохын төлөө чиглэдэг бол холбоо, сан нь ашгийн төлөө бус байгууллага юм.

Эдгээр байгууллагуудыг үүсгэн байгуулах, эрхлэн явуулах зэрэг үйл ажиллагааных нь онцлогтой холбоотой асуудлыг тус тусынх нь тусгайлсан хуулиар зохицуулсан байдаг. Хуулийн этгээдийг татан буулгахад нэн тэргүүнд иргэдийн эрх ашгийг хохироолгүй,

өр төлбрийн барагдуулсан эсэхэд анхаарах хэрэгтэй юм. Дараах дарааллаар иргэдийн хохирлыг барагдуулах ёстой.

Үүнд:

1. Нэн тэргүүнд бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгах төлбөр;
2. Тухайн байгууллагыг татан буулгах комиссын зардал;
3. Дампуурах үед нь дахин хөрөнгөжүүлэх зорилгоор байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу гарсан зардал;
4. Хадгаламж эзэмшигчийн мөнгөн хөрөнгө;
5. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын хөлс;
6. Бусад нэхэмжлэл.

2. Итгэлцлэлийн үндэс-гэрээ

*Ирэх зам шулуун бол
Буцаж зам саадгүй*

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх, үүрэг бий болгох, өөрчлөх, дуусгавар болгох талаарх амаар болон бичгээр хийсэн харилцан тохиролцоог гэрээ гэнэ. Хуульд зарим гэрээг заавал бичгээр хийхээр тусгайлан заасан байдаг. Иргэний хуульд гэрээг байгуулсанд автоматаар тооцох үндэслэлийн талаар тусгасан байдаг. Үүнд:

1. эд хөрөнгө шилжүүлснээр гэрээ байгуулахаар хуульд заасан бол гэрээний гол нөхцөлийн талаар талууд тохиролцож, тухайн эд хөрөнгийг шилжүүлснээр;
2. гэрээг бичгээр байгуулахаар хуульд заасан буюу талууд тохиролцсон бол гарын үсгээ зурсан захидал, албан бичиг, телефакс зэрэг баримт бичгийг нэг тал хүлээн авснаар;
3. хариу ирүүлэх хугацаатайгаар илгээсэн гэрээний саналд дурдсан хугацаанд нь зөвшөөрсөн хариу авсан;
4. гэрээний саналыг хариу ирүүлэх хугацаа заалгүй бичгээр илгээсэн тохиолдолд түүнийг зөвшөөрсөн тухай хариуг ердийн боломжит хугацаанд хүлээн авсан;


5. нүүр тулан амаар гаргасан саналд тэр даруй зөвшөөрсөн хариу өгсөн;
6. зөвшөөрсөн хариуг хугацаанд нь илгээсэн боловч уг хариу хожимдож ирсэн учир гэрээг байгуулахгүй гэж нөгөө тал нь хариу илгээсэн талд нэн даруй мэдэгдээгүй бол.

Гэрээ байгуулсан талууд нь эрх ашиг зөрчигдсөн, гэрээгээр тохиролцсон үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон зэрэг тохиолдолд нөгөө талдаа албан ёсоор мэдэгдэн гэрээнээс татгалзах эрхтэй.

Худалдах-худалдан авах гэрээ

Өглөө босоод цайны сүүгээ худалдаж авахаас эхлээд байр орон сууц худалдаж авах хүртэлх байнгын худалдааны харилцаа хүмүүсийн өдөр тутмын амьдралд тохиолдож байдаг. Худалдааны харилцааг зохицуулсан худалдах-худалдан авах гэрээг амаар болон бичгээр байгуулж болно.

Худалдан авагч нь 1. тохиролцсон үнийг төлөх 2. авсан зүйлээ хүлээн авах үүрэг хүлээнэ.



Иргэний хуульд зааснаар эд хөрөнгийг жигнэх, савлах, баглахад гарах зардлыг худалдагч, худалдагчийн байгаа газраас өөр газар руу тээвэрлэх, хүлээн авах, баримт бичиг бүрдүүлэхтэй холбогдсон зардлыг худалдан авагч хариуцна. Гэхдээ талууд гэрээ байгуулахдаа өөр нөхцөлийг тохиролцож болно.



Хэрвээ худалдсан эд хөрөнгө нь гэмтэлтэй, доголтой бол үүнийг арилгах бөгөөд худалдан авагч нь доголдолтой гэдгийг мэдээгүй бол түүнийг арилгуулж, засуулах буюу гэрээгээ цуцалж төлсөн үнээ буцаан авах эрхтэй. Баталгаат хугацаа тогтоосон бол энэ хугацааны дотор, тогтоогоогүй бол 6 сарын дотор доголдлыг арилгахыг шаардаж болно. Хэрвээ гэмтэл доголдол нь худалдан авагчийн өөрийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн, эсвэл хөл хорио гэнэт тогтоох, салхи шуурга дэгдэх, цас, бороо орох зэрэг давагдашгүй хүчин зүйлсийн улмаас бий болсон бол худалдагч хариуцахгүй.

БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

загвар

/огноо/

/үйлдсэн газар/

Гэрчилгээний дугаар.....

Улсын бүртгэлийн дугаар.....

Иргэний хуулийн 243-р зүйлийн 243.1 дэх хэсгийг үндэслэн нэг талаасхаягт оршин суух-ны.....би /цаашид “Худалдагч” гэнэ/, нөгөө талаасхаягт оршин суух-ны...../цаашид “Худалдан авагч” гэнэ/ бид харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээний ерөнхий нөхцөл

Гэрээний нөхцөлийн дагуу Худалдагч нь биет байдлын болон эрхийн доголдолгүйбараа бүтээгдэхүүн, түүнтэй холбоотой баримт бичгийг Худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, Худалдан авагч нь бүтээгдэхүүнийг хүлээн авч төлбөрийг төлөх үүрэг хүлээнэ.

Худалдагчаас шилжүүлж байгаа бүтээгдэхүүн нь...../чанарын гэрчилгээ гэх мэт/-ээр тодорхойлогдоно.

1.3 Бараа бүтээгдэхүүнийг худалдагч тал худалдан авагч талд.....төгрөгөөр худалдах ба төлбөрийгоны.....дугаар сарын-ны өдөр төлж барагдуулна.

1.4 Барааны үнэд...../жигнэх, савлах, тээвэрлэх зэрэг/ хөлс багтана.

Хоёр. Худалдагчийн үүрэг

2.1оны.....сарын.....-ны өдрөөс хэтрүүлэхгүй барааг худалдан авагчид шилжүүлнэ.

2.2 Гэрээний салшгүй хэсэг болох холбогдох бичиг баримтыг худалдан авагчид шилжүүлэн өгнө.

Гурав. Худалдан авагчийн үүрэг

3.1 Худалдагчаас барааг шилжүүлэх хугацааг мэдэгдсэнээс хойш.....оны.....сарын-ны дотор барааг шилжүүлэн авна.

3.2 Барааг хүлээж авахдаа тоо, чанар, иж бүрдэл, холбогдох бичиг баримтыг шалгаж авна.

3.3 Худалдан авсан барааг шалгах болон ашиглах явцад илэрсэн доголдлыг худалдан авагчид мэдэгдэнэ.

3.4 Худалдан авсан барааны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулна.

Дөрөв. Тооцоо хийх журам

- 4.1 Худалдан авагч барааны төлбөрийг...../бэлнээр, бэлэн бусаар/ худалдан авагчид шилжүүлнэ.
- 4.2 Худалдсан барааг худалдан авагчид шилжүүлснээр бараа устаж, гэмтсэн эрсдэл худалдан авагчид шилжинэ.

Зургаа. Маргааныг шийдвэрлэх

Гэрээнд холбогдох маргааныг талууд харилцан тохиоролцох замаар шийдвэрлэнэ. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй маргааныг шүүхээр /арбитр/ шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэрээний үйлчлэх хугацаа

- 9.1 Гэрээ ньоныдугаар сарын-ны өдрөөс.....оны сарын.....-ны өдөр хүртэл хүчинтэй.
- 9.2 Гэрээний үйлчлэх хугацааг гэрээний хоёр тал бичгээр харилцан тохиролцож сунгаж болно.

Найм. Бусад заалт

- 10.1 Гэрээг 3 хувь үйлдэж, гэрээний хоёр тал тус бүр нэг нэг хувийг, нотариатч 1 хувийг авна.
- 10.2 Талууд гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

Талуудын хаяг:

Худалдагч тал:

Регистрийн дугаар №:

Иргэний үнэмлэхийн дугаар:

Оршин сууж буй хаяг:

Холбоо барих утас:

Худалдан авагч тал:

Регистрийн дугаар №:

Иргэний үнэмлэхийн дугаар:

Оршин сууж буй хаяг:

Холбоо барих утас:

Гэрээ байгуулсан:

Худалдагч:

.....-ны

.....

...../гарын үсэг/

Худалдан авагч:

.....-ны

.....

...../гарын үсэг/

Гэрээг гэрчилсэн:

Нотариатч:.....

Тамга

Зээлийн гэрээ. Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд нь буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ. Тухайн зээлдэж байгаа зүйлийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр гэрээ байгуулагдсанд тооцно. Зээлийн гэрээг амаар байгуулж болох хэдий ч хүүтэй зээл бол гэрээгээ заавал бичгээр хийх шаардлагатай.

Зээлдэгч нь зээлээ гэрээгээр тогтоосон хугацаандаа буцаан өгөх үүрэгтэй. Ийм хугацаа тогтоогоогүй бол зээлдэгчийн шаардсанаар буцаан өгөх ёстой. Иргэний хуульд зааснаар авсан зээлээ тохирсон хугацаанаасаа өмнө буцаан өгч болно. Харин хүүтэй зээл бол энэ тохиолдолд зээлдүүлэгчтэй урьдчилан тохирч, зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Тохиолдол:

Оюутан Сүрэн байрныхаа мөнгийг төлөх хугацаа нь болсон тул монетан ээмэг бөгөөд барьцаалан зээлдэх газарт 30 хоногийн хугацаатай зээлжээ. Сар гаруй хугацаа өнгөрсний дараа Сүрэн эд зүйлээ авахаар иртэл тэд хугацаандаа ирж аваагүй тул зарсан гэжээ. Иймд Сүрэн Иргэний хууль уншиж судлан дараах хариултыг олжээ.

Зээлдэгч нь зээлээ хугацаанд нь төлөөгүй бол барьцаалагдсан хөрөнгийг худалдах тухайгаа зээлдэгчид бичгээр мэдэгдэх үүргийг барьцаалан зээлдэх газар хүлээдэг. Ингэж мэдэгдсэнээс хойш 10 хоногийн дотор зээлээ төлөөгүй бол эд хөрөнгийг худалдаж болно. Худалдсан зүйлийн үнээс зээлийг хүүгийн хамт суутгаж үлдсэн мөнгийг зээлдэгчид буцааж өгнө. Барьцаалан зээлдэх газар нь барьцааны зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангах үүрэгтэй.

Барьцаалан зээлдэх газар нь хөдлөх эд хөрөнгийг л барьцаалах эрхтэй бөгөөд газар гэх мэтийн үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалж болохгүй. Барьцаалан зээлэх газраас зээл авч байгаа тохиолдолд заавал бичгээр гэрээ хийх ёстой бөгөөд хүүг талууд харилцан тохиролцсон байна. Бичгээр хийгээгүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ

Загвар

.....оны дугаар

... сарын ...-ны өдөр

.....

/үйлдсэн газар/

Нэг талаас хаягт амьдрах. тоот иргэний үнэмлэх, дугаар бүхий регистртэй овогтой. би, нөгөө талаас хаягт амьдрах. тоот иргэний үнэмлэх, дугаар бүхий регистртэй овогтой. бид нар харилцан тохиролцож дараах агуулга бүхий гэрээ байгуулж байна.

1. Зээлдүүлэгч би, зээлдэгч -д төгрөг / доллар, юань, рубль/-ийг /доогуур нь зурах/. оны сарын -ны өдрөөс оны сарын -ны өдрийг хүртэл /хүүтэй, хүүгүй/ зээлдүүлэх, зээлдэгч нь заасан хугацаанд дурдсан мөнгийг эргүүлэн төлөх үүрэг хүлээнэ.
2. Зээлдэгч би өөрийн өмчлөлийн дараах зүйлүүдийг барьцаанд тавьж байна.
3. Зээлдэгч зээлдүүлэгчид гэрээнд заасан мөнгийг бүхлээр нь буюу хэсэгчлэн төлж болно. Гэхдээ ямар ч тохиолдолд зээлсэн мөнгийг гэрээнд тохиролцсон оны ... сарын ... -ны дотор төлсөн байна. Зээлийг бүхлээр нь буюу хэсэгчлэн төлсөн явдал зээлдүүлэгчийн гарын үсгээр баталгаажна.
4. Зээлдэгч нь зээлийг эргүүлж төлөх хугацаагаас эерхвэл зээлдүүлэгчид хугацаандаа төлөөгүй мөнгөний дүнгийн хувиар хугацаа хэтэрсэн хоног тутам алданги тооцно. Үүнээс гадна зээлдүүлэгч нь зээлдэгчийн барьцаа болгон тавьсан эд зүйлээс учирсан хохирлоо арилгуулна.
5. Энэхүү гэрээ нь зээлдүүлэгчээс зээлдэгчид бодитойгоор мөнгийг гардуулсан үеэс хүчин төгөлдөр болж, үүргээ бодитойгоор биелүүлсэн үеэс дуусгавар болно.
6. Барьцааны эд зүйлийг зээлдүүлэгчид гэрээний хугацаанд шилжүүлэх эсэх талаар бичих

Гэрээ байгуулсан:

.....

.....

Талуудын хувийн байдал, эрхийн чадамжтай болох нь тогтоогдсон.

Баталгааны дардас

Гэрээг уншиж танилцав.

Нотариатч...../нэр/

Орон сууц хөлслөх гэрээ. Орон сууц хөлслөхтэй холбогдсон маргаан иргэдийн дунд их байдаг. Энэ маргаанаас урьдчилан сэргийлж, эрхээ хамгаалах үүднээс орон сууц хөлслүүлэгч, хөлслөгчийн хооронд гэрээ байгуулах нь их ач холбогдолтой юм. Уг гэрээгээр хөлслүүлэгч нь байшин, өрөөг хөлслөгчийн эзэмшил ашиглалтад шилжүүлэх, хөлслөгч нь орон сууцыг зориулалтын дагуу ашиглах, бүрэн бүтэн байдлыг нь хангах, хэлэлцэн тохирсон хөлсийг төлөх үүргийг тус тус хүлээнэ. Хөлслүүлэгч нь орон сууцандаа засвар үйлчилгээ хийхдээ хөлслөгчид урьдчилан мэдэгдэнэ.

Тухайн орон сууцыг сүүлийн гурван жил тасралтгүй эзэмшиж үүргээ зохих ёсоор биелүүлж байсан хөлслөгч нь уг орон сууцыг тэргүүн ээлжинд худалдан авах буюу орон сууц хөлслөх шинэ гэрээг тэргүүн ээлжинд байгуулах давуу эрхтэй.

Хэрвээ хөлслүүлэгч зөвшөөрвөл хөлслөгч нь хөлслөж байгаа орон сууцаа өөр 3 дахь хүнд дамжуулан хөлслөж болно. Энэ тохиолдолд хөлслүүлэгч нь орон сууцны талбайн ачаалал хэт ихэссэн, дамжуулан хөлслөгчийн хувийн байдлаас болсон зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай үед л дамжуулан хөлслөхөөс татгалзах эрхтэй. Хөлслөгч нь үнэ хөлсгүйгээр, гэрээ байгуулахгүйгээр хөлслөж байгаа орон сууцандаа түр суугчийг суулгаж болно. Хөлслөгчтэй хамт амьдардаг гэр бүлийн гишүүд нь хөлслөгчийн нэгэн адил эрх, үүрэгтэй.

Ажил гүйцэтгэх гэрээ. Иргэний хуулийн 343 дүгээр зүйлд зааснаар ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

Ажлын хөлсний хэмжээ, төлөх арга хэлбэр, хугацааг гэрээ байгуулж байгаа талууд харилцан тохиролцон тогтооно. Хэрвээ хөлсөө урьдчилан тохиролцоогүй бол тухайн төрлийн ажлыг гүйцэтгэхэд мөрддөг жишиг үнэлгээний жагсаалтад тусгасан үнээр эсвэл тухайн үеийн зах зээлийн дундаж үнэлгээгээр бодож хөлсийг төлнө. Хөлсийг захиалсан ажлыг бүрэн дуусгаж, хүлээлгэн өгснөөр төлнө. Гэхдээ үүнээс өөрөөр тохиролцох эрх нь талуудад чөлөөтэй бий.

Ажил гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажил нь чанарын шаардлага хангахгүй, доголдолтой байвал захиалагч нь ажил хүлээн авснаас

хойш 6 сарын дотор гомдол гаргаж болно. Шууд илэрч мэдэгдэх боломжгүй дутагдал байсан бол 1 жилийн дотор гомдол гаргах эрхтэй. Байшин барилгын талаарх гомдлыг 3 жилийн дотор гаргана.

Иргэний хуульд ажил гүйцэтгэгч болон захиалагчийн хүлээх үүргийг заасан байдаг. Талууд гэрээ байгуулахдаа хуульд зааснаас гадна бусад нарийвчилсан эрх, үүргийн талаар тусгаж болно.





3. Гэм хор учруулснаас үүсэх үүрэг

*Гэм нь өмнөө
Гэмшил нь хойноо*

Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй /Иргэний хуулийн 497.1/.


Гэм хор нь бусдыг доромжлон гутаах, эд хөрөнгийг гэмтээх, устгах, эрүүл мэндийг бусниулах зэрэг янз бүрийн идэвхтэй ба идэвхгүй үйлдлээр бий болдог.

Гэм хийсэн бол хариуцлага хүлээх нь зүй ёсны асуудал тул бусдад гэм хор учруулсан этгээд үүнийгээ арилгах үүрэгтэй юм. Арилгахдаа засаж янзлах, өмнөх байдлаар нь сэргээх, хохирлыг эд хөрөнгө, мөнгөөр барагдуулах зэрэг аргыг хэрэглэдэг.

Хуулийн этгээдийн учруулсан гэм хор. Хуулийн этгээдийн бусдад учруулсан гэм хор гэдэгт тухайн байгууллага өөрөө чанаргүй бараа худалдаалан хэрэглэгчийг хохироосон, байгаль орчныг бохирдуулсан зэрэг буруутай үйл ажиллагааны улмаас үүссэн гэм

хороос гадна тухайн байгууллагад ажиллагсдын учруулсан гэм хор орно. Тухайн байгууллагын ажилтан хүлээсэн ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гэм хор бусдад учруулсан бол ажил олгогч байгууллага хохирлыг арилгах үүрэгтэй байна. Төрийн байгууллагын албан хаагч албаны ажлаа хийх үедээ буруу үйл ажиллагаа явуулан бусдад гэм хор учруулбал ажилладаг байгууллага болон төр гэм хорыг хариуцна.

Амьтны учруулсан гэм хор. Хүний амь нас, эрүүл мэндэд амьтан гэм хор учруулсан бол хохирлыг түүнийг өмчлөгч, эзэмшигч хариуцан арилгана. Гэрийн тэжээвэр амьтан болон мэргэжлийн үйл ажиллагаанд ашигладаг амьтны /цагдаагийн нохой, циркийн амьтан гэх мэт/ учруулсан гэм хор нь түүний эзний санаатай буюу илт болгоомжгүй үйлдэлтэй холбоогүй бол гэм хорыг хариуцахгүй. Тухайн амьтны эзэн нь анхааруулга, сануулга өгөх, хараа хяналтаа сайжруулах зэргээр бусдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг байнга авч байх хэрэгтэй. Энэ үүргээ биелүүлээгүйн улмаас тэжээвэр амьтан нь бусдад хохирол учруулбал уг хохирлыг барагдуулах үүрэгтэй.



Бусдын амь нас, эрүүл мэндэд учирсан гэм хор. Хүний бие махбодийг гэмтээх, хөгжлийн бэрхшээлтэй болгох, биеийн болон сэтгэл зүйн зовиур шаналгаа үүсгэх зэрэг янз бүрийн хэлбэрээр бусдын эрүүл мэндэд гэм хор учруулсан буруутай этгээд

нь хохирогчийн хохирлыг барагдуулах ёстой. Гэм хорын улмаас хохирогч хөдөлмөрийн чадвараа алдан дутуу авсан цалин хөлс, бусад орлого, түүнчлэн нэмэгдэл хоол хэрэглэх, хиймэл эрхтэн хийлгэх, сувиллын газар сувилуулах зэрэг эмчлүүлэхэд гарсан бүх зардлыг гэм хор учруулагч хариуцна. Иргэний хуульд зааснаар гэм хор учрах үед нь хохирогч нь тогтсон тодорхой орлого, цалин хөлсгүй байсан бол хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээний нөхөн төлбөр шаардах эрхтэй.

Гэм хорын улмаас хохирогч нас барсан бол гэм хорыг арилгахыг өв залгамжлагч нь шаардах эрхтэй бөгөөд дараах журмаар арилгана. Хохирогчийн нас барах хүртэл эмчилж байсан эмчилгээний болон оршуулахтай холбогдсон зайлшгүй зардлыг /хайрцаг сав, будаалга, буяны юм гэх мэт/ төлүүлэхээр өв залгамжлагч нь шаардах эрхтэй.

Гэм хор учруулсны төлбөрийг нас барсан хохирогчийн асрамжид байсан буюу нас барах үед түүнээс тэтгэвэр авах эрхтэй байсан хөдөлмөрийн чадваргүй этгээд, хохирогчийг нас барсны дараа төрсөн хүүхэд тус тус, түүнчлэн нас барагчийн найман нас хүрээгүй хүүхэд, дүү, ачийг асран хүмүүжүүлж байгаа байнгын цалин хөлс орлогогүй эцэг, эх, нөхөр /эхнэр/-ийн аль нэг нь авах эрхтэй.

Төлбөр гаргуулах хэмжээг тогтоохдоо нас барагчид өөрт нь болон түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадвартай бөгөөд төлбөр авах эрхгүй этгээдэд оногдох хэсгийг хасаад нас барагчийн сарын цалин хөлс, орлогын дунджаар тогтооно. Түүнчлэн төлбөр авагч тус бүрт тогтоосон төлбөрийн хэмжээнээс тэжээгчээ алдсаны тэтгэврийг хасна.

Гэм хор учруулсны төлбөрийг дараах хугацаанд нөхөн төлнө.

- Бага насны буюу насанд хүрээгүй иргэнд 16 нас хүртэл, суралцаж байгаа бол 18 нас хүртэл нь.
- 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэйд бүх насаар нь.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөдөлмөрийн чадвар алдалт тогтоогдсон хугацаанд.
- Нас барагчийн 8 нас хүрээгүй хүүхэд, дүү, ачийг асран хүмүүжүүлж байгаа байнгын цалин, хөлс, орлогогүй нас барагчийн эцэг, эх, эхнэр, нөхрийн аль нэгэнд түүний нас, хөдөлмөрийн чадварыг харгалзахгүйгээр уг хүүхдийг 8 нас хүртэл.

4. Өв залгамжлал

Мөрийн хэлжээ хууль *Мөрлийн хэлжээ нагац*

Эд хөрөнгө болон эрхээ өвлүүлэн өгч байгаа талыг өвлүүлэгч, хүлээн авагч талыг өвлөгч гэнэ. Өвлөгч өвлөн авсан өвийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг хүлээнэ. Өвлүүлэгч нас барсан өдрөөс эхлэн өв нээгдэнэ. Өвлөгч нь өвлүүлэгчийг болон өв залгамжлах ёстой байсан бусад хүнийг санаатайгаар алсан бол өвлөх эрхээ алдана. Энэ нь шунахай зорилготой эрүүгийн гэмт хэрэг юм. Өв залгамжлагч байхгүй, эсвэл бүгд өв залгамжлахаас татгалзсан, өвлөх эрхээ алдсан бол эд хөрөнгийг төр авна.

Өв залгамжлал нь хуульд зааснаар болон гэрээслэлээр өвлөх гэсэн 2 төрөлтэй.

Хуульд зааснаар өвлөх. Өв хөрөнгийг хэн, хэн нэн тэргүүнд өвлөх эрхтэй болохыг хуулиар зааж өгснийг “хууль ёсны өвлөгч” гэдэг. Өвлүүлэгч эд хөрөнгөө гэрээслээгүй эсвэл гэрээслэлээр өвлөгч өвийг хүлээн авахаас татгалзсан зэрэг тохиолдолд хуульд заасан этгээдүүд өв хөрөнгийг өвлөн авдаг. Өвлүүлэгчийн гэрийн эд хогшил нь нас барах үед нь түүнтэй хамт амьдарч байсан хууль ёсны өвлөгчид шууд, тэргүүн ээлжинд өвлөгддөг онцлогтой. Хуульд заасан өв залгамжлалыг зөвхөн өвлүүлэгчийн гэрээслэлээр өөрчилнө. Хууль ёсны өвлөгчдийн өв залгамжлах эрхээ хэрэгжүүлэх эрэмбийг доорх хүснэгтээс үзнэ үү.

№	Хэзээ	Хэн	
1	Тэргүүн ээлжинд	Нөхөр/эхнэр	Өвлүүлэгчийг нас барахаас өмнө нэгээс доошгүй жилийн хугацаанд асрамжинд нь байсан хөдөлмөрийн чадваргүй иргэн
		Үр хүүхэд	
		Эцэг/эх	
2	Хоёр дахь ээлжинд	Өвөө/эмээ	
		Ах/эгч, дүүс	
		Ач/зээ	
3	Гурав дахь ээлжинд	Ачинцар/зээнцэр	

Гэрээслэлээр өвлөх. Өвлүүлэгч нь өвлөх эрхтэй болон эрхгүй нэг буюу хэд хэдэн иргэн, мөн төр, байгууллагад өв хөрөнгөө бүхэлд нь буюу зарим хэсгийг нь сайн дураараа гэрээслэн өвлүүлж болно. Хэдийгээр гэрээслэгч нь бүх өмч хөрөнгөө бүхэлд нь гэрээслэлээр өвлүүлэх эрхтэй ч түүний насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй эсвэл нас барсан хойно нь төрсөн хүүхэд, асрамжид нь байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, эцэг, эх зэрэг хууль ёсны бусад өвлөгчдөд өвлөгдвөл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлдэг журамтай.

Хүчин төгөлдөр гэрээслэл нь бичгээр үйлдэгдэж, нотариатаар гэрчлэгдсэн байх шаардлагатай. Нотариатч байхгүй бол баг, сумын Засаг даргаар гэрчлүүлнэ. Мөн цэргийн албан хаагчийн гэрээслэлийг цэргийн ангийн удирдлага, хоригдож байгаа хүнийхийг хорих ангийн дарга, хөлөг онгоцны зорчигч, багийн гишүүдийнхийг онгоцны ахмад нь гэрчилж болно.

Гэрээслэгч нь гэрээслэлээ өөрчлөх буюу цуцлах эрхтэй. Гэрээслэлээ цуцалсан тухай баримт бичиг үйлдэн нотариатаар гэрчлүүлнэ.

Эд хөрөнгийг өвлөгч хүлээн авснаар өв залгамжлалыг гүйцэтгэсэнд тооцно. Өвлөгч өвлөх эрхээ өвлөвөл зохих бусад этгээдэд шилжүүлэхээр зааж, өв хүлээн авахаас татгалзах эрхтэй.

Өвлүүлэгчийг нас барах хүртэл түүнтэй хамт амьдарч байсан өвлөгч нь өв нээгдсэнээс хойш гурван сарын дотор өв хүлээн авахаас татгалзсан тухайгаа нотариат буюу нотариат байхгүй газар баг, сумын Засаг даргад мэдэгдээгүй бол уг өвийг хүлээн авсан гэж үзнэ.

Дээрхээс бусад өвлөгчид нь өв нээгдсэнээс хойш нэг жилийн дотор өвлөгдсөн эд хөрөнгийг эзэмшсэн, эсвэл өвлөх эрхийн гэрчилгээ олгохыг хүссэн өргөдөл гаргасан байвал өвийг хүлээн авсан гэж үздэг. Эдгээр хугацаанд эд хөрөнгийг хүлээн аваагүй, эсвэл хүсэлтээ гаргаагүй бол өвлөхөөс татгалзсан гэж үзнэ.

ГЭРЭЭСЛЭЛИЙН ГЭРЭЭ

Загвар

_____ Дугаар _____
/он, сар, өдөр/ _____ /үйлдсэн газар/

Иргэнийхуулийн523дугаарзүйлийн523.1дэххэсгийгүндэслэн.....
хаягт оршин суугч _____ тоот иргэний үнэмлэх _____ регистртэй
_____ /эцгийн нэр, нэр/ _____ би энэхүү гэрээслэлээр дараах
даалгаврыг өгч байна.

1. _____ хаягт байгаа _____ төгрөгийн үнэ бүхий _____
_____ /гэрээслэж буй эд хөрөнгийн нэр, тоо ширхэг/
_____ эд хөрөнгийг би _____ хаягт оршин
суугч _____
_____ /өө хүлээн авагчдын эцгийн нэр, нэр, иргэний үнэмлэх, регистрын дугаар/
_____ -д гэрээслэж байна.
2. Би Монгол Улсын Иргэний хуулийн 522, 523, 524, 525 дугаар зүйлийг
уншиж танилцсан болно.
3. Гэрээслэлийг хоёр хувь үйлдэж, нэг хувийг нотариатч хадгалж, нэг хувийг
гэрээслэгч _____ -д олгов.
_____ /эцгийн нэр, нэр/

_____ /гэрээслэгчийн гарын үсэг/

_____ /аймаг, дүүрэг/-ийн нотариатч _____ би дээрх гэрээслэлд зурсан
иргэн _____ -ны гарын үсгийн үнэн зөвийг гэрчилж байна.
_____ /эцгийн нэр, нэр/

Нотариатч гэрээслэлийн эхийг уншиж сонсгов.
Гэрээслэгчийн хувийн байдал эрхийн чадамжтай болох нь тогтоогдсон.
Гэрчлүүлсэн гэрээслэлдээ өөрчлөлт оруулах эсхүл шинээр гэрээслэл үйлдэх
тухай шийдвэр гаргаж гэрээслэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн өөрчлөх,
татгалзах эрхтэйг танилцуулав.

Үйлчилгээний хөлсөнд _____ төгрөг хураав.
Тамга _____ Нотариатч _____ /гарын үсэг/

5. Шүүхээр эрхээ хамгаалуулах нь

*Маазад гүн санаа бий
Хуульд гүн уугир бий*

Иргэний эрх зүйн харилцаанд оролцож байгаа хэн бүхэн өөрийнх нь хууль ёсны эрх зөрчигдсөн гэж үзвэл эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхтэй бөгөөд ийнхүү бичгээр гаргасан өргөдлийг “нэхэмжлэл” гэнэ.

Нэхэмжлэгч-эрх ашиг нь зөрчигдсөн гэж үзэн шүүхэд нэхэмжлэл гаргагч тал.

Хариуцагч-нэхэмжлэгчийн эрх ашгийг хохироосон хэмээн нэхэмжлэлд хариуцагчаар дурьдагдсан тал.

Нэхэмжлэлд заавал тусгах зүйлсийг хуульд тусгайлан зааж өгсөн байдаг. Үүнд:

- нэхэмжлэгчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;
- нэхэмжлэлийг ямар шүүхэд гаргаж байгаа;
- хариуцагчийн овог, эцгийн нэр, нэр, хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хаяг, оршин байгаа газар;
- нэхэмжлэлийн үндэслэл, шаардлага, түүнийг нотлох баримт;
- нэхэмжлэлийн үнэ;
- хавсаргасан баримт бичгийн жагсаалт.

Нэхэмжлэлд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, эсхүл уг хураамжаас чөлөөлүүлэх тухай хүсэлт, хэрэв нэхэмжлэлийг төлөөлөгч гаргасан бол итгэмжлэлийг мөн хавсаргана.

Нэхэмжлэлдээ хариуцагчаас юуг, хичнээн төгрөгний ямар үнийн дүнтэй зүйлийг нэхэмжлэж байгаагаа тодорхой тусгах хэрэгтэй. Нэхэмжлэлийн үнийг хэрхэн тодорхойлон тооцохыг хуульд дараах байдлаар заажээ. Үүнд:

1. мөнгө нэхэмжилсэн бол мөнгөний дүнгээр;

2. эд хөрөнгө нэхэмжилсэн бол эд хөрөнгийн тухайн үеийн зах зээлийн ханшаар;
3. бие даасан хэд хэдэн шаардлагыг нэг нэхэмжлэлд бичсэн бол бүх шаардлагын нийлбэр үнийн дүнгээр;
4. гэрээ, хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулахаар нэхэмжилсэн бол тухайн гэрээ, хэлцлийн үнийн дүнгээр;
5. тогтмол хугацаанд төлөгдөх тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, хохирол, нөхөн төлбөр шаардсан нэхэмжлэлд тэдгээрийн нэг жилийн хугацаанд төлбөл зохих дүнгээр;
6. үл хөдлөх эд хөрөнгө нэхэмжилсэн бол Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газарт бүртгүүлсэн үнээр;
7. нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлыг нэхэмжлэлдээ тодорхойлсон үнээр;
8. үнэт цаастай холбогдох нэхэмжлэлд хөрөнгийн биржийн тухайн үеийн ханшаар;
9. тусгай зөвшөөрөл, тендертэй холбоотой нэхэмжлэлд тэдгээрийн хураамжийн дүнгээр тодорхойлохоор тус тус заасан.

Нэхэмжлэлээ хаанахын шүүхэд гаргах вэ?

Нэхэмжлэлийг тухайн хариуцагчийн оршин суугаа газрын шүүхэд гаргана. Хэрвээ өөр, өөр газар амьдардаг олон хариуцагчтай нэхэмжлэл гаргах бол тэдгээр хариуцагчдын аль нэгнийх нь оршин суугаа газрын шүүхэд гаргана. Хариуцагчийг хаана оршин суудгийг мэдэхгүй бол түүний эд хөрөнгө нь байгаа газрын, үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой нэхэмжлэлийг тухайн хөрөнгө байгаа газрыг харьяалах шүүхэд хандан гаргана. Сураггүй алга болсонд тооцуулах, нас тогтоох, хүүхдийн эцэг, эхийг тогтоох гэх мэтийн эрх зүйн ач холбогдол бүхий үйл явдлыг тогтоолгох нэхэмжлэлийг өөрийн оршин суугаа газрын, эсвэл үйл явдал болсон газрын шүүхэд тус тус гаргана.

Нэхэмжлэлийг гаргаж байгаа шүүхийнхээ шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргад хүлээлгэн өгч бүртгүүлнэ. Доор дурдсан тохиолдолд шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж болно.

- хэргийн болон шүүхийн харьяаллын биш;
- шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлүүлэх талаар хуульд заасан журмыг нэхэмжлэгч зөрчсөн ба энэ журмыг хэрэглэх боломжтой байвал;
- нэхэмжлэгч нь эрх зүйн бүрэн чадамжгүй этгээд байвал;
- нэхэмжлэгчийг төлөөлөх бүрэн эрхгүй этгээд нэхэмжлэл гаргасан;
- нэхэмжлэлд дурдсан үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр буюу шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж байгаа;
- зохигчийн маргаж байгаа зүйл ба түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа;
- уг нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа;
- хариуцагчийн хаяг тодорхойгүй;
- зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй;
- нэхэмжлэлд заавал тусгах ёстой зүйлсийг тусгаагүй, шаардлагыг хангаагүй байвал.



VIII. ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

*Хууль дэвтрээс заасныг сурт
Хуульдгын ргнээс сургаалыг авт
Хошоо олныг рлгэрлэж яв
/Ардын аман зохиолч, хуульч Сандаг/*

Энэ бүлэгт иргэд цагдаагийн байгууллагатай хэрхэн хамтран ажиллаж гэмт хэргээс урьдчилан сэргийлж, амар тайван, аюулгүй орчинд аж төрөх талаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас эрхлэн гаргасан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” (2011 он) гарын авлагаас хэсэгчлэн авснаа толилуулж байна.

Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

Бусдын эд хөрөнгийг хулгайлах нь хүний хүч, хөдөлмөрийг үл хүндэтгэсэн үйлдэл бөгөөд нууцаар мэдэгдэхгүй хийдгээрээ илүү хохирол бий болгодог.

Орон байрны хулгайгаас урьдчилан сэргийлэхийн тулд:

- ахуйн болон аж ахуйн хүрээнд гарч болзошгүй хулгайгаас иргэдийг сэрэмжлүүлэх;
- гэртээ байхдаа болон гадагш гарахдаа хаалга, цонхоо түгжиж байх;
- цонхны шилийг гаднаас биш дотор талаас нь хийж сайтар тогтоож бэхлэх;
- олон нийтийн газар буюу дэлгүүр, зах, тээврийн хэрэгслээр зорчихдоо гадна талын халаасандаа мөнгө, үнэт зүйлсээ хийхгүй байхыг хичээх;
- эзэнгүй үедээ хөрш айлдаа гэрээ захиx, удаан хугацаагаар

явах үедээ үнэт эдлэл, их хэмжээний бэлэн мөнгөө найдвартай газар хадгалуулах;

- танихгүй хүн, сэжигтэй гэж үзсэн хүнээ гэртээ ганцааранг нь үлдээхгүй байх;
- өөрийн эд зүйлсийнхээ загвар, марк, үйлдвэрийн хаяг, өнгө, онцлогийг тэмдэглэн авах нь болзошгүй тохиолдолд эргүүлэн олоход тус болохыг санах хэрэгтэй.

Машины хулгайгаас хэрхэн сэргийлэх вэ?

Иргэдийг машинаа хулгайд алдахгүй байхыг сэрэмжлүүлэх үүднээс дараах санамжийг анхааруулъя.

- Машинаа түр хугацаагаар орхих байсан ч заавал түгжих, цонхоо сайн хаах;
- Машинтавих зөвшөөрөл бүхий гэрэлтэй, харуулхамгаалалттай зогсоолд тавих;
- Хулгайд өртөхөөс сэргийлсэн дохиолол, төхөөрөмж тавих.

Дээрэм, булаалтын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

Дээрэм, булаалт нь хүн цөөн явдаг, харанхуй зам, гудамжинд ихэвчлэн гардаг. Үүнд эмэгтэйчүүд, өндөр настан, хүүхэд өртөх магадлал өндөр тул анхаарал болгоомжтой байх нь чухал.

Анхааралтай байх асуудлууд:

- хүн цөөн явдаг газраар явахгүй байх;
- араас мотоцикл, дугуй, машины ирж буйг сонсвол эргэн харж магадлах;
- гар цүнх гэх мэт авч яваа зүйлээ тээврийн хэрэгсэл зөрж өнгөрөх талын эсрэг талдаа барих, мөн цээжээрээ оруулан үүрэх.



Хэрэв юмаа булаалгавал яах вэ?

Нэн даруй чанга дуу гаргаж, хүмүүсийн анхаарлыг татах хэрэгтэй. Гэмт этгээдийн гадаад байдлыг болон унаж яваа машины дугаарыг цээжилж, энэ талаарх мэдээллийг цагдаад өгч, хэрэв алдсан зүйлд тань банкны карт байсан бол банк руу яаралтай мэдээлэх шаардлагатай.

Бага насны хүүхдүүд гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох магадлал өндөр байдаг. Тийм учраас бага насны хүүхдийг хамгаалах үүднээс гэмт халдлагаас урьдчилан сэргийлж, хамгаалах мэдлэгийг зааж өгөх хэрэгтэй.

Авах арга хэмжээ:

- өдөр тутам хүүхдэд гэмт халдлагад өртөхгүй байх талаар байнга сануулж байх;
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор шүгэл, хонх зэргийг биед нь авч явуулах;
- цагдаагийн хүүхдийн тасгийн шуурхай дуудлага хүлээн авах утасны дугаарыг хүүхдэд цээжлүүлэх;
- дээрэм булаалт гарах өндөр магадлалтай газрууд, харанхуй гудамжийг хяналтандаа авах.

Эдгээр болон бусад төрлийн гэм хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд, олон нийтээрээ цагдаагийн байгууллагатай байнга хамтран ажиллаж, харилцан бие биендээ туслаж ажиллах нь зүйтэй юм. Орон нутгийн засаг захиргаа, байгууллага, цагдаа, иргэд хамтран ажилласнаар тухайн орон нутагтаа аюулгүй, амар тайван амьдрах орчин нөхцөлийг бий болгохуйц чадавхийг бүрдүүлнэ. Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааг зохион байгуулснаар дараах үр дүн гарна. Үүнд:

1. **Гэмт хэрэг, зөрчил буурна.** Аюулгүй, амар тайван амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө орон нутгийн хэмжээнд хамтран ажилласнаар гэмт хэрэг, зөрчил гаргагч этгээдийн орон зайг хязгаарлаж, иргэд, оршин суугчид элдэв хэрэгт өртөхөөс сэргийлэн хамгаалж чадна.
2. **Иргэдийн ухамсар дээшилнэ.** Орон нутгийн иргэдийн хамтач, нийтэч байдал идэвхжин сэргэж, өөрсдийн санаачлагаар олон төрлийн үйл ажиллагааг зохион байгуулах чадавхи бүрдэнэ.
3. **Хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшилд сайн нөлөө үзүүлнэ.** Гэр бүл, сургууль төдийгүй орон нутгийн иргэд хүүхэд залуучуудыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх асуудалд анхаарлаа хандуулснаар тэдний хүмүүжил төлөвшилд сайнаар нөлөөлөх боломж бүрдэнэ.
4. **Орчны ариун цэвэр, тохижилт сайжран ая тухтай амьдрах орчин нөхцөл бүрдэнэ.** Тухайн орон нутгаараа эмх замбараагүй, бохир заваан байдлыг арилгах, хог хаягдал, орчны эрүүл ахуйд анхааран ногоон байгууламжийг бий болгох зэргээр амьдрах орчин нөхцөлийг сайжруулах үйл ажиллагааг явуулах нь гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд нэмэр тус болно.

Иргэдийн санаачлагын бүлэг

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх иргэдийн санаачлагын бүлэг нь олон нийт-цагдаа, түншлэгч байгууллагуудын дунд гүүр болж, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх иргэдийн санаачлагын бүлгийн үйл ажиллагаа нь орон нутаг бүрийн онцлогоос хамаарч

харилцан адилгүй байж болно. Тэдний үйл ажиллагаа нь орон нутгийн нөхцөл байдлыг, түүнд учирч буй эрсдлийг үнэлэн, авах арга хэмжээгээ сонгох, түүндээ дүн шинжилгээ хийх, иргэдийн дунд чөлөөт ярилцлага, хурал зохион байгуулж тэд нараас гарсан саналд тулгуурлан үйл ажиллагаагаа төлөвлөх, гудамж талбай, нийтийн эзэмшлийн газарт мэдээллийн самбар байрлуулж өөрсдийн хийж буй үйл ажиллагаагаа таниулах, иргэдийг үйл ажиллагаандаа татан оролцуулахад түлхүү чиглэгдэнэ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдийн санаачлагын бүлэг нь үйл ажиллагаа явуулж эхлэхийн өмнө дараах асуудлыг анхаарах хэрэгтэй.

- Бүлгийн гишүүд нэгдсэн нэг ойлголттой байх;
- Сайн дурын үндсэн дээр нэгдэх;
- Аюулгүй байдлаа өөрсдөө хангахуйц чадавхийг эзэмших;
- Хүлээцтэй хандах;
- Хувь хүний нэр төрд халдахгүй байх;
- Орон нутгийн нөхцөл байдлыг мэдэж авах;
- Хамтран ажиллах;
- Бүлгийн гишүүдийг чадавхижуулах.

